



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 09 дүгээр сарын 04
№33 (1428)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

312.	Хөдөө аж ахуйн тухай	2496
313.	Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай	2520
314.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2621
315.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2622
316.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2624
317.	Дампуурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2626
318.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2627
319.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	2631
320.	Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2632
321.	Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2633
322.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2635
323.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2636



324.	Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2638
325.	Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2639
326.	Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай	2641
327.	Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай	2642
328.	Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2644
329.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2645
330.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2654
331.	Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2656
332.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2658
333.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай	2660
334.	Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр соёрхон батлах тухай	2661
335.	Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай	2662
336.	Зээлийн болон төслийн хэлэлцээр соёрхон батлах тухай	2663

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|------|
| 337. | Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 45 | 2664 |
| 338. | Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай | Дугаар 57 | 2666 |
| 339. | Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай | Дугаар 58 | 2673 |

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- | | | | |
|------|---|--|------|
| 340. | Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр | | 2681 |
| 341. | Монгол Улс болон Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээр (Тогтвортой эрчим хүчний шилжилтийг түргэсгэх зорилго бүхий Олон шатлалт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих Эрчим хүч-4 төсөл) | | 2689 |
| 342. | Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хооронд байгуулсан “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээр | | 2708 |

ᠨᠠᠭᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠨᠠᠭᠠᠨᠠᠨᠠᠨ ᠮᠤ ᠰᠤᠨ	ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ
ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠮᠤ ᠰᠤᠨ	ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ
ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠮᠤ ᠰᠤᠨ	ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ
ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠮᠤ ᠰᠤᠨ	ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ
ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠮᠤ ᠰᠤᠨ	ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ
ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠮᠤ ᠰᠤᠨ	ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ
ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠮᠤ ᠰᠤᠨ	ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ
ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠮᠤ ᠰᠤᠨ	ᠰᠤᠨᠠᠨᠠᠨᠠᠨ

2493



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 06 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төрөөс хөдөө аж ахуйг тогтвортой хөгжүүлэх бодлогын дэмжлэгтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн хууль тогтоомж

2.1.Хөдөө аж ахуйн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Малчны тухай хууль², Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль³, Малын генетик нөөцийн тухай хууль⁴, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль⁵, Гамшгаас хамгаалах тухай хууль⁶, Малын тоо толгойн албан татварын тухай хууль⁷, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль⁸, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль⁹, Тариалангийн тухай хууль¹⁰, Таримал ургамлын үр, сортын тухай хууль¹¹, Үрийн тариалангийн даатгалын тухай хууль¹², Органик бүтэгдэхүүний тухай хууль¹³, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

² Малчны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2024 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

³ Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2024 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Малын генетик нөөцийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2024 оны 18 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Гамшгаас хамгаалах тухай хууль Хууль тогтоомжийн эмхэтгэлийн 2017 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Малын тоо толгойн албан татварын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2020 оны 47 дугаарт нийтлэгдсэн.

⁸ Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 02 дугаарт нийтлэгдсэн.

⁹ Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2024 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

¹⁰ Тариалангийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

¹¹ Таримал ургамлын үр, сортын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

¹² Үрийн тариалангийн даатгалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1999 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

¹³ Органик бүтэгдэхүүний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2024 оны 36 дугаарт нийтлэгдсэн.

эдийн биржийн тухай хууль¹⁴, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх, үйлдвэрлэлийн сүлжээг хөгжүүлэхтэй холбогдсон харилцаанд үйлчилнэ.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“агро-ойн аж ахуй” гэж ойжуулалтыг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлтэй зориудаар хослуулсан, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн ашиг тустай аж ахуйн зохион байгуулалтыг;

4.1.2.“бэлчээрийн мал аж ахуй” гэж мал сүргийг бэлчээрт жилийн туршид улирлын хуваарьтайгаар идээшлүүлэн маллаж, ашиг шимийг нь хүртдэг, нүүдлийн өв соёлыг хадгалсан уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлийг;

4.1.3.“мал аж ахуйн үйлдвэрлэл” гэж мал, амьтныг өсгөн үржүүлж, тэдгээрээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх үйл ажиллагааг;

4.1.4.“тариалангийн үйлдвэрлэл” гэж Тариалангийн тухай хуулийн 16.1-д заасныг;

4.1.5.“тогтвортой хөдөө аж ахуй” гэж хүн, байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, эдийн засгийн өгөөжтэй, урт хугацаанд үргэлжлэх, бүтээмжтэй хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг;

4.1.6.“хөдөө аж ахуйн аялал жуулчлал” гэж мал аж ахуй, газар тариалан, уламжлалт нүүдлийн ахуйн хэв маяг, үндэсний соёл, өв уламжлалыг хадгалах, сурталчлан таниулах аялал жуулчлалын төрлийг;

¹⁴ Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 25 дугаарт нийтлэгдсэн.



4.1.7.“хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн” гэж хүнсний болон аж үйлдвэрийн зориулалтаар ургамал, мал, тэжээвэр амьтны аж ахуйгаас үйлдвэрлэсэн түүхий эд, бүтээгдэхүүнийг;

4.1.8.“хөдөө аж ахуйн үйлдвэрлэл” гэж хөдөө аж ахуйн газарт байгалийн болон биологийн нөөцөд тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл дагнан, эсхүл хослуулан эрхлэх үйл ажиллагааг;

4.1.9.“хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн сүлжээ” гэж хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бэлтгэн нийлүүлэх, анхан шатны боловсруулалт хийх, хадгалах, тээвэрлэх, борлуулах цогц үйл ажиллагааг;

4.1.10.“хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч” гэж энэ хуулийн 4.1.8-д заасан үйл ажиллагааг эрхэлж, эдийн засгийн өгөөж хүртэж байгаа хүн, хуулийн этгээдийг;

4.1.11.“эрчимжсэн мал аж ахуй” гэж Тариалангийн тухай хуулийн 3.1.7-д заасныг.

5 дугаар зүйл.Төрөөс хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлогын зарчим

5.1.Хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлого нь байгаль орчин, эдийн засаг, нийгмийн тэнцвэрийг хадгалахад чиглэнэ.

5.2.Хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

5.2.1.үндэсний үнэт зүйл, нүүдлийн соёл, өв уламжлалыг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх;

5.2.2.хүн, байгаль орчинд ээлтэй, ногоон, био эдийн засгийн хөгжлийг дэмжих;

5.2.3.уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх;

5.2.4.шинжлэх ухааны судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих, инновацыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

5.2.5.нөөцийг үр ашигтай ашиглах, орон нутгийн хөгжлийг дэмжих;

5.2.6.бүтээмж, эдийн засгийн өгөөж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах;

5.2.7.түүхий эд, бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийг тогтворжуулах, шударга өрсөлдөөнийг дэмжих;

5.2.8.хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах;

5.2.9.төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан, эрдэм шинжилгээ, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа, оролцоог хангах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

6 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн ангилал, төрөл

6.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дараах ангилалтай байна:

6.1.1.мал аж ахуй;

6.1.2.газар тариалан;

6.1.3.хадлан, тэжээл үйлдвэрлэл;

6.1.4.агро-ойн аж ахуй;

6.1.5.хөдөө аж ахуйн аялал жуулчлал.

6.2.Мал аж ахуйн үйлдвэрлэл нь үйл ажиллагааны онцлогоос хамаарч дараах төрөлтэй байна:

6.2.1.бэлчээрийн мал аж ахуй;

6.2.2.эрчимжсэн мал аж ахуй;

6.2.3.бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй хосолсон;

6.2.4.ашиг шимийн чиглэлээр төрөлжсөн мал аж ахуй.

6.3.Газар тариалангийн үйлдвэрлэл нь Тариалангийн тухай хуулийн 16.2-т заасан төрөлтэй байна.

6.4.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч энэ хуулийн 6.1-д заасан үйлдвэрлэлийг хослуулан эрхэлж болно.

7 дугаар зүйл.Хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх

7.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын¹⁵ хүрээнд газар зүйн байршил, экологийн онцлог, дэд бүтцийн хөгжил, хүн амын нягтрал болон биологийн бусад нөөц, зах зээлийн эрэлтэд тулгуурлан төрөлжүүлэн хөгжүүлнэ.

¹⁵ "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай" Улсын Их Хурлын тогтоол "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2024 оны 64 дугаарт нийтлэгдсэн.



7.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх тэргүүлэх чиглэлд бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, тэжээл үйлдвэрлэл, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо, үр тариа, хамгаалагдсан хөрсний тариалан, үржлийн аж ахуй, агро-ойн аж ахуйг хөгжүүлэх асуудлыг тусгайлан хамааруулна.

7.3.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх асуудлыг тодорхойлж, орон нутгийн хөгжлийн бодлого, Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

7.4.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хоршоо, кластерын зохион байгуулалтаар болон хөдөө аж ахуйн захиалгат бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр төрөлжүүлэн хөгжүүлж болно.

8 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо

8.1.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг төвлөрүүлэх, хадгалах, чанарын хамгаалалт хийх, худалдан борлуулах төвийг аймаг, суманд байгуулна.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан төвийн үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

8.3.Энэ хуулийн 8.1-д заасан төвд нийлүүлж, худалдан борлуулж байгаа түүхий эд, бүтээгдэхүүний талаарх мэдээлэл нь хөдөө аж ахуйн биржийн болон энэ хуулийн 10.1-д заасан цахим сантай холбогдсон байна.

8.4.Энэ хуулийн 8.1-д заасан төв нь түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авах, холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагын дагуу чанараар ангилах, шаардлагатай анхан шатны тордолт хийх, багцлах, савлах, шошголох, хадгалах, худалдан борлуулах үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.

8.5.Энэ хуулийн 8.1-д заасан төвийг байгуулах санхүүжилтийн эх үүсвэрийг улсын болон аймаг, сумын төсөв, хувийн хэвшлийн санхүүжилтээр шийдвэрлэнэ.

9 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанарын үнэлгээ, баталгаажуулалт

9.1.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг холбогдох стандартын дагуу үнэлж, баталгаажуулна.

9.2.Аймаг нь хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг шинжлэн судлах зориулалтын тоног төхөөрөмж, мэргэшсэн шинжээч бүхий лабораторитой байна.

9.3.Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний эрүүл ахуй, чанарын шинжилгээг холбогдох хуулиар зохицуулна.

10 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн сүлжээний бүртгэл, мэдээлэл

10.1.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүнсний бүтээгдэхүүний, зөвшөөрлийн, мал аж ахуй, газар тариалангийн, малын генетик нөөц, мал, амьтан, ургамлын эрүүл мэндийн, түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн, дотоодын болон олон улсын худалдаа, үйлчилгээний цахим сан /цаашид “цахим сан” гэх/-тай байна.

11 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн сүлжээнд оролцогчийн эрх, үүрэг

11.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн сүлжээнд оролцогч дараах эрх, үүрэгтэй:

11.1.1.үйлдвэрлэлээ өргөтгөх, хөгжүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зорилгоор төсөл боловсруулж, зээл, санхүүгийн дэмжлэг авах;

11.1.2.шинэ техник, технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх, ашиглах, зөвлөн туслах үйлчилгээ авах;

11.1.3.үйлдвэрлэлийн сүлжээний өөрт хамаарах үе шатанд зохистой дадал нэвтрүүлэх, түүнийг баталгаажуулах;

11.1.4.холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангах;

11.1.5.үйлдвэрлэсэн, бэлтгэн нийлүүлсэн, боловсруулсан түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, эрүүл ахуй, чанарын баталгааг хариуцах;

11.1.6.үйлдвэрлэсэн, бэлтгэн нийлүүлсэн, боловсруулсан түүхий эд, бүтээгдэхүүний тоо хэмжээг бүртгэл, мэдээллийн холбогдох дэд санд мэдээлэх;

11.1.7.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.



ГУРАВДУГААР БҮЛЭГ ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ

12 дугаар зүйл.Тогтвортой хөдөө аж ахуйн төлөвлөлт

12.1.Тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх Хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байна.

12.2.Хөдөө аж ахуйн Хөгжлийн зорилтот хөтөлбөрт дараах асуудлыг тусгана:

12.2.1.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх;

12.2.2.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шаардагдах мэргэшсэн хүний нөөцийн хэрэгцээг мэргэжил, мэргэшлийн түвшнээр тодорхойлж, хангах арга хэмжээ;

12.2.3.дотоодын хүнсний хангамж, экспортын бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулалт;

12.2.4.түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт;

12.2.5.хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын зах зээлийг судалж, экспортын голлох бүтээгдэхүүн тус бүрээр бодлого, стратеги;

12.2.6.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг ашигтай эрхлэх зах зээлийн болон нийгмийн таатай орчин бүрдүүлэлт.

12.3.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 12.1-д заасан зорилтот хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд¹⁶ нийцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангана.

12.4.Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа олон улсын төсөл, хөтөлбөрт энэ хуулийн 12.1-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгана.

13 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн газар

13.1.Төрөөс хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх баталгааг хангах зорилгоор холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид газрыг ашиглах, эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.

¹⁶ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2020 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

13.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах уст цэг, худгийн хоорондох зайг усны нөөц, уст цэгийн хайгуулын дүн, бүс нутгийн газар зүйн онцлогт үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

13.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээний усны нөөц, уст цэгийн хайгуул, судалгаа хийх, хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг Усны тухай хуулиар¹⁷ зохицуулна.

13.4.Хөдөө аж ахуйн газрын ангиллыг өөрчлөх, ангилал шилжүүлэхэд Газрын тухай хуулийн¹⁸ 23.2.9-д заасныг баримтлах бөгөөд улсын хөгжлийн бодлогын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хөдөө аж ахуйн газрыг нэгдмэл сангийн өөр ангилалд шилжүүлэхгүй.

14 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн судалгаа ба хөгжүүлэлт

14.1.Хөдөө аж ахуйн судалгаа ба хөгжүүлэлтийн тогтолцоо нь дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, оюуны өмчөөр хамгаалагдсан мэдлэгийг эргэлтэд оруулах, зах зээлд гаргах, энэ хуулийн 12.1-д заасан зорилтот хөтөлбөрт тусгасан судалгаа, хөгжүүлэлтийг гүйцэтгэхэд чиглэнэ.

14.2.Хөдөө аж ахуйн салбарын шинжлэх ухаан, технологи, инновацийн судалгааны үр дүнг нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах чиг үүрэгтэй төрийн үйлчилгээний байгууллага хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.

15 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх

15.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлнэ.

15.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийг дараах ангиллын дагуу үнэлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 15.2.1.байгаль орчны;
- 15.2.2.эдийн засгийн;
- 15.2.3.нийгмийн.

¹⁷ Усны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

¹⁸ Газрын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.



15.3.Энэ хуулийн 15.2.1-д заасан нөлөөллийн эрсдэлд бэлчээрийн болон тариалангийн газрын доройтол, усны хомсдол, генетик нөөцийн төлөв, уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгаруулалт, хог хаягдлын менежмент хамаарна.

15.4.Энэ хуулийн 15.2.2-т заасан нөлөөллийн эрсдэлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр, бүтээмж, өрсөлдөх чадвар, эдийн засгийн өгөөж, түүхий эд, бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, санхүүжилтийн хүртээмж, төрийн дэмжлэгийн үр дүн хамаарна.

15.5.Энэ хуулийн 15.2.3-т заасан нөлөөллийн эрсдэлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн тогтвортой ажлын байр, ажиллах орчны аюулгүй байдал, нийгмийн баталгааны өөрчлөлтөд дасан зохицох чадамж хамаарна.

15.6.Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, байгалийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг Засгийн газар, бүх шатны Засаг дарга авч, хэрэгжүүлж ажиллана.

16 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн даатгал

16.1.Хөдөө аж ахуйн дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, эрсдэл, түүний нөлөөллийг бууруулах зорилгоор хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог хөгжүүлнэ.

16.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн даатгал олон төрлийн багцтай байж болно.

16.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч нь үйл ажиллагааны төрөлжилт, онцлогоос хамаарч даатгалын нэр төрөл, багцыг сонгон хэрэглэнэ.

16.4.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн даатгалтай холбогдох харилцааг хуулиар зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДЭМЖЛЭГ

17 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжлэг

17.1.Төрөөс хөдөө аж ахуйн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортыг орлох болон экспортын баримжаатай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлогын хүрээнд дараах дэмжлэг үзүүлж болно:

- 17.1.1. шууд болон шууд бус татаас;
- 17.1.2. тарифын болон тарифын бус зохицуулалт;
- 17.1.3. хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн хөнгөлөлт;
- 17.1.4. хуульд заасан бусад дэмжлэг.

17.2. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжлэг үзүүлэх үйлдвэрлэлийн сүлжээний оролцогч нь дараах шаардлагыг хангасан байна:

- 17.2.1. зохистой дадал нэвтрүүлсэн, баталгаажуулсан байх;
- 17.2.2. стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан, баталгаажуулсан байх;
- 17.2.3. чанараас хамаарсан үнийн тогтолцоог нэвтрүүлсэн байх;
- 17.2.4. үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлсэн байх;
- 17.2.5. импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэл байх;
- 17.2.6. нэмүү өртөг шингээсэн байх.

17.3. Энэ хуулийн 17.2-т заасан шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлоход мэргэжлийн холбоодын оролцоог хангана.

ТАВДУГААР БҮЛЭГ **ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ**

18 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн салбар дахь төрийн удирдлага, зохицуулалт

18.1. Хөдөө аж ахуйн салбарын төрийн бодлого нь төвлөрсөн байх бөгөөд улсын хэмжээнд хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлд хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, сум, дүүрэгт хөдөө аж ахуйн тасаг болон бусад харьяа байгууллагаас бүрдэнэ.

18.2. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд мал, таримал ургамлын генетик нөөц, ургамлын болон мал, амьтны эрүүл мэнд, генийн сан, малын эм үйлдвэрлэл, лаборатори, аймаг дундын отрын бэлчээр, шинжлэх ухаан, инновац, судалгаа, шинжилгээ, нэвтрүүлэлт хариуцсан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд тус тус ажиллана.



18.3.Аймаг, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн тасгийн бүтцийг Засгийн газраас тогтоосон орон тооны хязгаарт багтаан хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18.4.Энэ хуулийн 18.2, 18.3-т заасан байгууллага нь энэ хууль болон холбогдох бусад хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

19 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

19.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль¹⁹, Хөдөлмөрийн тухай хуульд²⁰ заасан хариуцлага хүлээлгэнэ.

19.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль²¹, эсхүл Зөрчлийн тухай хуульд²² заасан хариуцлага хүлээлгэнэ.

20 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

20.1.Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ

¹⁹ Төрийн албаны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

²⁰ Хөдөлмөрийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2021 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

²¹ Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

²² Зөрчлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

[illegible][illegible]

در قسمت اول : مصلح است وضرر است و مسکن است ودر کارهای مهم و ضروری

[illegible][illegible][illegible][illegible]

התאריך: 1.1.2024

[illegible]

٤٠٦. نعتیہ احادیث میں مسلمانوں کی صفات

[illegible]

وہابیہ کی سرشتیں:

[illegible]

١٠٣٠٦ : ائفسي و ئاھياري .

[illegible]

سیدو لار سیدو . لار سیدو . لار سیدو .

دستور:

«صنعتی کار میسر» در سال ۹۵ و ۹۶
در صنعتی کار میسر

[illegible][illegible]

١٠٠٢٤ هر رخصتي بختدار دار حسن حسين «مکتوب دار پيغمبر» بين الملکي ٢٠٥٢ هـ و ٣٠ هجرت ٢٠٣٠ هـ

[illegible]

ممنوع من النشر «ممنوع من النشر» ١٩٤٥ م / ١٣٦٦ هـ ..

[illegible][illegible]

«مصدق» في نسخة مصنفه و نسخة
المصنف في نسخة المصنف ..

«**Судьба**» — это не просто название, а философия.

«...אני חושב שיש לי חלק גדול בזה...»

[illegible]

...הוא מנסה להבין את המציאות, וזהו תפקידו של המורה. המורה לא יודע את התשובה, אבל הוא יודע את השאלה. המורה לא יודע את התשובה, אבל הוא יודע את השאלה. המורה לא יודע את התשובה, אבל הוא יודע את השאלה.

[illegible]

«*Восстановление исторического облика*»

[illegible]

«*Самое главное – это не бояться*»

1. *...the ... of ...*
 2. *...the ... of ...*
 3. *...the ... of ...*
 4. *...the ... of ...*
 5. *...the ... of ...*
 6. *...the ... of ...*
 7. *...the ... of ...*
 8. *...the ... of ...*
 9. *...the ... of ...*
 10. *...the ... of ...*
 11. *...the ... of ...*
 12. *...the ... of ...*
 13. *...the ... of ...*
 14. *...the ... of ...*
 15. *...the ... of ...*
 16. *...the ... of ...*
 17. *...the ... of ...*
 18. *...the ... of ...*
 19. *...the ... of ...*
 20. *...the ... of ...*
 21. *...the ... of ...*
 22. *...the ... of ...*
 23. *...the ... of ...*
 24. *...the ... of ...*
 25. *...the ... of ...*
 26. *...the ... of ...*
 27. *...the ... of ...*
 28. *...the ... of ...*
 29. *...the ... of ...*
 30. *...the ... of ...*
 31. *...the ... of ...*
 32. *...the ... of ...*
 33. *...the ... of ...*
 34. *...the ... of ...*
 35. *...the ... of ...*
 36. *...the ... of ...*
 37. *...the ... of ...*
 38. *...the ... of ...*
 39. *...the ... of ...*
 40. *...the ... of ...*
 41. *...the ... of ...*
 42. *...the ... of ...*
 43. *...the ... of ...*
 44. *...the ... of ...*
 45. *...the ... of ...*
 46. *...the ... of ...*
 47. *...the ... of ...*
 48. *...the ... of ...*
 49. *...the ... of ...*
 50. *...the ... of ...*
 51. *...the ... of ...*
 52. *...the ... of ...*
 53. *...the ... of ...*
 54. *...the ... of ...*
 55. *...the ... of ...*
 56. *...the ... of ...*
 57. *...the ... of ...*
 58. *...the ... of ...*
 59. *...the ... of ...*
 60. *...the ... of ...*
 61. *...the ... of ...*
 62. *...the ... of ...*
 63. *...the ... of ...*
 64. *...the ... of ...*
 65. *...the ... of ...*
 66. *...the ... of ...*
 67. *...the ... of ...*
 68. *...the ... of ...*
 69. *...the ... of ...*
 70. *...the ... of ...*
 71. *...the ... of ...*
 72. *...the ... of ...*
 73. *...the ... of ...*
 74. *...the ... of ...*
 75. *...the ... of ...*
 76. *...the ... of ...*
 77. *...the ... of ...*
 78. *...the ... of ...*
 79. *...the ... of ...*
 80. *...the ... of ...*
 81. *...the ... of ...*
 82. *...the ... of ...*
 83. *...the ... of ...*
 84. *...the ... of ...*
 85. *...the ... of ...*
 86. *...the ... of ...*
 87. *...the ... of ...*
 88. *...the ... of ...*
 89. *...the ... of ...*
 90. *...the ... of ...*
 91. *...the ... of ...*
 92. *...the ... of ...*
 93. *...the ... of ...*
 94. *...the ... of ...*
 95. *...the ... of ...*
 96. *...the ... of ...*
 97. *...the ... of ...*
 98. *...the ... of ...*
 99. *...the ... of ...*
 100. *...the ... of ...*

intended to be:

॥ ॐ नमो भगवते वासुदेवाय ॥

𠂇 𠂈 𠂉 𠂊 𠂋 𠂌 𠂍 𠂎 𠂏 𠂐 𠂑 𠂒 𠂓 𠂔 𠂕 𠂖 𠂗 𠂘 𠂙 𠂚 𠂛 𠂜 𠂝 𠂞 𠂟 𠂠 𠂡 𠂢 𠂣 𠂤 𠂥 𠂦 𠂧 𠂨 𠂩 𠂪 𠂫 𠂬 𠂭 𠂮 𠂯 𠂰 𠂱 𠂲 𠂳 𠂴 𠂵 𠂶 𠂷 𠂸 𠂹 𠂺 𠂻 𠂼 𠂽 𠂾 𠂿 𠃀 𠃁 𠃂 𠃃 𠃄 𠃅 𠃆 𠃇 𠃈 𠃉 𠃊 𠃋 𠃌 𠃍 𠃎 𠃏 𠃐 𠃑 𠃒 𠃓 𠃔 𠃕 𠃖 𠃗 𠃘 𠃙 𠃚 𠃛 𠃜 𠃝 𠃞 𠃟 𠃠 𠃡 𠃢 𠃣 𠃤 𠃥 𠃦 𠃧 𠃨 𠃩 𠃪 𠃫 𠃬 𠃭 𠃮 𠃯 𠃰 𠃱 𠃲 𠃳 𠃴 𠃵 𠃶 𠃷 𠃸 𠃹 𠃺 𠃻 𠃼 𠃽 𠃾 𠃿 𠄀 𠄁 𠄂 𠄃 𠄄 𠄅 𠄆 𠄇 𠄈 𠄉 𠄊 𠄋 𠄌 𠄍 𠄎 𠄏 𠄐 𠄑 𠄒 𠄓 𠄔 𠄕 𠄖 𠄗 𠄘 𠄙 𠄚 𠄛 𠄜 𠄝 𠄞 𠄟 𠄠 𠄡 𠄢 𠄣 𠄤 𠄥 𠄦 𠄧 𠄨 𠄩 𠄪 𠄫 𠄬 𠄭 𠄮 𠄯 𠄰 𠄱 𠄲 𠄳 𠄴 𠄵 𠄶 𠄷 𠄸 𠄹 𠄺 𠄻 𠄼 𠄽 𠄾 𠄿 𠅀 𠅁 𠅂 𠅃 𠅄 𠅅 𠅆 𠅇 𠅈 𠅉 𠅊 𠅋 𠅌 𠅍 𠅎 𠅏 𠅐 𠅑 𠅒 𠅓 𠅔 𠅕 𠅖 𠅗 𠅘 𠅙 𠅚 𠅛 𠅜 𠅝 𠅞 𠅟 𠅠 𠅡 𠅢 𠅣 𠅤 𠅥 𠅦 𠅧 𠅨 𠅩 𠅪 𠅫 𠅬 𠅭 𠅮 𠅯 𠅰 𠅱 𠅲 𠅳 𠅴 𠅵 𠅶 𠅷 𠅸 𠅹 𠅺 𠅻 𠅼 𠅽 𠅾 𠅿 𠆀 𠆁 𠆂 𠆃 𠆄 𠆅 𠆆 𠆇 𠆈 𠆉 𠆊 𠆋 𠆌 𠆍 𠆎 𠆏 𠆐 𠆑 𠆒 𠆓 𠆔 𠆕 𠆖 𠆗 𠆘 𠆙 𠆚 𠆛 𠆜 𠆝 𠆞 𠆟 𠆠 𠆡 𠆢 𠆣 𠆤 𠆥 𠆦 𠆧 𠆨 𠆩 𠆪 𠆫 𠆬 𠆭 𠆮 𠆯 𠆰 𠆱 𠆲 𠆳 𠆴 𠆵 𠆶 𠆷 𠆸 𠆹 𠆺 𠆻 𠆼 𠆽 𠆾 𠆿 𠇀 𠇁 𠇂 𠇃 𠇄 𠇅 𠇆 𠇇 𠇈 𠇉 𠇊 𠇋 𠇌 𠇍 𠇎 𠇏 𠇐 𠇑 𠇒 𠇓 𠇔 𠇕 𠇖 𠇗 𠇘 𠇙 𠇚 𠇛 𠇜 𠇝 𠇞 𠇟 𠇠 𠇡 𠇢 𠇣 𠇤 𠇥 𠇦 𠇧 𠇨 𠇩 𠇪 𠇫 𠇬 𠇭 𠇮 𠇯 𠇰 𠇱 𠇲 𠇳 𠇴 𠇵 𠇶 𠇷 𠇸 𠇹 𠇺 𠇻 𠇼 𠇽 𠇾 𠇿 𠈀 𠈁 𠈂 𠈃 𠈄 𠈅 𠈆 𠈇 𠈈 𠈉 𠈊 𠈋 𠈌 𠈍 𠈎 𠈏 𠈐 𠈑 𠈒 𠈓 𠈔 𠈕 𠈖 𠈗 𠈘 𠈙 𠈚 𠈛 𠈜 𠈝 𠈞 𠈟 𠈠 𠈡 𠈢 𠈣 𠈤 𠈥 𠈦 𠈧 𠈨 𠈩 𠈪 𠈫 𠈬 𠈭 𠈮 𠈯 𠈰 𠈱 𠈲 𠈳 𠈴 𠈵 𠈶 𠈷 𠈸 𠈹 𠈺 𠈻 𠈼 𠈽 𠈾 𠈿 𠉀 𠉁 𠉂 𠉃 𠉄 𠉅 𠉆 𠉇 𠉈 𠉉 𠉊 𠉋 𠉌 𠉍 𠉎 𠉏 𠉐 𠉑 𠉒 𠉓 𠉔 𠉕 𠉖 𠉗 𠉘 𠉙 𠉚 𠉛 𠉜 𠉝 𠉞 𠉟 𠉠 𠉡 𠉢 𠉣 𠉤 𠉥 𠉦 𠉧 𠉨 𠉩 𠉪 𠉫 𠉬 𠉭 𠉮 𠉯 𠉰 𠉱 𠉲 𠉳 𠉴 𠉵 𠉶 𠉷 𠉸 𠉹 𠉺 𠉻 𠉼 𠉽 𠉾 𠉿 𠊀 𠊁 𠊂 𠊃 𠊄 𠊅 𠊆 𠊇 𠊈 𠊉 𠊊 𠊋 𠊌 𠊍 𠊎 𠊏 𠊐 𠊑 𠊒 𠊓 𠊔 𠊕 𠊖 𠊗 𠊘 𠊙 𠊚 𠊛 𠊜 𠊝 𠊞 𠊟 𠊠 𠊡 𠊢 𠊣 𠊤 𠊥 𠊦 𠊧 𠊨 𠊩 𠊪 𠊫 𠊬 𠊭 𠊮 𠊯 𠊰 𠊱 𠊲 𠊳 𠊴 𠊵 𠊶 𠊷 𠊸 𠊹 𠊺 𠊻 𠊼 𠊽 𠊾 𠊿 𠋀 𠋁 𠋂 𠋃 𠋄 𠋅 𠋆 𠋇 𠋈 𠋉 𠋊 𠋋 𠋌 𠋍 𠋎 𠋏 𠋐 𠋑 𠋒 𠋓 𠋔 𠋕 𠋖 𠋗 𠋘 𠋙 𠋚 𠋛 𠋜 𠋝 𠋞 𠋟 𠋠 𠋡 𠋢 𠋣 𠋤 𠋥 𠋦 𠋧 𠋨 𠋩 𠋪 𠋫 𠋬 𠋭 𠋮 𠋯 𠋰 𠋱 𠋲 𠋳 𠋴 𠋵 𠋶 𠋷 𠋸 𠋹 𠋺 𠋻 𠋼 𠋽 𠋾 𠋿 𠌀 𠌁 𠌂 𠌃 𠌄 𠌅 𠌆 𠌇 𠌈 𠌉 𠌊 𠌋 𠌌 𠌍 𠌎 𠌏 𠌐 𠌑 𠌒 𠌓 𠌔 𠌕 𠌖 𠌗 𠌘 𠌙 𠌚 𠌛 𠌜 𠌝 𠌞 𠌟 𠌠 𠌡 𠌢 𠌣 𠌤 𠌥 𠌦 𠌧 𠌨 𠌩 𠌪 𠌫 𠌬 𠌭 𠌮 𠌯 𠌰 𠌱 𠌲 𠌳 𠌴 𠌵 𠌶 𠌷 𠌸 𠌹 𠌺 𠌻 𠌼 𠌽 𠌾 𠌿 𠍀 𠍁 𠍂 𠍃 𠍄 𠍅 𠍆 𠍇 𠍈 𠍉 𠍊 𠍋 𠍌 𠍍 𠍎 𠍏 𠍐 𠍑 𠍒 𠍓 𠍔 𠍕 𠍖 𠍗 𠍘 𠍙 𠍚 𠍛 𠍜 𠍝 𠍞 𠍟 𠍠 𠍡 𠍢 𠍣 𠍤 𠍥 𠍦 𠍧 𠍨 𠍩 𠍪 𠍫 𠍬 𠍭 𠍮 𠍯 𠍰 𠍱 𠍲 𠍳 𠍴 𠍵 𠍶 𠍷 𠍸 𠍹 𠍺 𠍻 𠍼 𠍽 𠍾 𠍿 𠎀 𠎁 𠎂 𠎃 𠎄 𠎅 𠎆 𠎇 𠎈 𠎉 𠎊 𠎋 𠎌 𠎍 𠎎 𠎏 𠎐 𠎑 𠎒 𠎓 𠎔 𠎕 𠎖 𠎗 𠎘 𠎙 𠎚 𠎛 𠎜 𠎝 𠎞 𠎟 𠎠 𠎡 𠎢 𠎣 𠎤 𠎥 𠎦 𠎧 𠎨 𠎩 𠎪 𠎫 𠎬 𠎭 𠎮 𠎯 𠎰 𠎱 𠎲 𠎳 𠎴 𠎵 𠎶 𠎷 𠎸

[illegible]

卷之五

[illegible]

«**Самое интересное**»



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл, журмыг тогтоох, компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, удирдлага, зохион байгуулалт, засаглалыг сайжруулах, хяналтыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын хууль тогтоомж

2.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль², Иргэний хууль³, Компанийн тухай хууль⁴, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулна.

3.2.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн өмчтэй холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна.

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

² Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1996 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

³ Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Компанийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 42 дугаарт нийтлэгдсэн.

3.3.Тухайлсан хуулиар зохицуулагдах төрийн өмчит компанийн үйл ажиллагааг тухайн хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 3.1, 3.2-т заасны дагуу зохицуулна.

3.4.Хот, тосгоны өмчит компанийн үйл ажиллагаанд энэ хуульд заасан орон нутгийн өмчит компанийн зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“төрийн өмчит компани” гэж төр хуульд заасны дагуу хувьцааг нь эзэмшиж байгаа, эсхүл хяналтын эрхийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийг;

4.1.2.“орон нутгийн өмчит компани” гэж орон нутаг хуульд заасны дагуу хувьцааг нь эзэмшиж байгаа, эсхүл хяналтын эрхийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийг;

4.1.3.“төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани” гэж компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-иас дээш хувийг төр, эсхүл орон нутаг эзэмшдэг хуулийн этгээдийг;

4.1.4.“нийтийн үйлчилгээ” гэж иргэдийн ая тухтай амьдрах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор дэд бүтэц, эрчим хүч, зам, тээвэр, эрүүл мэнд, боловсрол, соёл, спорт болон холбогдох бусад салбарт төрөөс иргэдэд тэгш, чанартай, үр ашигтай, хууль тогтоомж, стандартын дагуу үзүүлж байгаа олон нийтэд зориулсан үйлчилгээг;

4.1.5.“хяналтын эрхийг хэрэгжүүлэх” гэж төр, орон нутаг, эсхүл тэдгээрийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь дангаараа, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдээр дамжуулан тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхыг томилох, эсхүл компанийн стратеги, санхүүгийн бодлого, үндсэн үйл ажиллагаанд заавал биелэгдэх шийдвэр гаргах эрхийг хууль, гэрээ, дүрмийн үндсэн дээр хэрэгжүүлэхийг.

5 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:



5.1.1.ил тод, нээлттэй байх;
5.1.2.үр ашигтай байх;
5.1.3.зах зээлд шударга өрсөлдөх, аливаа хэлбэрээр давуу эрх эдлэхгүй байх;

5.1.4.монополь, эсхүл давамгай байдлаа урвуулан ашиглахгүй байх;

5.1.5.компанийн үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах, удирдлагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх;

5.1.6.улс төрийн нөлөөллөөс ангид, хараат бус байх;
5.1.7.компани төрийн болон орон нутгийн хүлээх үүргийг хариуцахгүй байх;

5.1.8.тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжих;
5.1.9.шинэ технологи, инновацыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллах.

5.2.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлагыг хэрэгжүүлэхэд энэ хуулийн 5.1-д зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

5.2.1.компанийн удирдлагын эрх төрийн болон орон нутгийн эрх хэмжээнээс тусгаарлагдсан байх;

5.2.2.хувьцааны төрөл, тоонд нийцүүлэн хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах;

5.2.3.хараат бус хөндлөнгийн хяналттай байх;
5.2.4.мэргэшсэн байх;
5.2.5.үргүй зардал гаргахгүй байх;
5.2.6.эрх бүхий этгээдийн баталсан санхүүгийн болон бизнес төлөвлөгөөний дагуу ажиллах;

5.2.7.хариуцлага, эрх, үүргийн хувьд бие даасан байх;
5.2.8.цаг хугацаандаа, үнэн зөв, бүрэн тайлагнах.

Тайлбар: - Энэ хуульд заасан “үр ашигтай байх” гэж арилжааны зорилго бүхий төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд оруулсан капиталын өгөөжийг капиталын жигнэсэн дундаж өртгөөс өндөр түвшинд байхаар үйл ажиллагаа явуулж, компанийн урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэхийг ойлгоно. Нийтийн үйлчилгээний төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд нийтийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, тасралтгүй, боломжит бага зардлаар үзүүлэхийг ойлгоно.

Тайлбар: - Энэ хуульд заасан “зах зээлд шударга өрсөлдөх, аливаа хэлбэрээр давуу эрх эдлэхгүй байх” гэж хуульд зааснаас бусад тохиолдолд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхгүй, төрийн болон орон нутгийн өмчийг зах зээлийн үнэ, нөхцөлөөс доогуур ашиглахгүй, зөвшөөрөл, эрх олгох болон төрийн худалдан авах ажиллагаанд давуу эрх эдлэхгүй, дампуурал, төлбөрийн чадваргүйдлийн нийтлэг журмаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдөхгүй байхыг ойлгоно.

6 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн ангилал

6.1.Төрийн өмчит компанийг тухайн компанийн хувьцааны төрийн эзэмшлийн хувь хэмжээнээс хамааруулан дараах байдлаар ангилна:

6.1.1.компанийн нийт гаргасан энгийн хувьцааг бүхэлд нь төр дангаараа эзэмшдэг бол төрийн өмчийн компани;

6.1.2.компанийн нийт гаргасан энгийн хувьцааны гуравны нэгээс 100 хүртэл хувийг төр эзэмшдэг бол төрийн өмчийн оролцоотой компани.

6.2.Орон нутгийн өмчит компанийг тухайн компанийн хувьцааны орон нутгийн эзэмшлийн хувь хэмжээнээс хамааруулан дараах байдлаар ангилна:

6.2.1.компанийн нийт гаргасан энгийн хувьцааг бүхэлд нь орон нутаг дангаараа эзэмшдэг бол орон нутгийн өмчийн компани;

6.2.2.компанийн нийт гаргасан энгийн хувьцааны гуравны нэгээс 100 хүртэл хувийг орон нутаг эзэмшдэг бол орон нутгийн өмчийн оролцоотой компани.

6.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийг үйл ажиллагааны зорилго, чиг үүргээс нь хамааруулан арилжааны, эсхүл нийтийн үйлчилгээний гэж ангилах бөгөөд энэ талаар тухайн компанийн дүрэмд тусгана.

7 дугаар зүйл.Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлого

7.1.Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.

7.2.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Засгийн газрын гишүүдийн саналыг авч, нэгтгэн судалсны



үндсэн дээр төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн⁵ 4.1.8-д заасан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулна.

7.3.Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогод дараах зүйлийг тусгана:

7.3.1.төрийн өмчит компанийн хувьцаа эзэмших зорилго, хяналтын эрхийг хэрэгжүүлэх үндэслэл;

7.3.2.төрийн өмчит компанийн жагсаалт, хөрөнгийн багц мэдээлэл;

7.3.3.төрийн өмчит компанийн засаглалд оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага;

7.3.4.төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн;

7.3.5.төрийн өмчит компани шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, өөрчлөлт, шинэтгэлийн төлөвлөгөө;

7.3.6.төрийн өмчит компанийн хувьцааг худалдах, түүнийг хэрэгжүүлэх арга, төлөвлөгөө.

7.4.Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогод энэ хуулийн 8.1-д заасан төрийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэлийг компани тус бүрээр тодорхойлж тусгана.

7.5.Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогын хэрэгжилтэд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг тухайн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газарт, Засгийн газар тайланг Улсын Их Хурлын тухайн жилийн намрын ээлжит чуулганы хугацаанд холбогдох Байнгын хороонд танилцуулна.

7.6.Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогын хэрэгжилтийн тайланг Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаа дуусахаас хоёроос доошгүй сарын өмнө Улсын Их Хуралд танилцуулна.

7.7.Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлого, түүний хэрэгжилтийн жил бүрийн тайланг Засгийн газар

⁵ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2020 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

болон төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй, ил тод байршуулна.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ
КОМПАНИ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ**

**8 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компани
үүсгэн байгуулах үндэслэл**

8.1.Төрийн өмчит компанийг дараах үндэслэлээр үүсгэн байгуулж болно:

8.1.1.хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй, санхүүгийн үр ашиггүй нөхцөлд нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэх;

8.1.2.үндэсний эдийн засгийн ашиг сонирхлыг хангах зорилгоор төрийн нийтийн өмчид хамаарах байгалийн баялгийг ашиглах;

8.1.3.зүй ёсны монополь үйл ажиллагаа эрхлэх;

8.1.4.үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой батлан хамгаалах, хил хамгаалах, харилцаа холбоо, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг дэмжих, холбогдох аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх;

8.1.5.хуульд тусгайлан заасан бол.

8.2.Орон нутаг хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор энэ хуулийн 8.1.1-д заасан үндэслэлээр орон нутгийн өмчит компанийг үүсгэн байгуулна. Энэ хуулийн 8.1.2-т заасан үндэслэлээр орон нутгийн өмчит компанийг Улсын Их Хурлын зөвшөөрлөөр үүсгэн байгуулж болно.

8.3.Энэ хуулийн 8.1.4-т заасан үндэслэлээр төрийн өмчийн компани үүсгэн байгуулна.

8.4.Хуульд зааснаас өөр үндэслэлээр төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулахыг хориглоно.

**9 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компани
үүсгэн байгуулах санал, шийдвэр**

9.1.Холбогдох асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төрийн өмчит компани үүсгэн байгуулах саналыг Засгийн газарт хүргүүлнэ.



9.2.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах саналыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

9.3.Төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах саналд дараах баримт бичгийг хавсаргана:

9.3.1.компанийн дүрмийн төсөл;

9.3.2.энэ хуулийн 8.1-д заасан компани үүсгэн байгуулах үндэслэл төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогод нийцсэн талаарх төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газрын гаргасан дүгнэлт.

9.4.Энэ хуулийн 9.3.2-т заасан дүгнэлтийг дараах судалгаа, мэдээлэлд үндэслэн гаргана:

9.4.1.компани үүсгэн байгуулах хэрэгцээ, шаардлага буюу хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх гэсэн бодлоготой нийцэж байгаа эсэх, зах зээлийн эрэлт, хүлээлт, компаниас гаргах бараа, ажил, үйлчилгээний жагсаалт, тэдгээрийг борлуулах чадамж, бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх байдлын талаарх зах зээлийн судалгаа, байршил;

9.4.2.хөрөнгө оруулалтын хэмжээ, төр, эсхүл орон нутгаас оруулах хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, хөрөнгө оруулалтыг бүрэн хийж дуусах хугацаа, түүнийг нөхөх болон эргэлтийн эх үүсвэр бүрдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд тавих шаардлага;

9.4.3.бараа, ажил, үйлчилгээнд шаардагдах түүхий эд, эрчим хүч, ажиллах хүч болон бусад шаардлагатай хүчин зүйлийг хангах эх үүсвэр, чадамж;

9.4.4.салбарын хөгжлийн төлөвлөгөө, бодлогод нийцсэн байдал, эдийн засаг, нийгмийн үр ашгийн тооцоолол;

9.4.5.компанийн үйл ажиллагаа явуулах хугацаатай байх эсэх, түүний үндэслэл.

9.5.Төрийн өмчийн компани үүсгэн байгуулах шийдвэрийг Засгийн газар, төрийн өмчийн оролцоотой компани үүсгэн байгуулах шийдвэрийг Засгийн газрын зөвшөөрлийг үндэслэн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, бусад этгээд хамтран Компанийн тухай хуульд заасан журмын дагуу гаргана.

9.6.Орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулах шийдвэрийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргах бөгөөд орон нутгийн өмчийн оролцоотой компани үүсгэн байгуулах шийдвэрийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрлийг үндэслэн орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, бусад этгээд хамтран Компанийн тухай хуульд заасан журмын дагуу гаргана.

9.7.Төрийн болон орон нутгийн өмчит компанийг хугацаатай байгуулж болох бөгөөд үйл ажиллагаа явуулах хугацаа дууссан тохиолдолд хугацааг сунгах, эсхүл компанийг татан буулгах асуудлыг энэ хуулийн 9.5, 9.6-д заасан этгээд шийдвэрлэнэ.

9.8.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаа явуулах хугацааг сунгах эсэх асуудлыг тухайн хугацаа дуусах оны өмнөх санхүүгийн жилд багтаан шийдвэрлэх бөгөөд үйл ажиллагаа явуулах хугацааг сунгахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаатай холбоотой асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

10 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн дүрэм

10.1.Засгийн газар төрийн өмчийн компани үүсгэн байгуулах шийдвэр гаргахдаа компанийн дүрмийг батална.

10.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулах шийдвэр гаргахдаа компанийн дүрмийг батална.

10.3.Энэ хуулийн 10.1-д заасан компанийн дүрмийн төслийг боловсруулахад төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын, энэ хуулийн 10.2-т заасан компанийн дүрмийн төслийг боловсруулахад орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газрын саналыг авсан байна.

10.4.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16.2-т зааснаас гадна компанийн үйл ажиллагааны зорилго, хүрэх үр дүн, хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл, нийтийн үйлчилгээний үүргийн бодлогыг тодорхой тусгана.

10.5.Төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн дүрэмд Компанийн тухай хуулийн 89.4-т заасан зохицуулалт хамаарахгүй.

10.6.Алтан хувьцаа гаргах тохиолдолд компанийн дүрэмд алтан хувьцаа эзэмших этгээд, эрхийн агуулга, хугацааг тусгана.



11 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн охин компани, салбар, төлөөлөгчийн газар

11.1.Төрийн өмчийн компани охин компани үүсгэн байгуулах тохиолдолд Засгийн газар, орон нутгийн өмчийн компани охин компани үүсгэн байгуулах тохиолдолд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 9.3-т заасан баримт бичгийг үндэслэн шийдвэр гаргана.

11.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компани бусад этгээдтэй хамтран хараат болон охин компани үүсгэн байгуулах асуудлыг энэ хуулийн 8.1-д заасан үндэслэлийн дагуу энэ хуулийн 9.4-т заасан судалгаа, шинжилгээ болон Засгийн газрын зөвшөөрлийн дагуу Компанийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

11.3.Энэ хуулийн 11.1, 11.2-т заасны дагуу үүсгэн байгуулсан охин, хараат компани дахь төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг толгой компани эзэмшинэ.

11.4.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах асуудлыг Компанийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА, НОГДОЛ АШИГ

12 дугаар зүйл.Хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө, түүний хэмжээг өөрчлөх

12.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулах шийдвэрт компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийг тусгасан байна.

12.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ энэ тухай санхүүгийн тайлан гарснаас хойш ажлын таван өдрийн дотор хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид мэдэгдэнэ.

12.3.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ хуулийн 12.2-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах, компанийг өөрчлөн байгуулах, дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах тухай саналаа төрийн өмчийн

компанийн хувьд Засгийн газарт, орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

13 дугаар зүйл. Алтан хувьцаа

13.1. Засгийн газар төрийн өмчит компанийн төрд ногдох хувьцааг бүхэлд нь шилжүүлэх тухай шийдвэр гаргахдаа тодорхой хугацаанд компанийн удирдлагын шийдвэрт хориг тавих эрхтэй, ногдол ашиг авдаггүй алтан хувьцаа эзэмшихээр зааж болно.

13.2. Алтан хувьцаатай компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын дараах шийдвэр нь үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт харшилсан гэж үзвэл Засгийн газар хориг тавина:

13.2.1. өмнө эрхэлж байсан үйл ажиллагааны чиглэл, үндсэн үйл ажиллагааг өөрчлөх;

13.2.2. алтан хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарласан, хугацааг багасгасан өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулах;

13.2.3. компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах;

13.2.4. их хэмжээний хэлцэл байгуулах;

13.2.5. бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох;

13.2.6. компанийн хувьцааны хяналтын багцтай хэмжээгээрээ дүйцэхүйц хувьцаа болон хувьцаанд хамаарах бусад үнэт цаасыг нэг болон хэд хэдэн удаагийн дараалсан шийдвэрээр нэмж гаргах;

13.2.7. талууд харилцан тохиролцож, компанийн дүрэмд заасан бусад.

13.3. Энэ хуулийн 13.2-т заасан шийдвэрийг хүлээн авснаас хойш Засгийн газар ажлын 15 өдрийн дотор хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

13.4. Засгийн газар хориг тавих шийдвэр гаргаагүй бол энэ хуулийн 13.2-т заасан хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын шийдвэр хүчин төгөлдөр болно.

13.5. Засгийн газар энэ хуулийн 13.2-т заасны дагуу хориг тавих тухай шийдвэртээ хориг тавьж байгаа үндэслэл, хоригийн хамрах хүрээг заана.



13.6.Алтан хувьцааг бусдад шилжүүлэхийг хориглоно.

13.7.Энэ хуулийн 13.1-д заасны дагуу компанийн дүрэмд тусгасан хугацаа дуусмагц алтан хувьцаа хүчингүй болох бөгөөд хугацааг сунгахгүй.

13.8.Засгийн газар хориг тавих шийдвэр гаргахдаа зорилгодоо нийцсэн байх, компанийн үйл ажиллагаанд хамгийн бага хязгаарлалт тогтоох зарчмыг баримтална.

14 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанид хөрөнгө олж авах

14.1.Үндэсний баялгийн сангийн тухай хууль⁶, Ашигт малтмалын тухай хууль⁷ болон бусад хуульд заасан үндэслэл, журмын дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа компанийн хувьцааг эзэмших замаар төр хөрөнгө олж авч болно.

14.2.Төр, эсхүл орон нутаг нь компанийн энгийн хувьцааг дараах тохиолдолд олж авч болно:

14.2.1.бэлэглэл, өв залгамжлалаар эзэмшилдээ олж авсан;

14.2.2.Иргэний хуульд заасан арилжааны гэрээний дагуу;

14.2.3.шүүх, арбитрын шийдвэрийн дагуу.

14.3.Энэ хуулийн 14.2-т заасны дагуу компанийн энгийн хувьцааны гуравны нэгээс доош хувийг олж авсан бол төр, эсхүл орон нутаг тухайн хувьцааны зах зээлийн үнэ болон бодит үнэ цэнийг тооцон, аль өндөр үнээр тухайн хувьцааг худалдана.

14.4.Энэ хуулийн 14.3-т заасан компани нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, эсхүл хаалттай хувьцаат компани бол тухайн олж авсан хувьцааг Компанийн тухай хуульд өөрөөр заагаагүй бол бусад хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжид худалдаж авахыг санал болгоно.

14.5.Энэ хуулийн 14.4-т заасны дагуу санал болгосон хувьцааг тэргүүн ээлжид худалдаж аваагүй тохиолдолд нээлттэй дуудлага худалдаагаар худалдана. Нээлттэй дуудлага худалдаагаар худалдах хувьцааны үнэ энэ хуулийн 14.3-т зааснаас доошгүй байна.

14.6.Энэ хуулийн 14.3-т заасан компани нь нээлттэй хувьцаат компани бол тухайн олж авсан хувьцааг арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалдана.

⁶ Үндэсний баялгийн сангийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2024 оны 17 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Ашигт малтмалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

15 дугаар зүйл.Өрийн хэрэгсэл гаргах, зээл авах

15.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн Үнэт цаасны зах зээлийн тухай хууль⁸, Компанийн тухай хуульд заасны дагуу өрийн хэрэгсэл гаргаж болно.

15.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн зээл авч болно.

15.3.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан зөвшөөрөлд тухайн санхүүгийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр авах үнэт цаас, зээл хамаарахгүй.

15.4.Гүйцэтгэх удирдлага зээлийн гэрээний дагуу төлбөл зохих хуваарь болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг төлж барагдуулах төлөвлөгөө, хуваарийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан төлөөлөн удирдах зөвлөлд /байхгүй бол хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид/ танилцуулж, шийдвэрлүүлнэ.

15.5.Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани бусад этгээдэд өрийн баталгаа гаргахыг хориглоно.

16 дугаар зүйл.Ногдол ашгийн бодлого

16.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани нь Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасан ногдол ашгийн бодлоготой байх бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ батална.

16.2.Ногдол ашгийн бодлогод тухайн компанийн үйл ажиллагааны зорилго, хөрөнгө оруулалтын бүтэц, мөнгөн урсгалын онцлогоос хамааруулан дараах хэлбэрийн аль нэг, эсхүл хосолсон хэлбэрийг тусгана:

16.2.1.аудитлагдсан санхүүгийн тайланд туссан татвар төлсний дараах цэвэр ашгийн тодорхой хувиар;

16.2.2.жил бүр хөрөнгө оруулагчид тогтвортой хуваарилахаар урьдчилан тогтоосон ногдол ашгийн зорилтот хэмжээ болон түүнд тооцох өсөлтийн хувиар;

⁸ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 24 дугаарт нийтлэгдсэн.



16.2.3.аудитлагдсан санхүүгийн тайланд туссан хувь нийлүүлсэн хөрөнгө, чөлөөт мөнгөн урсгал, хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг, эсхүл хүү, татварын өмнөх ашиг зэрэг санхүүгийн үзүүлэлтээр урьдчилан тогтоосон хувь хэмжээгээр;

16.2.4.бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс шалтгаалж урьдчилан тооцоолоогүй орлого бий болсон тохиолдолд түүний урьдчилан тогтоосон тодорхой хувиар.

16.3.Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компанийн ногдол ашгийн бодлогод дараах зарчим, шаардлагыг тусгана:

16.3.1.ногдол ашгийг аудитлагдсан санхүүгийн тайланг үндэслэн тогтоох;

16.3.2.компанийн батлагдсан бизнес болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, их засварын хэрэгцээ, нөөц сан бүрдүүлэх шаардлага, санхүүгийн тогтвортой байдлыг харгалзан үзэх;

16.3.3.нийтийн үйлчилгээний үүрэг хүлээсэн бол тухайн үүргийн санхүүжилт, нөхөн төлбөр, татаас, тарифын зохицуулалт, зориулалтын хөрөнгийг ногдол ашиг тооцох сууринаас тусад нь авч үзэх;

16.3.4.компанийн урт хугацааны үнэ цэн, хэвийн үйл ажиллагааг дордуулахгүй байх;

16.3.5.бусад хувьцаа эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх.

16.4.Арилжааны зорилго бүхий төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани нь ногдол ашгийн бодлогод заасны дагуу ногдол ашиг хуваарилах үүрэгтэй.

16.5.Энэ хуулийн 16.4-т заасан компанийн тухайн жилд хуваарилах ногдол ашгийн зорилтот хувь хэмжээ, ногдол ашиг тооцох хэлбэрийг Засгийн газар, орон нутгийн өмчит компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн төсвийн төсөл боловсруулах үе шатанд компанийн ангилал, салбарын онцлог, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, өр төлбөрийн хэмжээ, мөнгөн урсгал, өөрийн хөрөнгийн өгөөж, нөөц сангийн шаардлагыг харгалзан тогтооно.

16.6.Энэ хуулийн 16.5-д заасан зорилтот хувь хэмжээ нь арилжааны зорилго бүхий компанийн хувьд хуваарилж болох цэвэр ашгийн 30 хувиас доошгүй байх зарчмыг баримтална. Харин компанийн санхүүгийн байдал, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, өр төлбөрийн хэмжээ, эсхүл энэ хуулийн 16.8-д заасан үндэслэл байгаа бол уг хувь хэмжээг бууруулж болно.

16.7.Нийтийн үйлчилгээний төрийн болон орон нутгийн өмчит компанид энэ хуулийн 16.6-д заасан доод хувь хэмжээ хамаарахгүй. Компани нь цэвэр ашигтай ажилласан тохиолдолд төлбөрийн чадвар, мөнгөн урсгал, нийтийн үйлчилгээний үүргийн санхүүжилт, үйлчилгээний хүртээмж, чанар, тасралтгүй байдлыг харгалзан ногдол ашиг хуваарилж болно.

16.8.Дараах үндэслэл байгаа бол энэ хуулийн 16.5, 16.6-д заасан зорилтот буюу доод хувь хэмжээнээс бага хэмжээгээр ногдол ашиг хуваарилж болно:

16.8.1.компанийн хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд цэвэр ашгаас дахин хөрөнгө оруулалт хийх зайлшгүй шаардлага үүссэн;

16.8.2.компанийн ногдол ашгийн бодлогод тусгасны дагуу хуримтлагдсан алдагдлыг нөхөх шаардлага үүссэн;

16.8.3.эрх бүхий байгууллагаас тогтоосон өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлтийг хангуулж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах шаардлага үүссэн.

16.9.Энэ хуулийн 16.8-д заасан үндэслэлээр ногдол ашгийг зорилтот хувь хэмжээнээс бага тогтоох саналыг төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Саналд дараах баримт бичгийг хавсаргана:

16.9.1.аудитлагдсан санхүүгийн тайлан;

16.9.2.төлбөрийн чадварын болон мөнгөн урсгалын дүгнэлт;

16.9.3.зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоолол.

16.10.Энэ хуулийн 16.9-д заасан саналыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч хянаж, зөвшөөрөх, өөрчлөх, эсхүл татгалзах тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.



**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

**17 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн
хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн
эрхийг хэрэгжүүлэгч**

17.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигч нь Засгийн газар байна.

17.2.Төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийг Засгийн газрын шийдвэрээр тогтооно.

17.3.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь нэг этгээд байна.

17.4.Орон нутгийн өмчит компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигч нь аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байна.

17.5.Орон нутгийн өмчит компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга байна.

**18 дугаар зүйл.Төрийн өмчит компанийн талаарх Засгийн
газрын бүрэн эрх**

18.1.Засгийн газар төрийн өмчит компанийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1.төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийг тогтоох;

18.1.2.төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

18.1.3.энэ хуульд заасан үндэслэлээр төрийн өмчийн компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх, алтан хувьцаа гаргах болон төрийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах;

18.1.4.энэ хуулийн 8.1.2-т заасан үндэслэлээр үүсгэн байгуулсан төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг Улсын Их Хурлын зөвшөөрлийн үндсэн дээр бусдад шилжүүлэх, барьцаалуулах;

18.1.5.төрийн өмчийн оролцоотой компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл олгох;

18.1.6.төрийн өмчийн компанийн газар, үл хөдлөх эд хөрөнгө, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх, худалдах, солих шийдвэр гаргах;

18.1.7.энэ хуулийн 13.2-т заасны дагуу хориг тавих;

18.1.8.хуульд заасан бусад бүрэн эрх.

19 дүгээр зүйл.Орон нутгийн өмчит компанийн талаарх аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

19.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн өмчит компанийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1.орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, орон нутгийн эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах;

19.1.2.орон нутгийн өмчийн оролцоотой компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл олгох;

19.1.3.орон нутгийн өмчийн компанийн үл хөдлөх эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх, худалдах, солих шийдвэр гаргах;

19.1.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

20 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн бүрэн эрх

20.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн талаар төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.1.1.төрийн болон орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, хувьцааг худалдах, шилжүүлэх, төрийн, эсхүл орон нутгийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх асуудлаар Засгийн газар, эсхүл иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал хүргүүлэх;



20.1.2.төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг хуульд заасан журмын дагуу томилох, чөлөөлөх;

20.1.3.төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх талаар саналын эрхийг хэрэгжүүлэх;

20.1.4.төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага хууль болон компанийн дүрэмд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд дүрэм болон гэрээнд заасан хариуцлага хүлээлгэх, компанид хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлөхийг шаардах, шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах;

20.1.5.төрийн болон орон нутгийн өмчит компанийн гүйцэтгэх удирдлага хууль болон компанийн дүрэмд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд компанийн дүрэм болон гэрээнд заасан хариуцлага хүлээлгэх саналаа төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэх;

20.1.6.төрийн болон орон нутгийн өмчийн компанийн бизнес төлөвлөгөө болон төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэх;

20.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

21 дүгээр зүйл.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газрын чиг үүрэг

21.1.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компанийн засаглалд оролцогч талуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогын биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

21.2.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит компанийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.2.1.төрийн өмчит компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлаар дүгнэлт гаргаж, төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх;

21.2.2.төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх, алтан хувьцаа гаргах болон төрийн

өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх асуудлаар дүгнэлт гаргаж, Засгийн газарт хүргүүлэх;

21.2.3.төрийн өмчийн компанийн үл хөдлөх эд хөрөнгө, газар эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх, худалдах, солих шийдвэр гаргах асуудлаар дүгнэлт гаргаж, Засгийн газарт хүргүүлэх;

21.2.4.төрийн өмчийн компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах талаар шаардлага, зөвлөмж өгөх, хуульд заасан үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагыг чөлөөлөх, хариуцлага хүлээлгэх саналыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх;

21.2.5.төрийн өмчит компанийг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг Засгийн газарт тайлагнах;

21.2.6.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;

21.2.7.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, бүрэн эрхийн хугацаа, гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын хэмжээ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

21.2.8.төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан өмчлөлийн бодлогын хэрэгжилтийн тайланг жил бүр хүлээн авч, хянах;

21.2.9.төрийн өмчийн компанийн төрийн өмчийн ашиглалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавих;

21.2.10.төрийн өмчит компаниас төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг энэ хуульд заасан зарчмыг баримталж, тухайн жилийн төсвийн тухай хуульд заасны дагуу бүрэн төвлөрүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

21.2.11.хуульд заасан бусад чиг үүрэг.

21.3.Орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар нь орон нутгийн өмчит компанийн талаар энэ хуулийн 21.2-т заасан чиг үүргийг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлнэ.



ТАВДУГААР БҮЛЭГ КОМПАНИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

22 дугаар зүйл.Хувьцаа эзэмшигчдийн хурал

22.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Компанийн тухай хуульд зааснаар зохицуулна.

22.2.Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг энэ хуулийн 17.2, 17.5-д заасан этгээд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хувьд дангаараа, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан, эсхүл тэдгээрийн оролцоотой компанийн хувьд бусад этгээдтэй хамтран хэрэгжүүлнэ.

22.3.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчит компанийн нэгдлийн хараат, охин компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг толгой компанийн гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.

23 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөл

23.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.1.1.компанийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

23.1.2.компанийн гүйцэтгэлийн үнэлгээний санхүүгийн ба санхүүгийн бус шалгуур үзүүлэлтийг тогтоож, хэрэгжилтийг үнэлэх;

23.1.3.компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гадна хүний эрх, авлига, тэгш боломж, хөдөлмөр, мэдээллийн аюулгүй байдал, хувийн мэдээлэл хамгаалалт, өрсөлдөөн, байгаль орчин, татвар, эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой эрсдэлийн удирдлага болон хянан нийцүүлэлтийн нэгдсэн бодлогыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

23.1.4.компанийн гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийг үнэлж, хянах;

23.1.5.компанийн удирдах ажилтны залгамж халааны бодлогыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих.

23.2.Энэ хуулийн 24.4-т заасан төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 81.2-т заасан хороодтой байх бөгөөд хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүд байна.

23.3.Энэ хуулийн 24.7-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ аудитын хороотой байна.

23.4.Төлөөлөн удирдах зөвлөлгүй төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд түүний бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч хэрэгжүүлнэ.

24 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид тавих шаардлага

24.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна:

24.1.1.Эрүүгийн хуульд заасан эдийн засгийн, авлигын, нийтийн албаны ашиг сонирхлын, өмчлөх эрхийн, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй;

24.1.2.компанийн үйл ажиллагаа хамаарах салбарын болон санхүүгийн мэдлэг, туршлагатай, төрийн өмчит компанийн хувьд удирдах албан тушаалд таваас доошгүй, орон нутгийн өмчит компанийн хувьд удирдах албан тушаалд хоёроос доошгүй жил ажилласан, эрх зүй, санхүү, аудит, нягтлан бодох бүртгэл, бизнесийн удирдлага, эдийн засаг, эсхүл тухайн компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн;

24.1.3.сүүлийн хоёр жил улс төрийн намын удирдах албан тушаал хашиж байгаагүй, эсхүл улс төрийн албан тушаал хашдаггүй байх;

24.1.4.эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээд төлбөрийн чадваргүй болж дампуурсан нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон;

24.1.5.эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй болгосон нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон;



24.1.6.доор дурдсан ашиг сонирхлын зөрчилтэй этгээд биш байх:

24.1.6.а.тухайн компанийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн тав болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшигч;

24.1.6.б.тухайн компанитай адил салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн эрх бүхий албан тушаалтан;

24.1.6.в.төрийн болон орон нутгийн өмчит компанийн ажил, үйлчилгээг хүлээн авах, бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах, эсхүл тус компанид ажил, үйлчилгээ үзүүлэх, бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх, худалдах үйл ажиллагаа явуулах байдлаар компанитай их хэмжээний хэлцэл байгуулсан аливаа этгээдийн эрх бүхий албан тушаалтан;

24.1.6.г.төрийн болон орон нутгийн өмчит компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчтэй хамаарал бүхий, эсхүл нэгдмэл сонирхолтой.

24.1.7.Компанийн тухай хуулийн 75.8-д заасан шаардлагыг хангасан байх;

24.1.8.компанийн дүрэмд заасан бусад шаардлага.

24.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажилладаг компани нь төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани бол энэ хуулийн 24.1.6.б-д заасан нөхцөл хамаарахгүй.

24.3.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх удирдлага тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болохгүй.

24.4.Арилжааны зорилго бүхий төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь сондгой тооны таваас ес хүртэлх гишүүнтэй байна.

24.5.Энэ хуулийн 24.4-т заасан төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний төрийн болон орон нутгийн төлөөллийн нэг гишүүн нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс санал болгож, томилогдсон этгээд байна.

24.6.Энэ хуулийн 24.4-т заасан төлөөлөн удирдах зөвлөл нь 5 гишүүнтэй бол хоёроос, 7 гишүүнтэй бол гурваас, 9 гишүүнтэй бол дөрвөөс

доошгүй нь хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүнийг Компанийн тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулна.

24.7.Энэ хуулийн 37.9-д заасан нөхцөлөөс доош үзүүлэлттэй, эсхүл нийтийн үйлчилгээний салбарын төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл таван гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн хоёроос доошгүй нь хараат бус гишүүн байна.

24.8.Энэ хуулийн 24.5-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн төлөөллийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилох бөгөөд төрийн захиргааны албан хаагч нэрээ дэвшүүлж, сонгон шалгаруулалтад оролцож болно.

24.9.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ хуулийн 24.1-д заасан шаардлагыг хангаагүй этгээдийг төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилох, томилуулахаар нэр дэвшүүлэх, эсхүл дэмжиж санал өгөхийг хориглоно.

25 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалт

25.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилно.

25.2.Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн өмчит компанийг үүсгэн байгуулах шийдвэр гарсан, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сул орон тоо гарснаас хойш ажлын таван өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах захиалгыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

25.3.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг 30 хоногийн дотор зохион байгуулж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид санал болгоно.

25.4.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа тухайн салбарт үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус байгууллага, мэргэжлийн нэгдсэн холбооны төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг байгуулна.



25.5.Энэ хуулийн 25.3-т заасны дагуу санал болгосон нэр дэвшигчээс бусад нэр дэвшигчийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэр дэвшигчийн нөөцийн сан үүсгэн бүртгэнэ.

25.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн нөөцөд байх хугацаа хоёр жил байна.

25.7.Энэ хуулийн 25.5-д заасан нөөцийн санд бүртгэгдсэн нэр дэвшигчээс төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний шаардлага хангаж байгаа хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд санал болгож болно.

25.8.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа болон нэр дэвшигчийн нөөц сангийн журмыг Засгийн газар батална.

25.9.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах журам, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, нэр дэвшигч тус бүрийн үнэлгээний оноо, нэр дэвшигчийн нөөцийн сангийн мэдээллийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд нээлттэй, ил тод байршуулна.

26 дугаар зүйл.Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалт

26.1.Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг тухайн аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар зохион байгуулна.

26.2.Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасныг баримтална.

27 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн сонгон шалгаруулалтад оролцогчоос шаардах мэдээлэл

27.1.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 25.2-т заасан захиалга ирүүлснээс хойш ажлын таван өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах тухай зарыг өөрийн цахим хуудас, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.

27.2.Энэ хуулийн 24.1-д заасан шаардлагыг хангасан иргэн сонгон шалгаруулалтыг нийтэд зарласнаас хойш 14 хоногийн дотор дараах мэдээллийг нотолсон баримт бичгийг бүрдүүлэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газарт сонгон шалгаруулалтад оролцох тухай хүсэлтээ хүргүүлсэн байна:

27.2.1.эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, боловсролын байдлын талаарх баримт бичиг, холбоо барих мэдээлэл;

27.2.2.сүүлийн таван жилийн ажил эрхлэлт, хувийн эрх зүйн хуулийн этгээдэд эрх бүхий албан тушаал эрхэлж байсан мэдээллийг агуулсан ажлын туршлагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

27.2.3.сонгон шалгаруулалтад оролцогч өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь дангаараа болон хамтран тав, түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, тухайн компанийн сүүлийн таван жилд үйл ажиллагаа эрхэлсэн салбарын жагсаалт, санхүүгийн үзүүлэлт зэрэг мэдээлэл.

28 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох

28.1.Энэ хуулийн 25.3, 25.7-д заасны дагуу санал болгосон нэр дэвшигчийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ хуулийн 24.1-д заасан шаардлага хангасан тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилно.

28.2.Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд санал болгоно.

28.3.Энэ хуулийн 28.1, 28.2-т заасны дагуу томилогдсон төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрх томилогдсон өдрөөс эхэлж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөнөөр дуусгавар болно.

28.4.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг энэ хуулийн 24.1-д заасан шаардлага хангаагүй үндэслэлээр томилохоос татгалзсан тохиолдолд ажлын таван өдрийн дотор төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн



захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар дараагийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг санал болгоно.

28.5.Энэ хуулийн 28.4-т заасан хугацаанд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн томилогдоогүйн улмаас төрийн болон орон нутгийн өмчит компанийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, компанид учирсан хохирлыг гэм буруутай этгээд хариуцна.

28.6.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилох, эсхүл томилуулахаар санал болгохдоо жендэрийн эрх тэгш байдал буюу төлөөлөн удирдах зөвлөл дэх хүйсийн тэнцвэртэй байдлыг харгалзана.

28.7.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа хоёр жилээс хэтрэхгүй байх бөгөөд нэг удаа хоёр жил хүртэл хугацаагаар улируулан томилж болно. Улируулан томилох тохиолдолд энэ хуулийн 42.1-д заасны дагуу тухайн гишүүний ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хангалттай гэж үнэлэгдсэн байна.

28.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг албан тушаалын байдлаар томилохгүй.

29 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүрэг, хариуцлага

29.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн дараах үүрэгтэй:

29.1.1.эрх, үүргээ компанийн ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх;

29.1.2.хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд биечлэн, эсхүл зайнаас оролцох, шийдвэр гаргахад саналаа өгөх;

29.1.3.шийдвэр гаргахад шаардагдах бүх мэдээлэлтэй танилцаж, үндэслэл бүхий шийдвэр гаргах;

29.1.4.албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглах, компанийн хөрөнгө, компанийн талаарх мэдээ, мэдээлэл, бизнесийн нууцыг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

29.1.5.албаны чиг үүрэг нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний чиг үүргээс тусгаарлагдсан байх;

29.1.6.өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь дангаараа, эсхүл хамтран тухайн компани, эсхүл ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг бусад компанийн хувьцаа эзэмшигч болсон даруйд мэдэгдэх;

29.1.7.компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд үл хамаарах их хэмжээний хэлцэл хийх төлөвлөгөөг тухай бүр хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид мэдэгдэх;

29.1.8.Банкны тухай хуулийн⁹ 31.4.3, 31.4.4, 31.4.5-д заасан болон компанийн дүрэмд заасан бусад.

29.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын ирц гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчинтэй болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр нийт гишүүдийн олонхын саналаар хүчин төгөлдөр болно.

29.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдахаас ажлын гурваас доошгүй өдрийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, холбогдох материалыг хурал болсноос хойш нэг сараас дээшгүй хугацааны дотор хурлаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.

29.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ хууль, Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, эсхүл гишүүн энэ тухай нотлох баримтын хамт бичгээр хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид мэдэгдэл хүргүүлж, холбогдох арга хэмжээ авна.

29.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх журам, хариуцлагын хэмжээг тогтоох аргачлалыг компанийн дүрэмд тусгасан байна.

29.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний санал өгөх, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч доор дурдсанаас бусад тохиолдолд оролцож, удирдамж, чиглэл өгөхийг хориглоно:

29.6.1.ногдол ашгийн бодлогыг батлах, хэрэгжүүлэх;

29.6.2.төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг хэрэгжүүлэх.

29.7.Төрийн болон орон нутгийн өмчийн төлөөлөл нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ компанийн ашиг

⁹ Банкны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2010 оны 07 дугаарт нийтлэгдсэн.



сонирхол, хуульд заасан үүрэг, хариуцлагыг тэргүүн ээлжид баримтлах бөгөөд энэ хуулийн 29.6-д заасан удирдамж, чиглэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн баримтлах эсэхийг бие даан шийдвэрлэнэ.

29.8.Төрийн болон орон нутгийн өмчийн төлөөлөл нь энэ хуулийн 29.6-д заасан удирдамж, чиглэлийг баримталсан, эсхүл баримтлаагүй нь түүнийг Компанийн тухай хууль болон бусад хуульд заасан үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

29.9.Энэ хуулийн 29.6-д заасан удирдамж, чиглэлийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч бүртгэж хадгална.

30 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшуулал

30.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн цалин, урамшуулалтай байна.

30.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээг төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч дараах журмаар тогтооно:

30.2.1.нийтийн үйлчилгээний төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээг тухайн компанийн гүйцэтгэх удирдлагын албан тушаалтны цалингийн жишгийг харгалзан төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналаар;

30.2.2.энэ хуулийн 30.2.1-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээг тухайн компанийн хөрөнгийн хэмжээ, ашигт ажиллагаа, зах зээл дэх хувийн хэвшлийн цалингийн жишгийг баримтлан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин, урамшууллын хорооны саналаар.

30.3.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ адил байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь аудитын хороо болон төлөөлөн удирдах зөвлөлийн бусад хороонд ажилласан бол нэмэгдэл урамшуулал авч болно.

30.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ хуульд заасан цалин, урамшууллаас бусад тусгайлсан хангамж эдлэхгүй.

30.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөхөд нөхөн төлбөр, олговор зэрэг аливаа хэлбэрийн тэтгэмж олгохыг хориглоно.

30.6.Энэ хуулийн 29.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол урамшуулал тогтоох эрх бүхий этгээдээс төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд урамшуулал олгохыг зогсоох, эсхүл үүргээ биелүүлээгүй, эсхүл хуралдаанд оролцоогүй тухайн хугацаанд хамаарах хувь хэмжээгээр урамшууллын хэмжээг бууруулна.

30.7.Энэ хуулийн 30.6-д заасны дагуу урамшуулал олгохыг зогсоох, эсхүл бууруулах арга хэмжээ нь урамшуулал тогтоох эрх бүхий этгээдээс компанийн гүйцэтгэх удирдлагад хандан энэ тухай бичгээр гаргасан мэдэгдэлд үндэслэнэ.

30.8.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд урамшуулал олгох аргачлалыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

30.9.Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, урамшууллын талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй, ил тод байна.

31 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх

31.1.Төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч дараах үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөх, эсхүл чөлөөлөх санал гаргана:

31.1.1.энэ хуулийн 24.1-д заасан шаардлагыг хангахгүй болох нь нотлогдсон;

31.1.2.хууль, компанийн дүрэмд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй, үүргээ ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэл гаргасан, эсхүл ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр удаа дараа хангалтгүй үнэлэгдсэн;

31.1.3.гэмт хэрэг үйлдсэнийг шүүхээс тогтоож, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

31.1.4.албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашигласан, компанийн хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашигласан;



31.1.5.эрх бүхий байгууллагаас тухайн албан тушаалыг эрхлэхтэй холбоотой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, эрхийг хүчингүй болгосон;

31.1.6.үүргээ гүйцэтгэх боломжгүй болох нөхцөл байдал бий болсон, өөрөө чөлөөлөгдөх хүсэлт гаргасан.

31.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн энэ хуулийн 31.1.1, 31.1.2, 31.1.3, 31.1.4-т заасан үйлдлийн улмаас компанид учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

32 дугаар зүйл.Гүйцэтгэх удирдлага, түүнд нэр дэвшигчид тавих шаардлага

32.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна:

32.1.1.энэ хуулийн 24.1-д заасан шаардлагыг хангасан байх;

32.1.2.бизнесийн удирдлага, эрх зүй, санхүү, аудит, эсхүл компанийн үйл ажиллагаанд хамаарах салбарын мэдлэг, туршлагатай байх;

32.1.3.өөрийн буруутай үйл ажиллагаанаас төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, захирал, дэд захирлын албан тушаалаас чөлөөлөгдөөгүй байх;

32.1.4.бусад компанид гүйцэтгэх удирдлагын албан тушаал давхар эрхэлдэггүй байх;

32.1.5.компанийн дүрэмд заасан бусад шаардлага.

32.2.Энэ хуулийн 32.1-д заасан шаардлагыг хангасан нэр дэвшигч нь гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлэх зорилтот түвшний мэдэгдэл боловсруулж, сонгон шалгаруулах комисст хүргүүлнэ.

32.3.Энэ хуулийн 32.2-т заасан зорилтот түвшний мэдэгдэл дараах агуулгатай байна:

32.3.1.нээлттэй өгөгдөл, мэдээлэлд үндэслэсэн компанийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам, бүрэн эрхийн хугацаанд хүргэхээр зорьж байгаа үр дүн, түүнтэй уялдсан урамшууллын хувилбар;

32.3.2.компанийн эрхэм зорилго, зорилт, хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн хүлээлтийг хэрхэн төсөөлж байгаа болон түүнийг биелүүлэхэд хангалттай ажлын туршлага, ур чадвартай болохоо бататгасан тайлбар, нотолгоо;

32.3.3.компанийн үндсэн үйл ажиллагааг зах зээлийн зарчимд нийцүүлэн зорилтот түвшинд хүргэн удирдах, өөрчлөлтийг хэрэгжүүлэх арга хэмжээ, нөөц бололцоо, учирч болзошгүй эрсдэл, хязгаарлалтын талаар.

32.4.Компанийн гүйцэтгэх удирдлагыг хуульд заасан шаардлагыг хангасан хараат бус, мэргэжлийн багаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

33 дугаар зүйл. Гүйцэтгэх удирдлагыг томилох

33.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл гүйцэтгэх удирдлагыг томилж, гурав хүртэлх жилийн хугацаатай даалгаврын гэрээ байгуулан ажиллуулна. Тухайн жилийн компанийн гүйцэтгэлийн үнэлгээ болон гүйцэтгэх удирдлагын ажлын үнэлгээг үндэслэн гэрээг сунгана.

33.2.Энэ хуулийн 33.1-д заасан гэрээнд гүйцэтгэх удирдлагын ажлын зорилт, санхүүгийн болон үйл ажиллагааны хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, цалин хөлс, урамшууллын хэмжээ, түүнийг олгох журам, эрх, үүрэг, хүлээлгэх хариуцлага, түүний эрх хэмжээг түдгэлзүүлэх, чөлөөлөх үндэслэл, журам болон үйл ажиллагааны талаар тайлагнах хуваарийг тусгана.

33.3.Энэ хуулийн 33.1-д заасан гэрээг байгуулахдаа үл өрсөлдөх, нууц хадгалах үүрэг хүлээлгэх гэрээний нэмэлт нөхцөлийг тусган хэрэгжүүлж болно.

34 дүгээр зүйл. Гүйцэтгэх удирдлагын үүрэг

34.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх удирдлага дараах үүрэгтэй:

34.1.1.компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, албаны чиг үүрэг, бүрэн эрхийг хууль, компанийн дүрэмд нийцүүлэн хэрэгжүүлэх;

34.1.2.компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай бүх арга хэмжээг шуурхай авах;



34.1.3.төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төсвийн хүрээнд компанийн үйл ажиллагааг эрхлэн явуулах;

34.1.4.компанийн талаарх мэдээ, мэдээлэл, байгууллагын болон бизнесийн нууц, хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй, эсхүл бусдад задруулахгүй байх;

34.1.5.аудитын хороо, дотоод аудитын нэгж, хөндлөнгийн аудитын хуулийн этгээдийг чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

34.1.6.компанийн санхүүгийн үзүүлэлт, үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад шаардлагатай бүх арга хэмжээг авах;

34.1.7.санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд¹⁰ заасан журмыг баримтлан бэлтгэж, ил тод тайлагнах;

34.1.8.хууль болон компанийн дүрэмд зааснаас бусад үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх;

34.1.9.энэ хуулийн 48 дүгээр зүйлд заасан мэдээллийг компанийн цахим хуудсанд тухай бүр ил тод, нээлттэй байршуулах, эрх бүхий этгээдэд тайлагнах.

34.2.Гүйцэтгэх удирдлага хууль, компанийн дүрэмд заасан үүргээ зөрчсөн бол төлөөлөн удирдах зөвлөлийн дарга энэ тухай мэдэгдлийг нотлох баримтын хамт хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид бичгээр хүргүүлж, холбогдох арга хэмжээг авна.

35 дугаар зүйл.Гүйцэтгэх удирдлагын цалин хөлс, урамшуулал

35.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх удирдлагын цалин хөлс, урамшууллын хэмжээг энэ хуулийн 33.1-д заасан гэрээгээр тохиролцоно.

35.2.Компанийн хөрөнгийн өгөөж, ашигт ажиллагаа, зах зээлд эзлэх байр суурь өсөн нэмэгдсэн бол гүйцэтгэх удирдлагад урамшуулал олгохоор гэрээнд зааж болно.

35.3.Гүйцэтгэх удирдлага гэрээнд зааснаас бусад чиг үүргийг хэрэгжүүлсэн боловч тухайн чиг үүрэгт тохирсон цалин хөлс, урамшуулал олгохоор гэрээнд заагаагүй бол аливаа цалин хөлс, урамшуулал олгохгүй.

¹⁰ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

35.4.Гүйцэтгэх удирдлагын цалин хөлс, урамшууллын талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй, ил тод байна.

36 дугаар зүйл.Гүйцэтгэх удирдлагыг чөлөөлөх

36.1.Дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх удирдлагыг ажлаас чөлөөлж, гэрээг хугацаанаас нь өмнө цуцална:

36.1.1.үйлдвэрлэлийг өргөжүүлэх, технологийг шинэчлэхэд хөрөнгө оруулснаас бусад тохиолдолд компанийг хоёр жил дараалан алдагдал хүлээлгэсэн, эсхүл гэрээнд заасан санхүүгийн зорилтот үзүүлэлтийг хоёр жил дараалан хангаж чадахгүй болсон;

36.1.2.компанийн гүйцэтгэлийн үнэлгээ хоёр жил дараалан хангалтгүй гэж үнэлэгдсэн;

36.1.3.компани төлбөрийн чадваргүй болсон талаар төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдээгүй, дампуурлын хүсэлт гаргаагүй;

36.1.4.хууль болон компанийн дүрэм, гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл ноцтой зөрчсөн;

36.1.5.компанийн санхүүгийн байдлын талаар худал мэдээлэл өгсөн;

36.1.6.төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан компанийн төсвийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн;

36.1.7.гэмт хэрэг үйлдсэнийг шүүхээс тогтоож, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

36.1.8.энэ хуулийн 32.1-д заасан шаардлагыг хангахгүй болох нь нотлогдсон;

36.1.9.компанийн шинэ бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны стратеги бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, туршлага, чадвар хангалтгүй байх;

36.1.10.албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашигласан, компанийн хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашигласан;

36.1.11.эрх бүхий байгууллагаас тухайн гүйцэтгэх удирдлагын ажил үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, эрхийг хүчингүй болгосон;



36.1.12.үүргээ гүйцэтгэх боломжгүй болох нөхцөл байдал бий болсон, өөрөө чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;

36.1.13.санхүүгийн тайланд хийсэн аудитаар хоёр жил дараалан өөрчлөлттэй дүгнэлт авсан;

36.1.14.компанийн олж авсан хөрөнгийг компанийн өмчид бүртгээгүй, бүртгэлгүй ашигласан.

36.2.Гүйцэтгэх удирдлага нь энэ хуулийн 36.1-д заасан үйлдлийн улмаас компанид учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

36.3.Гүйцэтгэх удирдлагын буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх журам, хариуцлагын хэмжээг тогтоох аргачлалыг тухайн компанийн дүрэмд тусгасан байна.

36.4.Гүйцэтгэх удирдлагын ажлаас чөлөөлөгдсөн этгээд нь ажлаа бүрэн хүлээлцэх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг нөхөн төлнө.

36.5.Энэ хуулийн 36.1.1-д заасан тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит нийтийн үйлчилгээний компани, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч болон төслийн санхүүжилттэй компанид хамаарахгүй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

37 дугаар зүйл.Компанийн аудитын тогтолцоо

37.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн аудитын тогтолцоо нь төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо, дотоод аудитын нэгж, дотоод аудитор, хөндлөнгийн аудитаас бүрдэнэ.

37.2.Энэ хуулийн 37.1-д заасан аудитын хорооны дарга нь санхүү, аудит, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна.

37.3.Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална. Журамд аудитын хороо, дотоод аудитын нэгж, гүйцэтгэх удирдлага, хөндлөнгийн аудитын хуулийн этгээдийн хооронд мэдээлэл солилцох арга хэлбэр, бүтэц, зохион байгуулалтыг тусгана.

37.4.Төрийн болон орон нутгийн өмчийн компани жил бүрийн санхүүгийн тайлангаа баталгаажуулах, хараат бус мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргуулах зорилгоор санхүүгийн тайлангийн аудит хийлгэнэ.

37.5.Төрийн аудитын байгууллага тайлант жилийн улсын хөгжлийн бодлого, тухайн жилийн санхүүгийн төлөв байдал, урьдчилсан судалгаа, эрсдэлийн үнэлгээг хийж, өмнөх оны гүйцэтгэсэн аудитын дүн, хүний нөөц, төсөв, санхүү бусад хүчин зүйлд үндэслэн санхүүгийн тайлангийн аудит хийх төрийн болон орон нутгийн өмчийн компанийг сонгон гүйцэтгэнэ.

37.6.Төрийн аудитын байгууллагаас энэ хуулийн 37.5-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн өмчит компанийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдэд тавих тусгай шаардлагыг Засгийн газарт хүргүүлнэ.

37.7.Энэ хуулийн 37.6-д заасан хөндлөнгийн аудит хийх хуулийн этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд¹¹ заасан журмын дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээс төлөөлөн удирдах зөвлөл сонгон шалгаруулна.

37.8.Энэ хуулийн 7.1-д заасан өмчлөлийн бодлогод нийцүүлэн тухайн жилд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр санхүүгийн аудит хийлгэх төрийн өмчит компанийн жагсаалт болон аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно.

37.9.Төрийн болон орон нутгийн өмчийн компани нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр дараах нөхцөлийг хангасан тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд дотоод аудитын нэгжтэй байна:

37.9.1.нийт ашгийн хэмжээ нь 200 сая төгрөгөөс дээш байх;

37.9.2.борлуулалтын орлогын хэмжээ хоёр тэрбум төгрөгөөс дээш байх.

37.10.Энэ хуулийн 37.9-д заасан нөхцөлөөс доош үзүүлэлттэй төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл дотоод аудитын нэгжтэй байх нь эдийн засгийн хувьд оновчтой гэж дүгнэсэн тохиолдолд энэ тухай шийдвэр гаргаж болно.

¹¹ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2023 оны 35 дугаарт нийтлэгдсэн.



37.11.Дотоод аудитын нэгж нь компанийн үйл ажиллагааны цар хүрээ, эдийн засгийн үр ашгаас хамааран төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тооны дотоод аудиторос бүрдэнэ.

37.12.Дотоод аудитын нэгж нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан үйл ажиллагааны журмын дагуу компанийн үйл ажиллагаанд ээлжит болон ээлжит бус дотоод аудит хийж, дүгнэлт гаргах ба дүгнэлтээ гүйцэтгэх удирдлагад танилцуулж, төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх аудитын хороонд тайлагнана.

37.13.Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, аудиторын эрх, үүрэг, аудитыг зохион байгуулах хэлбэр, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, дүгнэлт, зөвлөмж гаргахтай холбогдсон харилцааг хуульд нийцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо болон дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны журмаар тогтооно.

37.14.Энэ хуулийн 37.9-д заасан нөхцөлөөс доош үзүүлэлттэй төрийн болон орон нутгийн өмчийн компани нь дотоод аудитын нэгж байгуулахгүйгээр төлөөлөн удирдах зөвлөлийн харьяанд дотоод аудитор ажиллуулна.

37.15.Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь дотоод аудитын үйл ажиллагааг хараат бусаар явуулах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

38 дугаар зүйл.Компанийн дотоод аудитын чиг үүрэг

38.1.Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод аудитын нэгж, дотоод аудитор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

38.1.1.компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл холбогдох хууль тогтоомж, олон улсын стандартад нийцэж байгаа эсэх, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээлэл үнэн зөв эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах;

38.1.2.компанийн эрхэм зорилго, бизнес төлөвлөгөө, эрсдэлийн удирдлага, засаглалын үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах замаар компанийг зорилтоо биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

38.1.3.компанийн бүх нэгжийн үйл ажиллагаанд ээлжит болон ээлжит бус шалгалт хийж, дүгнэлт гаргах ба дүгнэлтээ төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад танилцуулах;

38.1.4.компанийн засаглал болон үйл ажиллагаа холбогдох хууль, дүрэм, журамд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;

38.1.5.компанийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал, цаг хугацаандаа, үнэн зөв, бүрэн тайлагнаж байгаа эсэхэд хяналт тавих;

38.1.6.төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

38.1.7.компанийн төсөв, хөрөнгө, нөөцийн ашиглалт, зарцуулалт хэмнэлттэй, үр ашигтай, үр өгөөжтэй байгаа эсэхэд аудит хийж, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах;

38.1.8.компанийн дүрэм болон компанийн дотоод аудитын дүрэмд заасан бусад.

ДОЛДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИ, ТҮҮНИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ

39 дүгээр зүйл.Компанийн бизнес төлөвлөгөө, түүний гүйцэтгэл

39.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлтэй гэрээ байгуулснаас хойш нэг сарын дотор энэ хуулийн 33.1-д заасан хугацаанд хэрэгжүүлэх компанийн бизнес төлөвлөгөөг боловсруулан төлөөлөн удирдах зөвлөлд батлуулахаар хүргүүлнэ.

39.2.Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлийн хянаж, баталсан бизнес төлөвлөгөөг төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.

39.3.Гүйцэтгэх удирдлага компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.

39.4.Энэ хуулийн 39.1-д заасан компанийн бизнес төлөвлөгөөнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө, эрсдэлийг багасгах болон компанийн тогтвортой хөгжлийн бодлогын арга хэмжээг тусган хэрэгжүүлнэ.



40 дүгээр зүйл.Компанийн гүйцэтгэлийн үнэлгээ

40.1.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гүйцэтгэх удирдлагын гэрээний хэрэгжилтийн тайланд үндэслэн жил бүр төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийг үнэлнэ.

40.2.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ хуулийн 40.1-д заасны дагуу компанийн гүйцэтгэлийн үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг ирүүлэхийг компанийн удирдлагаас шаардах эрхтэй.

40.3.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийг үнэлэх шалгуур, аргачлал, үнэлгээний журмыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар батална.

40.4.Арилжааны зорилго бүхий төрийн болон орон нутгийн өмчийн компанийн энэ хуулийн 40.3-т заасан гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурт дараах асуудлыг хамааруулна:

40.4.1.компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийн түвшин;

40.4.2.компанийн бүтэц, зохион байгуулалт, засаглал, эрсдэлийн удирдлага, хүний нөөцийн зохистой менежмент;

40.4.3.санхүүгийн менежмент, төсвийн хэмнэлт, хэтрэлт;

40.4.4.гүйцэтгэлийн үр дүнд суурилсан урамшууллын тогтолцоо;

40.4.5.борлуулалтын орлого, ашгийн хэмжээ, төлбөрийн чадвар, санхүүгийн тогтвортой байдал, хөрөнгийн ашиглалт, өөрийн хөрөнгийн өгөөж, ашигт ажиллагаа, мөнгөн урсгалын зорилтот түвшин;

40.4.6.мэдээллийн ил тод байдал.

40.5.Нийтийн үйлчилгээний компанийн энэ хуулийн 40.3-т заасан гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурт дараах асуудлыг хамааруулна:

40.5.1.компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийн түвшин болон нийтийн үйлчилгээний үүргийн биелэлт;

40.5.2.компанийн бүтэц, зохион байгуулалт, засаглал, эрсдэлийн удирдлага, хүний нөөцийн зохистой менежмент;

40.5.3.санхүүгийн менежмент, төсвийн хэмнэлт, хэтрэлт, төсөв, татаасын ашиглалт, нэгж үйлчилгээний өртөг, зардлын үр ашиг;

40.5.4.үйлчилгээний чанар, хүртээмж;

40.5.5.ашиглаж байгаа үндсэн хөрөнгө, дэд бүтцийн найдвартай ажиллагаа;

40.5.6.мэдээллийн ил тод байдал.

40.6.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор хийж, үнэлгээний тайланг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

40.7.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 40.4, 40.5-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийн үнэлгээний тайланг нэгтгэж, Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

40.8.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл хангалтгүй үнэлэгдсэн бол хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, эсхүл төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар гүйцэтгэх удирдлагыг чөлөөлүүлэхээр төлөөлөн удирдах зөвлөлд санал гаргах эрхтэй.

40.9.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар нь аудитор болон компанийн бусад эрх бүхий албан тушаалтан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй бол албан тушаалаас чөлөөлүүлэх санал гаргах эрхтэй.

40.10.Энэ хуулийн 36.5-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн өмчийн компани үйлдвэрлэлийг өргөжүүлэх, технологийг шинэчлэхэд хөрөнгө оруулснаас бусад тохиолдолд 2 жил дараалан санхүүгийн зорилтот үр дүнд хүрээгүй бол өөрчлөн байгуулах, татан буулгах, эсхүл хувьцааг шилжүүлэх, худалдах арга хэмжээг авна.

40.11.Эрх бүхий байгууллагын шийдвэрээр нийтийн ашиг сонирхлын зорилгоор үнэ, тарифыг өртгөөс доогуур тогтоосон, эсхүл нийтийн үйлчилгээний үүргийн хүрээнд компанид нэмэлт санхүүгийн үүрэг хүлээлгэснээс үүссэн орлогын зөрүү, алдагдлыг компанийн үйл ажиллагааны үр ашиггүй байдалд тооцохгүй бөгөөд гүйцэтгэлийн үнэлгээнд нотлох баримтад үндэслэн залруулж тусгана.



40.12.Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хуулийн 40.3-т заасан журамд нийцүүлэн компанийн тэнцвэржүүлсэн гүйцэтгэлийн үнэлгээний аргачлалыг баталж, хэрэгжилтэд хяналт тавина. Уг аргачлалд энэ хуулийн 40.4, 40.5-д заасан болон тухайн компанийн үйл ажиллагааны онцлогт нийцсэн бусад үзүүлэлтийг уялдуулан үнэлэх, тайлагнах, бизнес төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг тодорхойлох зохицуулалтыг тусгана.

Тайлбар: - Энэ хуулийн “Тэнцвэржүүлсэн гүйцэтгэлийн үнэлгээний аргачлал” гэж төрийн болон орон нутгийн өмчит компанийн стратеги, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг санхүүгийн үр дүн, эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөө, хэрэглэгчийн сэтгэл ханамж, үйлчилгээний чанар, үйл ажиллагааны үр ашиг, байгууллагын чадавх, хүний нөөцийн хөгжлийн үзүүлэлтээр тэнцвэртэй хэмжиж, үнэлэх, тайлагнах арга зүйн зохицуулалтыг ойлгоно.

41 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэл

41.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн бизнес төлөвлөгөө батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор бизнес төлөвлөгөөтэй уялдуулан тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.

41.2.Энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний хувийг төрийн өмчийн компанийн хувьд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн компанийн хувьд орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газарт хүргүүлнэ.

41.3.Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг жил бүр гаргаж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

42 дугаар зүйл.Ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээ

42.1.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлнэ.

42.2.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд шаардлагатай бусад мэдээллийг ирүүлэхийг шаардах эрхтэй.

42.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлэх аргачлалыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

НАЙМДУГААР БҮЛЭГ
НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАХ, ТӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦААГ
ШИЛЖҮҮЛЭХ, КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

43 дугаар зүйл.Энгийн хувьцаа нэмж гаргах, арилжих

43.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани энэ хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн энгийн хувьцаа нэмж гаргаж, дараах хэлбэрээр үнэт цаасны зах зээлд санал болгож хөрөнгө оруулалт татаж болно:

43.1.1.хуульд заасны дагуу нийтэд санал болгох, эсхүл хаалттай хүрээнд санал болгох;

43.1.2.хуульд заасны дагуу үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад давхар бүртгүүлэн санал болгох;

43.1.3.хуульд заасан бусад хэлбэрээр дотоодын болон гадаадын үнэт цаасны зах зээлд санал болгох.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан шийдвэрийг төрийн өмчийн компанийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргана. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

43.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн энгийн хувьцааг нийтэд санал болгох ажиллагааг дараах зорилгоор хэрэгжүүлнэ:

43.3.1.компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг өргөжүүлэх, техник, технологийн шинэчлэл хийх, өрсөлдөх чадвар, санхүүгийн чадавх, тогтвортой байдлыг дээшлүүлэх;

43.3.2.компанийн засаглал, ил тод байдал, хяналтыг сайжруулах, олон нийтийн оролцоог хангах;

43.3.3.Монгол Улсын иргэн, Үндэсний баялгийн сан, тэтгэврийн сан болон хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх;



43.3.4.газрын хэвлийн баялгийн өгөөжийг Монгол Улсын иргэн бүрд хүртээмжтэй, ил тод, зах зээлийн зарчмаар хүргэх;

43.3.5.төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг хэрэгжүүлэх.

43.4.Энэ хуулийн 43.3.1-43.3.5-д заасан зорилго болон 43.6.2-т заасан зарчмыг хангах хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит компанийн энгийн хувьцааг нийтэд санал болгохдоо хөрөнгө оруулагчийн төрлийг дараах байдлаар дангаар болон хослуулан тогтоож болно:

43.4.1.Монгол Улсын иргэн;

43.4.2.мэргэжлийн хөрөнгө оруулагч;

43.4.3.стратегийн хөрөнгө оруулагч;

43.4.4.бусад хөрөнгө оруулагч.

43.5.Энэ хуулийн 43.4-т заасны дагуу хөрөнгө оруулагчдын төрөл, захиалгын доод болон дээд хэмжээ, хуваарилалтын аргачлал, төвлөрлөөс сэргийлэх арга хэмжээ болон шаардлагатай тохиолдолд нэг этгээдийн эзэмших дээд хэмжээг төрийн өмчийн компанийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал мэргэжлийн оролцогчдын санал, дүгнэлтийг үндэслэн тогтооно. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд мэргэжлийн оролцогчдын санал, дүгнэлтийг үндэслэн Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

43.6.Төрийн өмчит компанийн энгийн хувьцааг нийтэд санал болгоход дараах зарчмыг баримтална:

43.6.1.шударга, ил тод оролцох боломж олгох;

43.6.2.дангаар болон холбогдох этгээдэд хувьцаа эзэмшлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх;

43.6.3.хувьцааны үнэ, үнэлгээ, эрсдэл, ногдол ашиг, саналын эрх, хязгаарлалт, захиалгын нөхцөлийг нийтэд хүртээмжтэй мэдээлэх;

43.6.4.захиалга давсан тохиолдолд хувьцааг урьдчилан зарласан журмын дагуу хуваарилах;

43.6.5.Монгол Улсын иргэний хувьцааг богино хугацаанд төвлөрүүлэн худалдан авах, дамжуулан худалдах, зах зээлийг урвуулан ашиглах эрсдэлээс сэргийлэх зохицуулалт тогтоох;

43.6.6.Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан бусад энгийн хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хуульд өөрөөр заагаагүй бол хангах.

43.7.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг дараах хэлбэрээр арилжиж, худалдаж болно:

43.7.1.үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд төрийн болон орон нутгийн эзэмшлийн энгийн хувьцааг хоёрдогч зах зээл дээр арилжих;

43.7.2.дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалт, хэлэлцээрийн аргаар стратегийн хөрөнгө оруулагчид худалдах;

43.7.3.өөр төрлийн үнэт цаас, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр солих;

43.7.4.хуульд заасан бусад.

43.8.Энэ хуулийн 43.7-д заасны дагуу төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг арилжих, худалдах шийдвэрийг Засгийн газар, орон нутгийн өмчит компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцааг арилжих, худалдах шийдвэрийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хувьцаа эзэмшигчийн хувиар гаргана.

43.9.Энэ хуулийн 8.1.2-т заасан төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, арилжих шийдвэрийг Улсын Их Хурал гаргана.

43.10.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ур чадвартай ажилтныг тогтвортой ажиллуулах, дотоод хяналтыг сайжруулах зорилгоор Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн ажилтнуудад опцион эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж болно.

43.11.Энэ хуулийн 43.10-т заасан хөтөлбөрийн нөхцөл, эзэмшлийн дээд хэмжээ, шилжүүлэх хязгаарлалт, хэрэгжүүлэх хугацаа, шалгуур үзүүлэлтийг төлөөлөн удирдах зөвлөлийн саналын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал Засгийн газрын зөвшөөрлийг үндэслэн батална.



44 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийг өөрчлөн байгуулах

44.1.Төрийн өмчийн компанийг Засгийн газрын шийдвэрээр, төрийн өмчийн оролцоотой компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх хэлбэрээр өөрчлөн байгуулж болно.

44.2.Орон нутгийн өмчийн компанийг аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр, орон нутгийн өмчийн оролцоотой компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх хэлбэрээр өөрчлөн байгуулж болно.

44.3.Энэ хуулийн 44.1, 44.2-т заасан байгууллагын шийдвэргүйгээр төрийн болон орон нутгийн өмчийн компанийг өөрчлөн байгуулахыг хориглоно.

44.4.Төрийн болон орон нутгийн өмчит компанийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх хэлбэрээр өөрчлөн байгуулахад энэ хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

45 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийг татан буулгах

45.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийг татан буулгахад энэ хууль, Иргэний хууль, Компанийн тухай хуульд заасан үндэслэл, журмыг баримтална.

45.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийг татан буулгах ажлыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс томилсон татан буулгах комисс эрхлэн гүйцэтгэнэ.

45.3.Төрийн өмчийн компанийн эд хөрөнгийн тооллого хийж, дуусгалтын тайлан, тэнцэл үйлдэн, эд хөрөнгийг хэсэгчлэн шилжүүлэх, эсхүл дуудлага худалдаагаар худалдах ажлыг Засгийн газрын шийдвэрийг үндэслэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

45.4.Орон нутгийн өмчийн компанийн эд хөрөнгийн тооллого хийж, дуусгалтын тайлан, тэнцэл үйлдэн, эд хөрөнгийг хэсэгчлэн шилжүүлэх, эсхүл дуудлага худалдаагаар худалдах ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн орон нутгийн өмчийн газар эрхлэн гүйцэтгэнэ.

**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН,
МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ**

46 дугаар зүйл. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан

46.1. Төрийн болон орон нутгийн өмчийн компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Компанийн тухай хуульд заасан журмын дагуу санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргаж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч болон төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

46.2. Санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д заасан бүрэлдэхүүнтэй байна.

46.3. Энэ хуулийн 46.1-д заасан үйл ажиллагааны тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

46.3.1. санхүүгийн болон санхүүгийн бус зорилтын хэрэгжилт, батлагдсан ногдол ашгийн бодлого, үйл ажиллагааны зорилго, зорилтын нийцэл;

46.3.2. бизнесийн стратегийн бодлого, зах зээлийн дүн шинжилгээ;

46.3.3. дотоод болон гадаад зах зээлийн эрсдэлийн шинжилгээ, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;

46.3.4. бизнесийн хэтийн төлөвийг ойлгоход чухал ач холбогдолтой санхүүгийн бус эрсдэл, тодорхой бус хүчин зүйлсийн тайлбар;

46.3.5. санхүүгийн жилийн хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалт, худалдан авалт, онцлох үйл явдал;

46.3.6. төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн, цалин хөлс, урамшууллын мэдээлэл;

46.3.7. компанийн тогтвортой хөгжил болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлын тайлан, санхүүжилт, хөрөнгө оруулалтын дүн;

46.3.8. хүний нөөц, ажиллах хүч, байгууллагын бүтэц.

46.4. Энэ хуулийн 46.3-т заасан үйл ажиллагааны тайланд төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг



хэрхэн чиглүүлсэн, удирдан зохицуулсан, хянаж нийцүүлсэн талаарх тайлан, гүйцэтгэх удирдлагын болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хүлээн авсан цалин хөлс, урамшууллын хэмжээний талаарх мэдээллийг хавсаргана.

46.5.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газарт энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан өмчлөлийн бодлогын хэрэгжилтийн тайланг жил бүр хүргүүлнэ. Илтгэл бэлтгэх загварыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

46.6.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ зүйлд заасан тайлан, илтгэлийг нэгтгэн жилд нэг удаа төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааны үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн болон орон нутгийн эзэмшиж байгаа хувьцааг шилжүүлэх үр дүнтэй хувилбарын талаарх нэгдсэн тайлан бэлтгэж, саналын хамт Засгийн газарт танилцуулна.

46.7.Энэ хуулийн 46.6-д заасан нэгдсэн тайлан, саналыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд олон нийтэд ил тод, нээлттэй байршуулна.

47 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн нөөц сан

47.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчийн компани жил бүр татварын дараах цэвэр ашгийн 10 хувь хүртэл хэмжээний хөрөнгийг ногдол ашиг хуваарилахаас өмнө компанийн нөөц сан байгуулан төвлөрүүлж болно.

47.2.Энэ хуулийн 47.1-д заасан нөөц сан байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл гаргана.

47.3.Энэ хуулийн 47.1-д заасан нөөц сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

47.3.1.компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг өргөжүүлэх, технологийг шинэчлэх;

47.3.2.давагдашгүй хүчин зүйл, зах зээлийн гэнэтийн өөрчлөлт болон бусад урьдчилан таамаглах боломжгүй эрсдэлийн сөрөг нөлөөллийг бууруулах.

47.4.Энэ хуулийн 47.1-д заасан нөөц санд төвлөрүүлсэн хөрөнгийн нийт хэмжээ нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 50 хувиас хэтэрсэн тохиолдолд компани нөөц санд хөрөнгө төвлөрүүлэхгүй байж болно.

48 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн мэдээллийн ил тод байдал

48.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани Шилэн дансны тухай хуулийн¹² 6.1, 6.4, 6.8 дахь хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн¹³ 8 дугаар зүйлд заасан мэдээлэл болон дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд, мөн тэдгээрт өөрчлөлт оруулсан тухай бүрд өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ:

48.1.1.компанийн төсөв, бизнес төлөвлөгөө;

48.1.2.компанийн зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан хувьцааны тоо, төрөл, нэрлэсэн үнэ, өөрийн хөрөнгийн хэмжээ, биет, биет бус хөрөнгийн талаарх мэдээлэл;

48.1.3.компанийн сүүлийн таван жилд хөндлөнгийн аудит хийлгэсэн санхүүгийн тайлан;

48.1.4.компанийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөө;

48.1.5.компанийн байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл;

48.1.6.компанийн гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэх санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гэрээ, түүний гүйцэтгэлийг дүгнэсэн мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын гэрээг сунгах эсэх тухай гаргасан шийдвэр;

48.1.7.компанитай холбогдуулан гаргасан нэхэмжлэл, хэрэг маргаан, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн хуульч, өмгөөлөгч, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл;

48.1.8.компанийн дүрэм, компанийн үйл ажиллагааны болон засаглалын дотоод журам;

48.1.9.тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын мэдээлэл, хэрэгжилтийн явц болон хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээний талаарх мэдээлэл;

¹² Шилэн дансны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2014 оны 26 дугаарт нийтлэгдсэн.

¹³ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 06 дугаарт нийтлэгдсэн.



48.1.10.бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын болон нийлүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл, гэрээний хугацаа, үнийн дүн, сонгон шалгаруулалтын аргачлал, хэрэгжилтийн явц;

48.1.11.Төрийн болон албаны нууцын тухай хууль¹⁴, Байгууллагын нууцын тухай хуульд¹⁵ заасан нууц болон холбогдох бусад хуульд заасан хаалттай, хязгаарлалттай мэдээлэл агуулаагүй төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;

48.1.12.байгууллагын нууцад хамааруулсан мэдээллийн жагсаалт;

48.1.13.тухайн санхүүгийн жилд төлсөн албан татвар, төлбөр, хураамж;

48.1.14.төсвөөс болон бусад эх үүсвэрээс авсан дэмжлэг, татаас, хандив, тусламж.

48.2.Энэ хуулийн 48.1-д заасан мэдээлэлд хяналт шалгалт хийх зорилгоор холбогдох баримт бичгийг хуулбарлахыг зөвшөөрнө.

АРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

49 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

49.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

49.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль¹⁶, эсхүл Зөрчлийн тухай хуульд¹⁷ заасан хариуцлага хүлээлгэнэ.

50 дугаар зүйл.Дагаж мөрдөх журмын зохицуулалт

50.1.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу байгуулагдсан төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг энэ хуулийг дагаж мөрдсөнөөс хойш нэг жилийн хугацаанд компани, эсхүл нийтийн үйлчилгээний байгууллага хэлбэрээр өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах арга хэмжээ авна.

¹⁴ Төрийн болон албаны нууцын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

¹⁵ Байгууллагын нууцын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1995 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

¹⁶ Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

¹⁷ Зөрчлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

50.2.Энэ хуулийн 50.1-д заасны дагуу өөрчлөн байгуулагдах компанийн дүрмийг Засгийн газрын шийдвэрээр тогтоосон тухайн компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч батална.

50.3.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг энэ хуулийн 8.2-т заасан үндэслэлд нийцүүлэх арга хэмжээг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулна.

50.4.Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг 2028 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

50.5.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үүсгэн байгуулагдсан уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчит компанид энэ хуулийн 8.2-т заасан зөвшөөрөл хамаарахгүй.

50.6.Энэ хуулийн 50.1-д заасан үйлдвэрийн газарт эмнэлэг, сургууль, цэцэрлэг хамаарахгүй.

51 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

51.1.Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ

[illegible]

۶.۳. در خصوص معیار تعیین میزان محاسبه، معیارهای ذیل پیشنهاد میگردد:

حفظت

[illegible][illegible]

۳.۲.۱. مدل‌سازی و پیاده‌سازی سیستم پیشنهادی:

[illegible][illegible]

2. 3. 4. 5. 6. 7. 8. 9. 10. 11. 12. 13. 14. 15. 16. 17. 18. 19. 20. 21. 22. 23. 24. 25. 26. 27. 28. 29. 30. 31. 32. 33. 34. 35. 36. 37. 38. 39. 40. 41. 42. 43. 44. 45. 46. 47. 48. 49. 50. 51. 52. 53. 54. 55. 56. 57. 58. 59. 60. 61. 62. 63. 64. 65. 66. 67. 68. 69. 70. 71. 72. 73. 74. 75. 76. 77. 78. 79. 80. 81. 82. 83. 84. 85. 86. 87. 88. 89. 90. 91. 92. 93. 94. 95. 96. 97. 98. 99. 100. 101. 102. 103. 104. 105. 106. 107. 108. 109. 110. 111. 112. 113. 114. 115. 116. 117. 118. 119. 120. 121. 122. 123. 124. 125. 126. 127. 128. 129. 130. 131. 132. 133. 134. 135. 136. 137. 138. 139. 140. 141. 142. 143. 144. 145. 146. 147. 148. 149. 150. 151. 152. 153. 154. 155. 156. 157. 158. 159. 160. 161. 162. 163. 164. 165. 166. 167. 168. 169. 170. 171. 172. 173. 174. 175. 176. 177. 178. 179. 180. 181. 182. 183. 184. 185. 186. 187. 188. 189. 190. 191. 192. 193. 194. 195. 196. 197. 198. 199. 200. 201. 202. 203. 204. 205. 206. 207. 208. 209. 210. 211. 212. 213. 214. 215. 216. 217. 218. 219. 220. 221. 222. 223. 224. 225. 226. 227. 228. 229. 230. 231. 232. 233. 234. 235. 236. 237. 238. 239. 240. 241. 242. 243. 244. 245. 246. 247. 248. 249. 250. 251. 252. 253. 254. 255. 256. 257. 258. 259. 260. 261. 262. 263. 264. 265. 266. 267. 268. 269. 270. 271. 272. 273. 274. 275. 276. 277. 278. 279. 280. 281. 282. 283. 284. 285. 286. 287. 288. 289. 290. 291. 292. 293. 294. 295. 296. 297. 298. 299. 300. 301. 302. 303. 304. 305. 306. 307. 308. 309. 310. 311. 312. 313. 314. 315. 316. 317. 318. 319. 320. 321. 322. 323. 324. 325. 326. 327. 328. 329. 330. 331. 332. 333. 334. 335. 336. 337. 338. 339. 340. 341. 342. 343. 344. 345. 346. 347. 348. 349. 350. 351. 352. 353. 354. 355. 356. 357. 358. 359. 360. 361. 362. 363. 364. 365. 366. 367. 368. 369. 370. 371. 372. 373. 374. 375. 376. 377. 378. 379. 380. 381. 382. 383. 384. 385. 386. 387. 388. 389. 390. 391. 392. 393. 394. 395. 396. 397. 398. 399. 400. 401. 402. 403. 404. 405. 406. 407. 408. 409. 410. 411. 412. 413. 414. 415. 416. 417. 418. 419. 420. 421. 422. 423. 424. 425. 426. 427. 428. 429. 430. 431. 432. 433. 434. 435. 436. 437. 438. 439. 440. 441. 442. 443. 444. 445. 446. 447. 448. 449. 450. 451. 452. 453. 454. 455. 456. 457. 458. 459. 460. 461. 462. 463. 464. 465. 466. 467. 468. 469. 470. 471. 472. 473. 474. 475. 476. 477. 478. 479. 480. 481. 482. 483. 484. 485. 486. 487. 488. 489. 490. 491. 492. 493. 494. 495. 496. 497. 498. 499. 500. 501. 502. 503. 504. 505. 506. 507. 508. 509. 510. 511. 512. 513. 514. 515. 516. 517. 518. 519. 520. 521. 522. 523. 524. 525. 526. 527. 528. 529. 530. 531. 532. 533. 534. 535. 536. 537. 538. 539. 540. 541. 542. 543. 544. 545. 546. 547. 548. 549. 550. 551. 552. 553. 554. 555. 556. 557. 558. 559. 560. 561. 562. 563. 564. 565. 566. 567. 568. 569. 570. 571. 572. 573. 574. 575. 576. 577. 578. 579. 580. 581. 582. 583. 584. 585. 586. 587. 588. 589. 590. 591. 592. 593. 594. 595. 596. 597. 598. 599. 600. 601. 602. 603. 604. 605. 606. 607. 608. 609. 610. 611. 612. 613. 614. 615. 616. 617. 618. 619. 620. 621. 622. 623. 624. 625. 626. 627. 628. 629. 630. 631. 632. 633. 634. 635. 636. 637. 638. 639. 640. 641. 642. 643. 644. 645. 646. 647. 648. 649. 650. 651. 652. 653. 654. 655. 656. 657. 658. 659. 660. 661. 662. 663. 664. 665. 666. 667. 668. 669. 670. 671. 672. 673. 674. 675. 676. 677. 678. 679. 680. 681. 682. 683. 684. 685. 686. 687. 688. 689. 690. 691. 692. 693. 694. 695. 696. 697. 698. 699. 700. 701. 702. 703. 704. 705. 706. 707. 708. 709. 710. 711. 712. 713. 714. 715. 716. 717. 718. 719. 720. 721. 722. 723. 724. 725. 726. 727. 728. 729. 730. 731. 732. 733. 734. 735. 736. 737. 738. 739. 740. 741. 742. 743. 744. 745. 746. 747. 748. 749. 750. 751. 752. 753. 754. 755. 756. 757. 758. 759. 760. 761. 762. 763. 764. 765. 766. 767. 768. 769. 770. 771. 772. 773. 774. 775. 776. 777. 778. 779. 780. 781. 782. 783. 784. 785. 786. 787. 788. 789. 790. 791. 792. 793. 794. 795. 796. 797. 798. 799. 800. 801. 802. 803. 804. 805. 806. 807. 808. 809. 810. 811. 812. 813. 814. 815. 816. 817. 818. 819. 820. 821. 822. 823. 824. 825. 826. 827. 828. 829. 830. 831. 832. 833. 834. 835. 836. 837. 838. 839. 840. 841.

جواب :

الحمد لله الذي هدانا لهذا الذي كنا لنهتدي لولا أن هدانا الله

ପ୍ରାୟଶଃ ସମସ୍ତେ ଏହିପରି କରନ୍ତି ।

[illegible]

٢٠٣٠٦٠٧
مجلد دوم، فصل سوم، در خصوص سبب و علل وقوع این حادثه

مصدقہ فیما بین محمد بن عبد اللہ
وہدیٰ بن علی وبنو ہاشم

[illegible]

١٠٦٠: فصل في معرفة الحروف العشرة

[illegible][illegible]

QUESTION

[illegible][illegible][illegible][illegible]

دسترس به منابع و اطلاعات در دسترس نیست؛

...بالتشريع في إصلاح القضاء

[illegible][illegible]

٣٦ جُمادى الثانی ١٠٠٧ھ بمطابق ۱۸۶۸ء

استقامت

[illegible]

مجلس شورای اسلامی

.....

نمونه مصدق و محققین در این خصوص به شرح ذیل است:

[illegible][illegible][illegible]

செய்து

وہی ہے جس نے

دعوت حضرت امام رضا علیه السلام

[illegible][illegible]

[illegible][illegible][illegible][illegible][illegible][illegible]

[illegible]

[illegible]

सत्यमेव जयते

[illegible]

۵۹ حضرت اعلیٰ حضرت رحمہ اللہ کی سیرت و صلاحیت

[illegible][illegible]

٣٠٤٩ : من راجع الى ٥٠٠٠ - في الحشود والاعمال

[illegible]

התאריך: 20.04.2024

[illegible]

الحمد لله الذي جعل القرآن الكريم من أجلنا، وهدانا لهذا السبيل، والحمد لله دائماً وأبداً.

٢٠٢٠ م. ١٤٤٢ هـ

[illegible]

٥٦ فصل في بيان ما مضى من تاريخه

[illegible][illegible][illegible][illegible][illegible][illegible]

၃၅) မြောက် မြောက်... မြောက် မြောက် မြောက်

[illegible]

کتابخانه جامعہ اسلامیہ
بیت العلوم دارالحدیث

சு. சிவசுந்தரி

...میں نے اس کو دیکھا تھا...

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар” гэснийг “төрийн болон орон нутгийн өмчит компани” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.7 дахь заалтын “аж ахуйн нэгжүүдээс” гэснийг “компаниас” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠬᠤᠠᠭᠤᠨ
ᠠᠵᠤ ᠠᠬᠤᠢ ᠨᠡᠭᠭᠢᠨ ᠣᠷᠯᠣᠭ-ᠤᠨ
ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠠᠲᠪᠠᠷ-ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠤᠠᠭᠣᠯᠣᠳᠤ
ᠡᠭᠡᠷᠠᠭᠠᠯᠠᠭ ᠣᠷᠤᠭᠤᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

ᠠᠵᠤ ᠠᠬᠤᠢ ᠨᠡᠭᠭᠢᠨ ᠣᠷᠯᠣᠭ-ᠤᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠠᠲᠪᠠᠷ-ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ
ᠬᠤᠠᠭᠣᠯᠣᠳᠤ 4 дᠤᠭᠡᠷ зᠦᠢᠯᠡᠭ 4.1.1 дэх заалтын “төрийн болон орон
нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар” гэснийг “төрийн болон орон
нутгийн өмчит компани” гэж, 21 дᠤᠭᠡᠷ зᠦᠢᠯᠡᠭ 21.1.7 дахь заалтын “аж
ахуйн нэгжүүдээс” гэснийг “компаниас” гэж тус тус өөрчилсүгэй.

ᠡᠨᠡ ᠬᠤᠠᠭᠣᠯᠣᠳᠤ Төрийн болон орон нутгийн өмчит
компанийн засаглалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн
дагаж мөрдөнө.

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ
ИХ ХУРЛЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.17 дахь хэсгийн, 28 дугаар зүйлийн 28.4.3 дахь заалтын, 55 дугаар зүйлийн 55.1.4 дэх заалтын “, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой” гэснийг, 47 дугаар зүйлийн 47.5.4 дэх заалтын “хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ

Бусад хэсгээр нь

Бусад хэсгээр нь

Бусад хэсгээр нь

Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь

Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь

Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь

Бусад хэсгээр нь
Бусад хэсгээр нь

Бусад хэсгээр нь



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.6.4.төрийн өмчит хуулийн этгээд, төрийн чиг үүргийг хууль, гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн архивын баримт;”

2 дугаар зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11 дэх хэсгийн “Төрийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар” гэснийг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 5-д заасан төрийн өмчит хуулийн этгээд” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ

Бүтээгдэхүүний үнэ

Бүтээгдэхүүний үнэ

Бүтээгдэхүүний үнэ

Бүтээгдэхүүний үнэ

Бүтээгдэхүүний үнэ

Бүтээгдэхүүний үнэ

Бүтээгдэхүүний үнэ

Бүтээгдэхүүний үнэ

Бүтээгдэхүүний үнэ

Бүтээгдэхүүний үнэ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн Аравдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 10.31 дүгээр зүйл нэмсүгэй:

“10.31 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хууль зөрчих

1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хуульд заасан тайлан тэнцэл, мэдээ, мэдээллийг:

1.1.нийтэд, эрх бүхий байгууллага, хувьцаа эзэмшигчид танилцуулах;

1.2.тайлагнах;

1.3.мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хуульд заасныг зөрчиж:

2.1.төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилсон, томилуулахаар нэр дэвшүүлж, санал болгосон, гүйцэтгэх удирдлагыг томилсон;

2.2.төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллыг олгосон, гүйцэтгэлийн үнэлгээ хийгээгүй;

2.3.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагаар ажиллаж болохгүй нөхцөл байдал бий болсон талаар мэдээлээгүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хуульд заасныг зөрчиж:

3.1.алтан хувьцаа гаргасан, хугацааг сунгасан, бусдад шилжүүлсэн;



3.2.алтан хувьцаатай компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын шийдвэрт тавьсан Засгийн газрын хоригийг биелүүлээгүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.5 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн “төрийн өмчит, эсхүл төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж” гэснийг “төрийн өмчит компани” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 18.5 дахь заалтын “этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ

[illegible][illegible]

3.0.3. ۱۳۰۳ و ۱۳۰۴ سال در خصوص تغییرات در وضعیت آب و هوا،

[illegible][illegible][illegible][illegible]

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 6.67 дахь заалт нэмсүгэй:

“6.67.Төрийн өмчийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.31 дүгээр зүйлд заасан зөрчил.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 6.67 дахь заалт нэмсүгэй:

“6.67.Төрийн өмчийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.31 дүгээр зүйлд заасан зөрчил.”

Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ИННОВАЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Инновацийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд” гэснийг “төрийн өмчит компани” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалтын “болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд” гэснийг “компани” гэж, 27 дугаар зүйлийн 27.10.3 дахь заалтын “төрийн өмчит үйлдвэрийн газарт” гэснийг “төрийн өмчит компанид” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ

Үргэлжлэл, хэсэг 1

2026 оны 07 сарын 02-ны өдөр /Хурлын өдөр/

Төрийн өмчийн
хуулийн этгээд

6 хэсэгт өөрчлөлт оруулах...
6.1.5 дахь заалтыг “төрийн өмчит компани” гэж, 11.1.5 дахь заалтыг “компани” гэж, 27.10.3 дахь заалтыг “төрийн өмчит компанид” гэж тус тус өөрчилсүгэй.

“төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд” гэснийг “төрийн өмчит компани” гэж, 11.1.5 дахь заалтын “болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд” гэснийг “компани” гэж, 27.10.3 дахь заалтын “төрийн өмчит үйлдвэрийн газарт” гэснийг “төрийн өмчит компанид” гэж тус тус өөрчилсүгэй.

Үргэлжлэл, хэсэг 2

4-д үргэлжлэл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 61.11 дэх хэсэг нэмсүгэй:

“61.11.Төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 61.4-т заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл.Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг тухайлсан хуулиар, уг хуульд өөрөөр заагаагүй бол компанийн нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулна.”

3 дугаар зүйл.Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсгийн “компани болон төрийн өмчийн” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4, 2.5, 2.6 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэг, 36 дугаар зүйл, 79 дүгээр зүйлийн 79.2, 79.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.18 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4.3 дахь заалт, 56 дугаар зүйлийн 56.1.4 дэх заалтын “, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой” гэснийг, 48 дугаар зүйлийн 48.5.4 дэх заалтын “хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ

Бусад үзүүлэлтүүд

Бусад үзүүлэлтүүд

Бусад үзүүлэлтүүд

Бусад үзүүлэлтүүд
Бусад үзүүлэлтүүд
Бусад үзүүлэлтүүд

Бусад үзүүлэлтүүд... Бусад үзүүлэлтүүд... Бусад үзүүлэлтүүд...
Санхүүгийн үр ашиггүй төслүүдтэй холбоотой “Хэлсинки”-гийн нөхцөлт тусламжийн журмын туршлагыг үндэслэн салбаруудыг хөнгөлөлттэй санхүүжилтэд хамруулах боломжтой гэж үзнэ. Үүнд:

- Эрүүл мэндийн салбар түүнд эмнэлэг болон эмнэлгийн тоног төхөөрөмжийг хамруулан;
- Нийгмийн дэд бүтэц;
- Хотын ус хангамж болон ариутгах байгууламж;
- Хог хаягдал болон бохир ус;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдал болон төмөр зам;
- Боловсрол болон мэргэжлийн сургалт;
- Иргэний хамгаалалт;
- Хөдөө аж ахуй;
- Бусад дэд бүтэц.



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ЗЭЭЛИЙН ДУГААР (ОУСБХБ)_____МН

МОНГОЛ УЛС

болон

ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК

хоорондын

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

(Тогтвортой эрчим хүчний шилжилтийг түргэсгэх зорилго бүхий
Олон шатлалт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих
Эрчим хүч-4 төсөл)



ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү хэлэлцээрийг Монгол Улс (цаашид "Зээлдэгч" гэх) болон Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (цаашид "Банк" гэх) хооронд хэлэлцээрт гарын үсэг зурсан өдөр байгуулав. Зээлдэгч болон Банк хооронд дараах нөхцөлүүдийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:

ЗҮЙЛ I - ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ; НЭР ТОМЬЁО

1.01. Ерөнхий нөхцөл нь (энэхүү Хэлэлцээрийн Хавсралтад тодорхойлсны дагуу) энэхүү Хэлэлцээрт хамаарах ба түүний салшгүй нэг хэсэг мөн.

1.02. Хэлэлцээрийн агуулгад өөрөөр заагаагүй бол энэхүү Хэлэлцээрт том үсгээр тэмдэглэсэн нэр томьёог Ерөнхий нөхцөл, Санхүүжилтийн гэрээ, эсхүл энэхүү Хэлэлцээр (түүний Удиртгал болон Хавсралтууд мөн хамаарна)-т тодорхойлсон утгаар ойлгоно.

ЗҮЙЛ II - ЗЭЭЛ

2.01. Банк нь Зээлдэгчид Төслийг санхүүжүүлэх зорилгоор далан найман сая (78,000,000 ам.доллар) америк доллартой тэнцэх хэмжээний зээл (цаашид "Зээл" гэх) олгохыг зөвшөөрсөн. Уг үнийн дүн нь валютын хөрвүүлэлтээс шалтгаалан өөрчлөгдөж болно.

2.02. Зээлдэгч нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын Хэсэг III-т заасны дагуу Зээлийн хөрөнгийг татан авч болно.

2.03. Үйлчилгээний хураамж нь зээлийн үнийн дүнгийн тэг зууны хорин таван (0.25%) хувь байна.

2.04. Зээлийн хөрөнгийн ашиглагдаагүй үлдэгдлээс тооцогдох хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж нь жилийн тэг зууны хорин таван (0.25%) хувь байна.

2.05. Зээлийн хүүгийн хэмжээ нь Жишиг хүү дээр Хувьсах хүүгийн нэмэгдлийг нэмсэнтэй тэнцүү, эсхүл Хөрвүүлсэн хувь хэмжээ байх бөгөөд энэ нь Ерөнхий нөхцөлийн 3.02(е) хэсэгтэй нийцсэн байна.

2.06. Зээлийн төлбөр гүйцэтгэх өдөр нь жил бүрийн 06 дугаар сарын 15 болон 12 дугаар сарын 15-ны өдөр байна.

2.07. Зээлийн үндсэн төлбөрийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 3-т заасны дагуу эргэн төлнө.

ЗҮЙЛ III - ТӨСӨЛ

3.01. Зээлдэгч нь Төслийн болон ОШХ-ийн зорилтыг хангах үүрэг хүлээснээ үүгээр мэдэгдэж байна. Үүнтэй холбогдуулан Зээлдэгч нь Ерөнхий нөхцөлийн Зүйл V заалтууд болон энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-т заасны дагуу Төслийг Эрчим хүчний яам (ЭХЯ)-аар дамжуулан хэрэгжүүлнэ.

ЗҮЙЛ IV - ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ; ЦУЦЛАХ

4.01. Хэлэлцээр хүчин төгөлдөр болоход дараах Нэмэлт нөхцөлийг хангасан байна. Үүнд:

(а) Зээлдэгч нь ЭХЯ-аар дамжуулан Банкны хүлээн зөвшөөрсөн хэлбэр, агуулга бүхий Төслийн үйл ажиллагааны гарын авлага боловсруулан батална; мөн

(б) Зээлдэгч нь ЭХЯ-аар дамжуулан Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтцэд Төсөл удирдах багийг Банканд хүлээн зөвшөөрөгдөхүйц бүрэлдэхүүн, хүний нөөц болон чиг үүргийн тодорхойлолттойгоор байгуулсан байна.

4.02. Хэлэлцээр хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь энэхүү Хэлэлцээрт талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш нэг зуун наян (180) хоногийн дотор байна.

4.03. Ерөнхий нөхцөлийн 9.05(б) хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор энэхүү Хэлэлцээрийн дагуу Зээлдэгчийн хүлээх үүрэг (төлбөрийн үүргээс бусад) дуусах өдөр нь Хэлэлцээрт талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш хорин (20) жил байна.

ЗҮЙЛ V - ТАЛУУДЫН ТӨЛӨӨЛӨЛ; ХАЯГ

5.01. Зээлдэгчийн төлөөлөгч нь тухайн үеийн санхүүгийн асуудал эрхэлсэн Сайд байна.

5.02. Ерөнхий нөхцөлийн 10.01 хэсэгт заасан зорилгоор:

(а) Зээлдэгчийн хаяг:

Сангийн яам
Засгийн газрын II байр
С.Данзангийн гудамж 5/1 Д
Улаанбаатар хот, 15160
Монгол Улс; ба



(б) Зээлдэгчийн цахим хаяг:

Факсын дугаар:
976-11-3202472

5.03. Ерөнхий нөхцөлийн 10.01 хэсэгт заасан зорилгоор:

(а) Банкны хаяг:

Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк
1818 Н гудамж, Хойд, баруун хэсэг
Вашингтон хот, Колумбын тойрог 20433
Америкийн Нэгдсэн Улс; ба

(б) Банкны цахим хаяг:

Телекс:

248423(MCI) эсвэл 64145(MCI)

Факс:

1-202-477-6391



Хэлэлцээрт талууд гарын үсэг зурсан өдрөөр ХАРИЛЦАН ТОХИРОЛЦОВ.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____

ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____



ХУВААРЬ 1

Төслийн танилцуулга

Төслийн зорилт нь төсөл хэрэгжүүлэх орон нутгийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй холбох цахилгаан дамжуулах шугамын хүчин чадлыг нэмэгдүүлэх, түүний найдвартай байдлыг сайжруулахад оршино.

Төсөл нь ОШХ-ийн нэг үе шат бөгөөд дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

Хэсэг 1. Цахилгаан дамжуулах шугамын барилгын ажил, холбогдох дэд станцын өргөтгөл

- (a) Барилга угсралтын ажил: (i) одоо байгаа Мандал дэд станцаас шинээр барих Өвөрхангай дэд станц хүртэлх 220 кВ хоёр хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам; (ii) шинэ Өвөрхангай дэд станц; мөн (iii) шинэ Өвөрхангай дэд станцыг одоо байгаа Арвайхээр – Баянхонгорын 110 кВ-ын дэд бүтцэд холбох шугам.
- (b) Өргөтгөлийн ажил: (i) одоо байгаа Мандал дэд станцыг 220 кВ хоёр хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамд холбох; мөн (ii) одоо байгаа Арвайхээр, Баянхонгор дэд станцуудыг өргөтгөх.

Хэсэг 2. Төсөл хэрэгжүүлэх дэмжлэг үзүүлэх

Дараах техникийн болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүлнэ. Үүнд: (a) ЭХЯ болон холбогдох агентлагуудын институцын болон техникийн чадавхыг бэхжүүлэх; (b) Төслийн хэрэгжилт болон удирдлагад дэмжлэг үзүүлэх, үүнд: санхүүгийн удирдлага, зарцуулалт, худалдан авалт, байгаль орчин болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн удирдлага, хяналт, тайлагнал, үнэлгээ багтана.

ХУВААРЬ 2

Төслийн хэрэгжилт

Хэсэг I. Төсөл хэрэгжүүлэх зохион байгуулалт

А. Институцын зохион байгуулалт

1. Зээлдэгч нь Төслийн үйл ажиллагааны гарын авлагад заасны дагуу төсөл хэрэгжүүлэх хугацаанд улс, орон нутгийн түвшинд Банкны шаардлагад нийцсэн бүтэц, чиг үүрэг, орон тоо, нөөц бүхий Төсөл хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтэц байгуулан ажиллуулна.

2. Дээр дурдсанаар хязгаарлагдахгүй Зээлдэгч нь дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

(а) Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг [1] сарын дотор СЯ, ЭХЯ, төсөл хэрэгжүүлэх орон нутгийн захиргааны төлөөллөөс бүрдсэн, ЭХЯ даргалсан Төслийн удирдах хороог байгуулна. Уг хороо Төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох агентлаг хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах үүрэг хүлээнэ;

(б) Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн дэргэд байгуулах Төсөл удирдах баг нь доорх үүрэг хүлээнэ. Үүнд: (i) Төслийн жилийн ажлын төлөвлөгөө, төсөв (ЖАТТ) болон бусад тогтмол тайлан бэлтгэх; (ii) худалдан авах ажиллагаа, санхүүгийн удирдлага, зарцуулалт, санхүүжилт, байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн менежмент, түүний дотор гомдол барагдуулах механизм хэрэгжүүлэх; (iii) Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээ зэрэг Төслийн өдөр тутмын хэрэгжилтийг хариуцах.

Б. Төслийн үйл ажиллагааны гарын авлага

Зээлдэгч нь ЭХЯ-аар дамжуулан Төслийн үйл ажиллагааны гарын авлагад заасан зохион байгуулалт, дэг журмын дагуу (хэрэв энэхүү Хэлэлцээр болон Төслийн үйл ажиллагааны гарын авлагад заасан зохион байгуулалт, дэг журмын заалтууд хооронд ямарваа зөрчил үүсвэл энэхүү Хэлэлцээрийн заалтыг дагаж мөрдөнө) Төслийг хэрэгжүүлэх ба Банк урьдчилан бичгээр зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд Төслийн үйл ажиллагааны гарын авлагын аливаа заалтад нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, татгалзах эсхүл түдгэлзүүлэхийг хориглоно.



В. Төслийн жилийн ажлын төлөвлөгөө, төсөв

1. Зээлдэгч нь ЭХЯ-аар дамжуулан төсөл хэрэгжүүлэх хугацаанд энэхүү Хуваарийн Хэсэг Д-д заасны дагуу хэрэгжүүлж буй эсхүл төлөвлөж буй байгаль орчин, нийгмийн арга хэмжээ, бүх зарлагын санхүүжилтийн эх үүсвэр зэрэг ирэх санхүүгийн жилд санал болгож буй төслийн бүх үйл ажиллагаа, зарлагыг агуулсан нэгтгэсэн жилийн ажлын төлөвлөгөө, төсөв (ЖАТТ)-ийг бэлтгэн 2026 оны санхүүгийн жилд багтаан Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш жар (60) хоногийн дотор, түүний дараагийн төсөл хэрэгжилтийн хугацаанд жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор (эсхүл Банкны зөвшөөрсөн хугацаанд) Банкны зөвшөөрөл авахаар хүргүүлнэ.

2. Зээлдэгч нь Банкны хүлээн зөвшөөрсөн ЖАТТ-ийн дагуу тухайн төсвийн жилд Төслийг хэрэгжүүлнэ. Хэрэв төслийн ЖАТТ болон энэхүү Хэлэлцээрийн заалт хооронд зөрчил үүсвэл энэхүү Хэлэлцээрийн заалтыг дагаж мөрдөнө.

3. Зээлдэгч нь Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр Төслийн ЖАТТ-т ямарваа нэмэлт өөрчлөлт оруулах эсхүл оруулахыг зөвшөөрөхийг хориглоно.

Г. Зээлдэгч талын санхүүжилт

Ерөнхий нөхцөлийн 5.03 дахь (Санхүүжилт болон бусад эх үүсвэрээр хангах) хэсгийн ерөнхий агуулгад хязгаарлалт тогтоохгүйгээр, Зээлдэгч нь Төслийн хэрэгжилтийн бүхий л хугацаанд дараах үүргийг хүлээнэ:

(а) 2(б) хэсэг (“Зээлдэгч талын санхүүжилт”)-ийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагаанд зориулсан өөрийн санхүүжилтийг хангах зорилгоор Банкны зүгээс хангалттай хэмээн тооцогдох хэмжээний санхүүжилтийн хөрөнгийг цаг тухайд нь бүрэн хангаж эсхүл хангуулна;

(б) дээрх 1 дэх хэсэгт заасны дагуу шаардагдах Зээлдэгч талын санхүүжилтийн оролцооны төлөв байдлын талаар жил бүр, дор хаяж нэг удаа тайлан гаргаж, холбогдох баримт бичгийн хамт Банканд ирүүлнэ;

(в) Зээлдэгч талын санхүүжилтээр хэрэгжүүлэх бүх Төслийн үйл ажиллагаа нь энэхүү Хэлэлцээрийн дагуу хамаарах бүх шаардлага, түүний дотор Төслийн үйл ажиллагааны гарын авлагад заасан заалтуудыг бүрэн мөрдөж, хэрэгжилтийг хангана.

Д. Байгаль орчин, нийгмийн стандарт

1. Зээлдэгч нь Байгаль орчин, нийгмийн стандартад нийцүүлэн Банкны хүлээн зөвшөөрөхүйц байдлаар Төслийг хэрэгжүүлнэ.

2. Зээлдэгч нь дээрх 1 дэх зүйлд зааснаар хязгаарлахгүй Банк хүлээн зөвшөөрөхүйц байдлаар Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө (“БОНХТ”)-ний дагуу Төслийг хэрэгжүүлнэ. Үүний тулд Зээлдэгч дараах арга хэмжээг авна:

(а) БОНХТ-ний дагуу уг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ, үйл ажиллагааг урьдчилан шалгаж, үр дүнтэй хэрэгжүүлэх;

(б) БОНХТ-г хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг гаргах;

(в) БОНХТ-нд заасны дагуу түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бодлого, журмыг сахин мөрдөх, мэргэжлийн шаардлага хангасан, туршлагатай ажилтныг зохистой тоогоор авч ажиллуулах;

(г) БОНХТ-ний дагуу Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд БОНХТ эсхүл түүний аливаа заалтад нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, түдгэлзэх эсхүл татгалзахыг хориглох ба шинэчилсэн БОНХТ-г олон нийтэд зохих журмын дагуу мэдээлэх.

3. БОНХТ болон энэхүү Хэлэлцээрийн заалт хооронд аливаа зөрчил үүсвэл энэхүү Хэлэлцээрийн заалтыг мөрдөнө.

4. Зээлдэгч дараах арга хэмжээг авна.

(а) БОНХТ-нд заасан давтамжийн дагуу тогтмол тайлан эсхүл Банкны хүсэлтийн дагуу БОНХТ болон байгаль орчин, нийгмийн арга хэрэгслийг мөрдөж байгаа талаарх тусгайлсан тайлан цуглуулах, бэлтгэх, нэгтгэх, Банканд хүргүүлэх шаардлагатай бүх арга хэмжээ авах. Дараах мэдээллийг тусган Банкны хүлээн зөвшөөрөхүйц хэлбэр, агуулгаар бүх тайланг бэлтгэнэ. Үүнд: (i) БОНХТ-ний хэрэгжилтийн явц; (ii) БОНХТ хэрэгжүүлэхэд саад учруулах эсхүл саад учруулж болзошгүй аливаа нөхцөл байдал; (iii) ийм нөхцөл байдлыг арилгах эсхүл урьдчилан сэргийлэхээр авсан эсхүл авах шаардлагатай арга хэмжээ;

(б) БОНХТ, түүнд дурдсан байгаль орчин, нийгмийн хамгааллын арга хэрэгсэл, Байгаль орчин, нийгмийн стандартын дагуу байгаль орчин, орон нутгийн иргэд, төрийн албаны болон бусад



ажилтнуудад ихээхэн сөрөг нөлөө үзүүлэхүйц эсхүл үзүүлсэн Төслийн үйл ажиллагаатай холбоотой эсхүл түүнд нөлөө үзүүлж буй тохиолдол эсхүл ослын талаар Банканд нэн даруй мэдэгдэнэ.

5. Зээлдэгч нь Төслийн нөлөөлөлд орсон хүмүүсийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах, барагдуулахад дэмжлэг үзүүлэх гомдол барагдуулах хүртээмжтэй механизмыг боловсруулах, сурталчлах, ажиллуулах ба Банкны хүлээн зөвшөөрөхүйц байдлаар аливаа гомдлыг шийдвэрлэх эсхүл шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээ авна.

6. Зээлдэгч нь Төслийн хүрээнд хэрэгжүүлэх барилгын ажлын бүх тендерийн баримт бичиг болон гэрээнд гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч, хяналт тавих этгээдийн хүлээсэн үүргийн талаар дараах заалтыг тусгасан байна. Үүнд: (а) БОНХТ болон түүнд дурдсан байгаль орчин, нийгмийн арга хэрэгслийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах; (б) байгуулсан гэрээний хүрээнд хэрэгжүүлэх барилгын ажил гүйцэтгэх явцад байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, бэлгийн дарамт, хүүхдийн эсрэг хүчирхийллийг шийдвэрлэх арга хэмжээг нарийвчлан тусгасан ёс зүйн дүрмийг батлах, уг дүрмийг бүх ажилтанд хүргэж тэднээр гарын үсэг зуруулан, мөрдөн ажиллах.

Хэсэг II. Төслийн хяналт шалгалт, тайлагнал, үнэлгээ

A. Төслийн тайлан

Зээлдэгч нь тайлант улирлын Төслийн тайланг нэгтгэн тайлант улирал дуусгавар болсноос хойш нэг (1) сарын дотор Банканд ирүүлнэ.

Б. Дунд хугацааны хяналт

Зээлдэгч нь (а) Төсөл хүчин төгөлдөр болсноос хойш хорин дөрөв (24) сарын дараа Банкны хүссэн мэдээлэл бүхий Төслийн дунд хугацааны тайланг бэлтгэн Банканд хүргүүлнэ. Тайланд энэхүү А хэсгийн дагуу хэрэгжүүлсэн хяналт шалгалт, үнэлгээний арга хэмжээг харгалзан тайлант хугацаанд Төслийн гаргасан ололт амжилт, Төслийн зорилтыг хангах, үр дүнтэй үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай төлөвлөсөн арга хэмжээг тусгана; (б) Төслийн дунд хугацааны тайланг хүргүүлсэн өдөр болон түүнээс хойш дөчин тав (45) хоногт багтаан Банктай хамтран Төслийн дунд хугацааны тайланг хянах, тайлангийн дүгнэлт, зөвлөмж, энэ талаарх Банкны дүгнэлтэд үндэслэн Төслийн зорилтыг хангах, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хэсэг III. Зээлийн хөрөнгийн татан авалт

А. Ерөнхий зүйл

Зээлдэгч нь Ерөнхий нөхцөлийн II зүйлээр хязгаарлагдахгүйгээр Зарцуулалт ба Санхүүгийн мэдээллийн албан захидлын дагуу зээлийн хөрөнгийг хуваарилсан хэмжээгээр болон хэрэв боломжтой бол доорх хүснэгтийн Зардлын зүйл анги тус бүрээр заасан хувь хэмжээгээр татан авалт хийж болно.

| <i>Зардлын зүйл анги</i> | <i>Хуваарилсан
зээлийн үнийн дүн
(ам.доллар)</i> | <i>Санхүүжүүлэх
зардлын хувь
хэмжээ
(үүнд гааль болон
НӨАТ-аас бусад
татвар багтсан)</i> |
|---|--|---|
| (1) Бараа, ажил, зөвлөхийн бус болон зөвлөхийн үйлчилгээ, үйл ажиллагааны зардал, төслийн сургалт | 78,000,000 | ОУСБХБ-ны хувь болох 100%-г, Төслийн ЖАТТ-ийн дагуу |
| Нийт | 78,000,000 | |

Б. Санхүүжилт татан авах нөхцөл, татан авах хугацаа

1. Дээрх А хэсгийн заалтыг үл харгалзан хэлэлцээрт талууд гарын үсэг зурсан өдрөөс өмнө хийсэн аливаа төлбөрийг санхүүжүүлэх зориулалтаар зээлийн хөрөнгийг татан авахгүй.
2. Татан авалт хийх сүүлийн хугацаа нь 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байна.

Хэсэг IV. Бусад үүрэг хариуцлага

А. Зээлдэгч нь төслийг хэрэгжүүлэх зорилгоор зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн аливаа бараа, ажил болон/эсвэл үйлчилгээний импорт, худалдан авалт болон/эсвэл нийлүүлэлт нь НӨАТ болон гаалийн татвараас (НӨАТ болон бусад) чөлөөлөгдөх нөхцөлөөр хангана.



ХУВААРЬ 3

Амлалттай холбоотой эргэн төлөх хуваарь

Зээлдэгч нь Зээлийн үндсэн төлбөрийг дараах хүснэгтэд заасан хуваарийн дагуу төлнө. Уг хүснэгтэд зээлийн үндсэн төлбөрийг төлөх огноо болон тухайн огноонд зээлийн үнийн дүнгээс төлөгдөх үндсэн төлбөрийн хувийг ("Хэсэгчлэн төлөх хувь хэмжээ" гэх) тусгасан байна.

| Зээлийн үндсэн төлбөр
төлөх хугацаа | Хэсэгчилсэн төлбөрийн
хувь хэмжээ (%) |
|--|--|
| 12/15/2030 | 1.0300 |
| 6/15/2031 | 1.0600 |
| 12/15/2031 | 1.0800 |
| 6/15/2032 | 1.1100 |
| 12/15/2032 | 1.1400 |
| 6/15/2033 | 1.1700 |
| 12/15/2033 | 1.1900 |
| 6/15/2034 | 1.2200 |
| 12/15/2034 | 1.2600 |
| 6/15/2035 | 1.2900 |
| 12/15/2035 | 1.3200 |
| 6/15/2036 | 1.3500 |
| 12/15/2036 | 1.3900 |
| 6/15/2037 | 1.4200 |
| 12/15/2037 | 1.4600 |
| 6/15/2038 | 1.4900 |
| 12/15/2038 | 1.5300 |
| 6/15/2039 | 1.5700 |
| 12/15/2039 | 1.6100 |
| 6/15/2040 | 1.6500 |
| 12/15/2040 | 1.6900 |
| 6/15/2041 | 1.7300 |
| 12/15/2041 | 1.7700 |
| 6/15/2042 | 1.8200 |
| 12/15/2042 | 1.8600 |

| | |
|------------|--------|
| 6/15/2043 | 1.9100 |
| 12/15/2043 | 1.9600 |
| 6/15/2044 | 2.0100 |
| 12/15/2044 | 2.0600 |
| 6/15/2045 | 2.1100 |
| 12/15/2045 | 2.1600 |
| 6/15/2046 | 2.2200 |
| 12/15/2046 | 2.2700 |
| 6/15/2047 | 2.3300 |
| 12/15/2047 | 2.3900 |
| 6/15/2048 | 2.4500 |
| 12/15/2048 | 2.5100 |
| 6/15/2049 | 2.5700 |
| 12/15/2049 | 2.6300 |
| 6/15/2050 | 2.7000 |
| 12/15/2050 | 2.7700 |
| 6/15/2051 | 2.8400 |
| 12/15/2051 | 2.9100 |
| 6/15/2052 | 2.9800 |
| 12/15/2052 | 3.0500 |
| 6/15/2053 | 3.1300 |
| 12/15/2053 | 3.2100 |
| 6/15/2054 | 3.2900 |
| 12/15/2054 | 3.3700 |
| 6/15/2055 | 2.9600 |



ХАВСРАЛТ

Хэсэг I. Нэр томьёоны тодорхойлолт

1. “Жилийн ажлын төлөвлөгөө ба төсөв” буюу “ЖАТТ” гэсэн товчлол нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын Хэсэг I.B-д дурдсан төлөвлөгөө, төсвийг хэлэх бөгөөд Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр төлөвлөгөөнд тухай бүр өөрчлөлт оруулж болно.
2. “Авлигатай тэмцэх удирдамж” гэж Ерөнхий нөхцөлийн Хавсралтын 6 дахь хэсэгт заасан зорилгын үүднээс 2006 оны 10 дугаар сарын 15-ны өдөр батлан, 2011 оны 01 дүгээр сард шинэчилсэн 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн байдлаарх “ОУСБХБ-ны зээл, ОУХА-ын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгийн санхүүжилттэй төслүүдийг залилан, авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай заавар” болно.
3. “Арвайхээр дэд станц” гэж Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд байрлах мөн нэртэй дэд станц болно.
4. “Баянхонгор дэд станц” гэж Баянхонгор аймгийн Баянхонгор суманд байрлах дэд станц болно.
5. “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” гэдэг нь Эрчим хүчний яамны дэргэд байгуулагдсан, эсхүл байгуулагдах “нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж”-ийг хэлнэ. Уг нэгж нь 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн Засгийн газрын 24 дүгээр тогтоолын дагуу байгуулагдсан (эсхүл байгуулагдана).
6. “Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө” буюу “БОНХТ” гэж Төслийн 2025 оны 04 дүгээр сард хийгдсэн байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө бөгөөд энэхүү Хэлэлцээрт заасны дагуу Төслийн үзүүлэх байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэл, нөлөөллийг арилгахад чиглэсэн арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх хугацаа, зохион байгуулалт, хүний нөөц, сургалт, хяналт, тайлангийн зохицуулалт, тэдгээрийн дагуу боловсруулж хэрэгжүүлэх байгаль орчин, нийгмийн аливаа арга хэрэгслийг агуулсан Зээлдэгчийн зүгээс хэрэгжүүлэх шаардлагатай эсхүл хэрэгжүүлэхэд хүрсэн материаллаг арга хэмжээ, үйл ажиллагааг тодорхойлсон нэмэлт өөрчлөлтийг тухай бүр оруулж болно.
7. “Байгаль орчин, нийгмийн стандарт” буюу “БОНС” гэж Банкнаас нийтэлсэн бөгөөд 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн

хүчин төгөлдөр болсон дараах стандартыг нийтэд нь хэлнэ: (i) “Байгаль орчин, нийгмийн стандарт 1: Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ, менежмент”; (ii) “Байгаль орчин, нийгмийн стандарт 2: Ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл”; (iii) “Байгаль орчин, нийгмийн стандарт 3: Нөөцийг зохистой ашиглах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, удирдах”; (iv) “Байгаль орчин, нийгмийн стандарт 4: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал”; (v) “Байгаль орчин, нийгмийн стандарт 5: Газар чөлөөлөх, газар ашиглахыг хязгаарлах, албадан нүүлгэн шилжүүлэх”; (vi) “Байгаль орчин, нийгмийн стандарт 6: Биологийн олон янз байдлыг хамгаалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент”; (vii) “Байгаль орчин, нийгмийн стандарт 7: Уугуул иргэд/Африкийн Сахарын бүсийн нутгийн уугуул иргэд”; (viii) “Байгаль орчин, нийгмийн стандарт 8: Соёлын өв”; (ix) “Байгаль орчин, нийгмийн стандарт 9: Санхүүгийн зуучлагч”; (x) “Байгаль орчин, нийгмийн стандарт 10: Оролцогч талуудын оролцоо ба мэдээллийн ил тод байдал”.

8. “Ерөнхий нөхцөл” гэж 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн (2023 оны 07 дугаар сарын 15-ны өдөр сүүлийн байдлаар шинэчлэн найруулсан) Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны “ОУСБХБ-ны санхүүжилт, хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн ерөнхий нөхцөл”-ийг хэлнэ.
9. “кВ” гэж цахилгааны хүчдэл хэмжих стандарт хэмжүүр болох киловольт буюу нэг мянган (1,000) вольт болно.
10. “Мандал дэд станц” гэж Дундговь аймгийн Сайнцагаан суманд байрлах мөн нэртэй дэд станцыг хэлнэ.
11. “ЭХЯ” гэж Зээлдэгчийн Эрчим хүчний яам, эсхүл түүний хууль ёсны залгамжлагчийг хэлнэ.
12. “СЯ” гэж Зээлдэгчийн Сангийн яам, эсхүл түүний хууль ёсны залгамжлагчийг хэлнэ.
13. “Олон шатлалт хөтөлбөр буюу ОШХ” гэж Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн цахилгаан, дулааны дэд салбарт сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх замаар эрчим хүчний шилжилтийг дэмжихэд чиглэсэн олон шатлалт хөтөлбөрийг хэлнэ.
14. “Үйл ажиллагааны зардал” гэж төслийн өдөр тутмын уялдаа холбоо бүхий удирдлага, зохион байгуулалт, хяналт хэрэгжүүлэхэд шаардлагатай бараа, зөвлөхийн бус үйлчилгээний зохистой



зардлыг хэлнэ. Үүнд тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байгууламж, албан тасалгааны түрээс болон хэвийн засвар үйлчилгээ, түлш, оффисын хэрэгсэл, ашиглалтын төлбөр, хэрэглээний зүйлс, харилцаа холбооны зардал (шуудан, утас, интернет), тээвэр, орчуулга, хэвлэх, хуулбарлах, банкны шимтгэл, хэвлэл мэдээлэл, сурталчилгаа, даатгал, төсөлтэй холбоотой уулзалт, төсөлтэй холбоотой аялал, амьдрах болон байрлах зардал, гэрээт дэмжлэгийн ажилтан болон төсөлтэй шууд холбоотой бусад удирдлагын зардлууд орно. Гэхдээ зээлдэгчийн төрийн албан хаагчдын цалин, урамшуулал, шимтгэл, шагнал, түүнтэй адилтгах төлбөрийг оруулахгүй.

15. “Худалдан авах ажиллагааны журам” гэж Ерөнхий нөхцөлийн Хавсралтын 85 дахь зүйлийг хэрэгжүүлэх үүднээс 2023 оны 09 дүгээр сард баталсан, 2025 оны 02 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан “Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт авч буй Зээлдэгчид зориулсан Дэлхийн Банкны худалдан авах ажиллагааны журам”-ыг хэлнэ.
16. “Төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэр” гэж Зээлдэгчийн Баянхонгор, Өвөрхангай, Дундговь аймаг дахь Мандалговь-Арвайхээр цахилгаан дамжуулах агаарын шугам дайран өнгөрдөг газар нутгийг, мөн Төсөл хэрэгжих явцад Банктай тохиролцон Зээлдэгчийн сонгосон бусад орон нутгийг нийтэд нь хэлнэ.
17. “Төсөл удирдах баг” гэж Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн дэргэд байгуулагдсан, энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын Хэсэг I.A.2.(б)-д заасны дагуу Зээлдэгчийн байгуулан ажиллуулах алба эсхүл түүний хууль ёсны залгамжлагч төсөл хэрэгжүүлэх багийг хэлнэ.
18. “Төслийн үйл ажиллагааны гарын авлага” гэж Зээлдэгчийн ЭХЯ-аар дамжуулан баталж, төслийн хэрэгжилтийн явцад шинэчлэх гарын авлагыг хэлнэ. Уг гарын авлагад дараах зохицуулалт, дэг журмын асуудлыг нарийвчлан тусгана. Үүнд: (а) институцын зохион байгуулалт, зохицуулалт, төслийн өдөр тутмын хэрэгжилт; (б) хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн удирдлага; (в) худалдан авах ажиллагаа; (г) байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийн арга хэмжээ; (д) хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагнал, мэдээлэл харилцаа; (е) шударга байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө; (ж) олон улсын сайн туршлага, Төслийг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагад нийцүүлэн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах; (ж) төсөлд шаардагдах бусад захиргааны, санхүүгийн, техникийн болон зохион байгуулалтын

зохицуулалт, дэг журам. Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр уг гарын авлагад өөрчлөлт оруулж болох ба гарын авлагын хуваарт уг нөхцөлийг тусгана.

19. “Төслийн удирдах хороо” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын Хэсэг I.A.2.(а)-д заасны дагуу Зээлдэгчийн байгуулан ажиллуулах хороо эсхүл түүний хууль ёсны залгамжлагч этгээдийг хэлнэ.
20. “Хэлэлцээрт гарын үсэг зурсан огноо” гэж Зээлдэгч болон Банк энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан хоёр огнооны сүүлийн огноог хэлэх бөгөөд уг тодорхойлолт нь энэхүү Хэлэлцээр болон Ерөнхий нөхцөлд дурдсан “Зээлийн хэлэлцээрийн огноо”-ны бүх ишлэлд хамаарна.
21. “Сургалт” гэж Банкнаас баталсан сургалтын төлөвлөгөөнд үндэслэн Төслийн хүрээнд зохион байгуулж буй сургалт, семинар, туршлага судлах аялалд боловсон хүчнийг оролцуулахад шаардагдах бараа, үйлчилгээний үндэслэл бүхий зардлыг хэлнэ. Уг зардалд сургалт, семинар, танилцах аялалд оролцогчдын томилолтын зардал, сургагч багшийн үйлчилгээтэй холбоотой зардал, сургалт, семинарын байрны түрээсийн төлбөр, сургалт, семинарын материал бэлтгэх, олшруулах зардал, сургалт, семинар эсхүл танилцах аялалд бэлтгэх, зохион байгуулахтай холбоотой бусад зардлыг хамруулах ба харин зөвлөхийн цалин хөлс, Зээлдэгчийн төрийн албан хаагчийн цалин, урамшуулал, шан харамж, эсхүл түүнтэй адилтгах зардлыг хамруулахгүй.
22. “Өвөрхангай дэд станц” гэж нь зээлийн төслийн эх үүсвэрээс санхүүжигдсэн Өвөрхангай аймгийн Тарагт суманд байрлах ижил нэртэй дэд станц болно.

Хэсэг II. Ерөнхий нөхцөлийн өөрчлөлтүүд

Ерөнхий нөхцөлд дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

1. Хэсэг 3.01 (Үйлчилгээний хураамж; Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж, Эрсдэлийн нэмэлт хураамж)-ийг дараах байдлаар шинэчлэн найруулав:

“Хэсэг 3.01. Үйлчилгээний хураамж, Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж

(а) Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээрт заасан хувь хэмжээгээр “Үйлчилгээний хураамж”-ийг Банканд төлнө. Хэсэг 2.07(б)-д



өөрөөр заагаагүй бол Зээлдэгч нь “Хүчин төгөлдөр болсон өдөр”-өөс хойш жар (60) хоногийн дотор уг Үйлчилгээний хураамжийг төлнө.

(б) Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээрт заасан хувь хэмжээгээр татан аваагүй зээлийн хөрөнгийн үлдэгдэлд “Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж”-ийг Банканд төлнө. Уг зээлийн хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж нь Зээлийн хэлэлцээр байгуулсан өдөр эсхүл Зээлийг Банк баталсан өдрөөс хойш дөрөв дэх жилийн ойн өдрийн аль сүүлийн өдрөөс эхлэн тооцогдох бөгөөд Зээлдэгч нь Зээлийн данснаас зарцуулалт хийсэн эсхүл цуцалсан тухайн өдрүүд хүртэл хуримтлагдана. Зээлдэгч нь, Хэсэг 2.07 (в)-д өөрөөр заагаагүй бол, Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг хагас жил тутам Зээлийн төлбөр гүйцэтгэх өдөр төлнө.

2. Хэсэг 3.04 (Урьдчилсан төлбөр)-ийг дараах байдлаар шинэчлэн найруулав:

“3.04. Урьдчилсан төлбөр

(а) Зээлдэгч нь Банканд дөчин таваас доошгүй (45) хоногийн өмнө мэдэгдэл өгсний дараа Банкны хүлээн зөвшөөрсөн өдөр дараах дүнг хугацаанаас нь өмнө Банканд буцаан төлж болно (Зээлдэгч нь тухайн өдөр хүртэл төлбөл зохих бүх зээлийн төлбөрийг бүрэн төлсөн тохиолдолд): (i) тухайн өдрийн байдлаар татан авсан зээлийн үлдэгдлийг бүхэлд нь; эсхүл (ii) аль нэг буюу хэд хэдэн хуваарьт Зээлийн үндсэн дүнг бүхэлд нь татан авсан зээлийн үлдэгдлийг хэсэгчлэн урьдчилж төлөхдөө Зээлдэгчийн өөрийн заасан журмаар төлнө, эсхүл Зээлдэгч тодорхой журам заагаагүй бол дараах байдлаар төлнө: (А) хэрэв Зээлийн хэлэлцээрт Зээлийн үндсэн төлбөрийн тодорхой зарцуулсан дүнгүүдийг тусад нь хуваарилан төлөхөөр заасан бол хамгийн сүүлд татан авсан дүнг эхэлж төлөх зарчмаар, тухайн зарцуулсан дүнгийн хамгийн сүүлийн хугацаатай хэсгээс эхлэн урвуу дарааллаар хамааруулан төлнө; (Б) бусад бүх тохиолдолд урьдчилж буцаах төлбөрийг зээлийн хугацаа нь болсоноос эсрэг дарааллаар төлөх буюу хамгийн сүүлийн хуваарьт хугацааны дүнг эхэлж төлнө.

(б) Хэрэв хугацаанаас өмнө төлөхөөр төлөвлөж буй Зээлийн аливаа дүнтэй холбогдуулан Хөрвүүлэлт хийгдсэн бөгөөд тухайн үед Хөрвүүлэлтийн хугацаа дуусаагүй байвал, Хэсэг 4.06-д заасан заалтууд хамаарна.

3. Дараах нэр томьёоны тодорхойлолтыг Хавсралтад цагаан толгойн үсгийн дарааллаар шинээр [#]-[#] догол мөрүүд болгон нэмэх бөгөөд, үүний улмаас бусад тодорхойлолт (хамааралтай бол)-ыг зохих ёсоор дахин дугаарлав.

“75. “Зээлийн төлбөр” гэж Зээлийн хэлэлцээрийн дагуу Зээлийн холбогдогч талуудын Банканд төлөх үүрэг хүлээсэн аливаа төлбөрийг ойлгох бөгөөд үүнд (гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй) Зээлдэгчээс төлөх татан авсан зээлийн үлдэгдэл, хүү, үйлчилгээний хураамж, хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж, хугацаа хэтэрсний хүү (хэрэв байгаа бол), аливаа нэмэлт хураамж, хөрвүүлсний хураамж, хөрвүүлснийг хугацаанаас нь өмнө цуцалсны хураамж, зээлийн хүүгийн дээд хязгаар эсвэл зээлийн хүүгийн өөрчлөлтийн дээд, доод хязгаар тогтоосны урьдчилгаа шимтгэл, хаалтын төлбөрийг хэлнэ.

“81. “Зээлийн төлбөр гүйцэтгэх өдөр” гэж Зээлийн хэлэлцээрт заасны дагуу Зээлийн хэлэлцээр байгуулсан өдөр эсхүл түүнээс хойш тохиох, зээлийн хүү, зээл ашиглаагүй үлдэгдэлд ногдох хураамж болон бусад зээлийн төлбөр, шимтгэл (үйлчилгээний хураамжаас бусад)-ийг төлөх ёстой өдөр бүрийг ойлгоно.

4. Хавсралтын 4-т заасан (“Хуваарилсан илүү эрсдэлийн дүн”); 53-т заасан (“Эрсдэлийн нэмэлт хураамж”); 99-т заасан (“Стандарт эрсдэлийн хязгаар”) нэр томьёоны тодорхойлолт болон 105-д заасан (Нийт эрсдэл) нэр томьёоны тодорхойлолтыг бүхэлд нь хүчингүй болгож, дараагийн догол мөрүүдийг зохих ёсоор дахин дугаарлав.



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

**МОНГОЛ УЛС, ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН
УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТЫН ЗЭЭЛИЙН БАНК ХООРОНД
БАЙГУУЛСАН "ТӨВИЙН БҮСИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ,
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСЛИЙН
III ҮЕ ШАТ"-НЫ ЗЭЭЛИЙН БОЛОН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР**

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

Зээлийн болон Төслийн хэлэлцээр

2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

талууд

Монгол Улс
(цаашид "**Зээлдэгч**" гэх)
Монгол Улсын Сангийн яам
ба

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын
зээлийн банк Франкфурт ам Майн хот
(**"СБЗБ"**)
ба

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК
(цаашид "**Төсөл хэрэгжүүлэгч байгууллага**" гэх)
хамтран байгуулсан

17,000,000.00 еврогийн

Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний
үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат

BMZ-дугаар: 2022.652.05



Агуулга

1. Зээлийн хэмжээ болон зориулалт.....
 2. Зээлийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагад дамжуулан зээлдүүлэх....
 3. Зээлийн зарцуулалт.....
 4. Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж, Зээлийн хүү, Зээлийн эргэн төлөлт.....
 5. Зээлийн санхүүжилтийг түдгэлзүүлэх ба хугацаанаас нь өмнө эргэн төлөх.....
 6. Зардал ба бусад татвар, хураамж.....
 7. Хэлэлцээр хүчин төгөлдөр болох болон хууль ёсны төлөөлөл.....
 8. Төсөл.....
 9. Төсөлтэй холбоотой мэдээллийг нийтлэх ба дамжуулах.....
 10. Бусад заалтууд.....
- Хавсралт 1а: Зээлдэгчийн дагаж мөрдөх гэрээний нөхцөлүүд.....
- Хавсралт 1б: Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын дагаж мөрдөх үүрэг....
- Хавсралт 2: Зээлдэгчийн хууль зүйн зөвлөхийн гаргах хууль зүйн дүгнэлтийн маягт.....

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас (цаашид “ХБНГУ” гэх) Монгол Улсад суугаа Элчин сайдын яамнаас Монгол Улсын Гадаад харилцааны яаманд 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдөр илгээсэн 87/2022 дугаар ноот бичгийг үндэслэн, 1992 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр байгуулсан ХБНГУ-ын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын Техникийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр, мөн 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдөр ноот бичиг солилцох хэлбэрээр байгуулсан олон улсын эрх зүйн шинжтэй Техникийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр (цаашид “**Техникийн хамтын ажиллагааны хэлэлцээрүүд**” гэх) энэхүү хэлэлцээрт хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд Монгол Улсын Гадаад харилцааны яамны _____ өдрийн ноот бичгийг үндэслэн Зээлдэгч, Төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон СБЗБ нь дараах Зээлийн болон Төслийн хэлэлцээрийг (цаашид “**Гэрээ**” гэх) байгуулж байна.

1. Зээлийн хэмжээ болон зориулалт

- 1.1. СБЗБ-ны зүгээс Зээлдэгчид олгох зээлийн хэмжээ нь дараах мөнгөн дүнгээс хэтрэхгүй

17,000,000.00 евро (үсгээр: арван долоон сая евро)
(“**Зээл**”).

- 1.2. Зээлдэгч нь энэхүү Гэрээний 2 дугаар зүйлд заасан нөхцөлийн дагуу Зээлийг бүхэлд нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагад дамжуулан олгоно. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь Зээлийг зөвхөн Монгол Улсын Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээнд хамаарах дэд станцууд болон дамжуулах шугамын барилга угсралт, шинэчлэл болон сэргээн засварын ажилд, тухайлбал нийслэл Улаанбаатар хотын нэг дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх тоног төхөөрөмж нийлүүлэх, угсралт/суурилуулалтын ажил, мөн олон улсын зөвлөх үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх (цаашид “**Төсөл**” гэх), гадаад валютын зардлыг төлөхөд голлон ашиглагдана. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон СБЗБ нь Төслийн нарийвчилсан нөхцөлүүд болон Зээлээр санхүүжүүлэх бараа, үйлчилгээний жагсаалтыг тусгайлсан гэрээгээр (“**Тусгай гэрээ**”) тохиролцоно.
- 1.3. Зээлдэгч болон Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хариуцах татвар болон улсын бусад төлбөр хураамж, мөн гаалийн татварыг Зээлээр санхүүжүүлэхгүй.

2. Зээлийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагад дамжуулан зээлдүүлэх



- 2.1. Зээлдэгч нь энэхүү гэрээний 4.2 болон 4.4 дүгээр зүйлд заасан нөхцөл, шаардлагын дагуу Зээлийг Төсөл хэрэгжүүлэгч байгууллагад тусгайлсан зээлийн гэрээ байгуулан дамжуулан зээлдүүлнэ.
- 2.2. Зээлийн анхны санхүүжилтийг олгохоос өмнө Зээлдэгч нь энэхүү гэрээний 2.1 дүгээр зүйлд заасан зээлийн гэрээний хуулбар болон түүний баталгаат орчуулгыг СБЗБ-нд хүргүүлнэ.
- 2.3. Энэхүү гэрээний дагуу Зээлийг дамжуулан зээлдүүлснээр Төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон СБЗБ хооронд аливаа төлбөрийн үүрэг, хариуцлага үүсэхгүй.

3. Зээлийн зарцуулалт

- 3.1. СБЗБ нь төслийн хэрэгжилтийн явцтай уялдуулан, Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хүсэлтийн дагуу Зээлийн санхүүжилтийг олгоно. Төсөл хэрэгжүүлэгч болон СБЗБ-ны хооронд байгуулсан Тусгайлсан гэрээгээр Зээлийн санхүүжилтийн журмыг, ялангуяа хүсэлт гаргасан зээлийн дүнг энэхүү Гэрээнд заасан зорилгод ашиглаж буйг баталгаажуулах баримт бичгийн талаарх шаардлагыг харилцан тохиролцоно.
- 3.2. СБЗБ нь 2029 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс хойш зээлийн санхүүжилт хийхээс татгалзах эрхтэй.

4. Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж, зээлийн хүү, зээлийн эргэн төлөлт

- 4.1. Зээлдэгч нь ашиглагдаагүй Зээлийн дүнд жилийн 0.25 хувийн хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж төлнө. Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш гурван сарын дараагаас эхлэн тооцох бөгөөд зээлийн ашиглалтууд бүрэн гарсан өдрөөр дуусгавар болно.
- 4.2. Зээлдэгч нь зээлд жилийн 2.00 хувийн хүү төлнө. Хүүг зээлийн санхүүжилт гарсан өдрөөс эхлэн тооцож, энэхүү гэрээний 4.10 дугаар зүйлд заасны дагуу СБЗБ-ны дансанд эргүүлэн төлөх хүртэлх хугацаанд бодож төлнө.
- 4.3. Зээлдэгч нь хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж, зээлийн хүү болон энэхүү гэрээний 4.6 дугаар зүйлд заасан хугацаа хэтэрсэн төлбөрт ногдох хураамж зэрэг аливаа төлбөрийг хагас жил бүр, 05 дугаар сарын 15 болон 11 дүгээр сарын 15-ны өдрүүдэд тус тус төлнө. Эхний хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг эхний хүүгийн төлбөртэй хамт төлнө.

4.4. Зээлдэгч нь зээлийг дараах хуваарийн дагуу эргэн төлнө:

| Хуваарьт төлөлт | Огноо | | Дүн | Валют |
|-----------------|----------------|------|------------|-------|
| 1 | 11-р сарын 15, | 2036 | 425.000,00 | Евро |
| 2 | 5-р сарын 15, | 2037 | 425.000,00 | Евро |
| 3 | 11-р сарын 15, | 2037 | 425.000,00 | Евро |
| 4 | 5-р сарын 15, | 2038 | 425.000,00 | Евро |
| 5 | 11-р сарын 15, | 2038 | 425.000,00 | Евро |
| 6 | 5-р сарын 15, | 2039 | 425.000,00 | Евро |
| 7 | 11-р сарын 15, | 2039 | 425.000,00 | Евро |
| 8 | 5-р сарын 15, | 2040 | 425.000,00 | Евро |
| 9 | 11-р сарын 15, | 2040 | 425.000,00 | Евро |
| 10 | 5-р сарын 15, | 2041 | 425.000,00 | Евро |
| 11 | 11-р сарын 15, | 2041 | 425.000,00 | Евро |
| 12 | 5-р сарын 15, | 2042 | 425.000,00 | Евро |
| 13 | 11-р сарын 15, | 2042 | 425.000,00 | Евро |
| 14 | 5-р сарын 15, | 2043 | 425.000,00 | Евро |
| 15 | 11-р сарын 15, | 2043 | 425.000,00 | Евро |
| 16 | 5-р сарын 15, | 2044 | 425.000,00 | Евро |
| 17 | 11-р сарын 15, | 2044 | 425.000,00 | Евро |
| 18 | 5-р сарын 15, | 2045 | 425.000,00 | Евро |
| 19 | 11-р сарын 15, | 2045 | 425.000,00 | Евро |
| 20 | 5-р сарын 15, | 2046 | 425.000,00 | Евро |
| 21 | 11-р сарын 15, | 2046 | 425.000,00 | Евро |
| 22 | 5-р сарын 15, | 2047 | 425.000,00 | Евро |



| | | | | |
|----|----------------|------|------------|------|
| 23 | 11-р сарын 15, | 2047 | 425.000,00 | Евро |
| 24 | 5-р сарын 15, | 2048 | 425.000,00 | Евро |
| 25 | 11-р сарын 15, | 2048 | 425.000,00 | Евро |
| 26 | 5-р сарын 15, | 2049 | 425.000,00 | Евро |
| 27 | 11-р сарын 15, | 2049 | 425.000,00 | Евро |
| 28 | 5-р сарын 15, | 2050 | 425.000,00 | Евро |
| 29 | 11-р сарын 15, | 2050 | 425.000,00 | Евро |
| 30 | 5-р сарын 15, | 2051 | 425.000,00 | Евро |
| 31 | 11-р сарын 15, | 2051 | 425.000,00 | Евро |
| 32 | 5-р сарын 15, | 2052 | 425.000,00 | Евро |
| 33 | 11-р сарын 15, | 2052 | 425.000,00 | Евро |
| 34 | 5-р сарын 15, | 2053 | 425.000,00 | Евро |
| 35 | 11-р сарын 15, | 2053 | 425.000,00 | Евро |
| 36 | 5-р сарын 15, | 2054 | 425.000,00 | Евро |
| 37 | 11-р сарын 15, | 2054 | 425.000,00 | Евро |
| 38 | 5-р сарын 15, | 2055 | 425.000,00 | Евро |
| 39 | 11-р сарын 15, | 2055 | 425.000,00 | Евро |
| 40 | 5-р сарын 15, | 2056 | 425.000,00 | Евро |

- 4.5. Энэхүү Гэрээний дагуу хийх төлбөрийн өдөр нь Банкны ажлын өдөр биш бол Зээлдэгч нь тухайн төлбөрийг дараагийн Банкны ажлын өдөр хийж гүйцэтгэнэ. Хэрэв дараагийн Банкны ажлын өдөр нь дараагийн сард тохиож байгаа тохиолдолд тухайн төлбөр нь хуваарьт сарын сүүлийн банкны ажлын өдөрт хийгдсэн байх шаардлагатай. “**Банкны ажлын өдөр**” гэдэг нь ХБНГУ-ын Франкфурт ам Майнд байрлах арилжааны банкууд ердийн үйл ажиллагаа явуулдаг Бямба, Ням гарагуудаас бусад өдрийг ойлгоно.

4.6. Хэрэв зээлийн үндсэн төлбөр СБЗБ-ны дансанд хугацаандаа ороогүй тохиолдолд СБЗБ нь тухайн төлбөрийг төлөгдөх ёстой өдрөөс энэхүү гэрээний 4.10 дугаар зүйлд заасан СБЗБ-ны дансанд орж ирэх өдөр хүртэлх хугацаанд суурь хүү дээр жилийн 3%-ийн хүүг нэмж тооцно. “Суурь хүү” гэдэг нь төлбөр төлөгдөх ёстой байсан өдрийн Германы Холбооны банкнаас тогтоосон хүүг хэлнэ. Хэрэв хүүгийн төлбөрийн хугацаа хэтэрсэн тохиолдолд СБЗБ нь учирсан хохирлыг шаардах эрхтэй. Уг хохирлын хэмжээ нь хугацаа хэтэрсэн хүүгийн төлбөрт тухайн хугацаанд мөрдөгдөж буй суурь хүү дээр 3%-ийг нэмэгдүүлж тооцсоноос хэтрэхгүй байна.

4.7. Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж, зээлийн хүү болон энэхүү гэрээний 4.6 дугаар зүйлд заасан хугацаа хэтэрсэн төлбөрт ногдох хураамжийг жилийг 360 хоног, сарыг 30 хоногтой гэж тооцож төлнө.

4.8. Ашиглагдаагүй болон хугацаанаас өмнө төлсөн зээлийн дүнг эргэн төлөх хуваарийн дагуу үлдсэн үндсэн төлбөрүүдийн дүнгээс тэнцүү хэмжээгээр суутгах бөгөөд СБЗБ нь тухайн тохиолдолд, тухайлбал төлбөрийн хэмжээ бага байвал өөр аргаар суутган тооцно.

4.9. СБЗБ нь Зээлдэгчээс хүлээн авсан аливаа төлбөрийг энэхүү Гэрээ эсвэл СБЗБ болон Зээлдэгчийн хооронд байгуулсан бусад зээлийн гэрээний төлбөрт суутган тооцох эрхтэй.

4.10. Зээлдэгч нь аливаа төлбөрийг доорх данс хаягаар, Еврогоор шилжүүлэх бөгөөд энэхүү төлбөрийг буцаан нэхэмжлэх эрхгүй.

Хүлээн авагч: СБЗБ

SWIFT-BIC: KFWIDEFF

IBAN: DE94 5002 0400 3139 4059 82

5. Зээлийн санхүүжилтийг түдгэлзүүлэх ба хугацаанаас өмнө эргэн төлөх

5.1. Зээлдэгч нь энэхүү гэрээний 8 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлсэн нөхцөлд дараах эрхүүдийг эдэлнэ:

а. ашиглагдаагүй байгаа зээлийг хэмжээ харгалзахгүй цуцлах, мөн



б. зээлийг хугацаанаас өмнө бүхэлд нь буюу хэсэгчлэн урьдчилан төлөх.

5.2. СБЗБ нь дараах нөхцлүүдээс бусад тохиолдолд зээлийн ашиглалтыг цуцлах эрхгүй:

а. Зээлдэгч нь СБЗБ-нд төлөх ёстой зээлийн төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулаагүй тохиолдолд,

б. энэхүү Гэрээ болон үүнд хамаарах бусад гэрээний нөхцөлүүдийг зөрчигдсөн тохиолдолд,

в. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь Зээлийг Гэрээнд заасан зориулалтын дагуу ашигласан болохоо нотолж чадаагүй тохиолдолд,

г. энэхүү Гэрээнд заасан СБЗБ-ны хүлээх үүрэг нь холбогдох хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа тохиолдолд,

д. төслийн зорилго, түүний хэрэгжүүлэлт, үйл ажиллагаанд эсхүл Зээлдэгчийн энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу төлбөр хийхэд давтагдашгүй хүчин зүйлийн улмаас боломжгүй болох буюу ноцтой саад тотгор учирсан тохиолдолд.

5.3. Энэхүү гэрээний 5.2 дугаар зүйлийн а), б), в) болон г) хэсгүүдэд заасан нөхцөлүүдийн аль нэг нь үүсэж, СБЗБ-аас тогтоосон 30 хоногоос багагүй хугацаанд зөрчлийг шийдвэрлээгүй тохиолдолд СБЗБ нь дараах арга хэмжээг авах эрхтэй. Үүнд:

а. Энэхүү гэрээний 5.2 дугаар зүйлийн а), б) болон г)-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Зээлийн нийт үлдэгдэл, хуримтлагдсан нийт хүү болон бусад холбогдох бүх төлбөрийг нэн даруй эргэн төлөхийг шаардах;

б. Энэхүү гэрээний 5.2 дугаар зүйлийн в)-д заасны дагуу Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь энэхүү Гэрээнд тусгасан зориулалтын дагуу зээлийг ашигласан гэдгээ нотолж чадаагүй тохиолдолд дээрх Зээлийн төлбөрүүдийг нэн даруй эргүүлэн төлөхийг шаардах.

6. Зардал ба бусад татвар, хураамж

6.1. Зээлдэгч нь энэхүү Гэрээний хүрээнд хийх бүх төлбөрийг аливаа татвар, улсын бусад төлбөр, хураамж болон бусад зардлыг

суутгахгүйгээр бүрэн хэмжээгээр төлнө. Хэрэв Зээлдэгч нь хууль тогтоомжийн дагуу эсхүл бусад шалтгаанаар төлбөрөөс аливаа татвар, хураамж суутгах буюу суутган төлөх үүрэг хүлээвэл, СБЗБ нь энэхүү Гэрээний дагуу авах ёстой төлбөрийн дүнг татвар, хураамжийг суутгасны дараа бүрэн хэмжээгээр хүлээн авах боломжийг хангах зорилгоор Зээлдэгч нь төлөх төлбөрийн дүнг шаардлагатай хэмжээгээр нэмэгдүүлэн төлнө.

6.2. Зээлдэгч нь Зээлийн санхүүжилт болон эргэн төлөлттэй холбоотой гарч буй шилжүүлгийн болон валют хөрвүүлэх зардлыг төлнө.

6.3. Зээлдэгч нь энэхүү Гэрээг байгуулах болон хэрэгжүүлэхтэй холбоотой ХБНГУ-аас өөр бусад оронд үүсэх аливаа татвар, бусад төрлийн төлбөр, хураамжийг бүрэн хариуцна.

7. Хэлэлцээр хүчин төгөлдөр болох болон хууль ёсны төлөөлөл

7.1. Дараах урьдчилсан нөхцөлүүдийг СБЗБ-ны шаардлагад нийцсэн хэлбэр болон агуулгаар биелүүлсэн тохиолдолд СБЗБ нь энэхүү Гэрээний дагуу зээлийн санхүүжилт хийх үүргийг хүлээнэ:

а. Зээлдэгч нь СБЗБ-ны шаардлагад нийцүүлэн дараах баримт бичгүүдийг бүрдүүлж өгснөөр энэхүү Гэрээ эрх зүйн хувьд хүчин төгөлдөр, хэрэгжих боломжтой болно. Үүнд: Энэхүү Гэрээний Хавсралт 2 ("*Зээлдэгчийн хууль зүйн зөвлөхийн хууль зүйн дүгнэлтийн загвар*")-т нийцсэн агуулгатай хууль зүйн дүгнэлт, мөн уг хууль зүйн дүгнэлтэд иш татагдсан бүх баримт бичгийн баталгаажуулсан хуулбар. Тэдгээр нь энэхүү Гэрээний хэл дээрх албан ёсны орчуулгатай байна. Тэдгээр баримт бичгээр Зээлдэгч нь энэхүү Гэрээний бүх үүргийг хүчин төгөлдөр хүлээхийн тулд өөрийн Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг бүрэн хангаж байгааг нотлох ёстой;

б. СБЗБ нь энэхүү Гэрээ болон Тусгайлсан гэрээ тус бүрийн эх хувийг эрх зүйн хувьд хүчин төгөлдөр гарын үсэг зурж баталгаажуулсан байдлаар хүлээн авсан байх ёстой. Монгол Улсын Сангийн сайд эсвэл түүний СБЗБ-нд итгэмжлэн томилсон, баталгаат гарын үсэг бүхий этгээд энэхүү гэрээг хэрэгжүүлэхэд Зээлдэгчийг төлөөлнө. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын Гүйцэтгэх захирал болон түүний СБЗБ-нд итгэмжлэн томилсон баталгаат гарын үсэг бүхий этгээд энэхүү гэрээг хэрэгжүүлэхэд Төсөл хэрэгжүүлэгч байгууллагыг төлөөлнө. Төлөөлөгч этгээдийн



томилолтыг хүчингүй болгосон тухай мэдэгдлийг СБЗБ хүлээж авах хүртэл төлөөллийн бүрэн эрх хүчин төгөлдөр байна.

- 7.2. Энэхүү Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, түүнчлэн гэрээнд оролцогч талуудад хүргэх аливаа мэдэгдэл, тайлбар зэрэг нь гагцхүү бичгээр үйлдэгдэнэ. Ийм мэдэгдэл эсхүл тайлбар нь тухайн гэрээнд оролцогч талуудын дараах хаягт эсвэл эсрэг талдаа урьдчилан мэдэгдсэн өөр хаягт хүргэгдсэн даруйд хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэнд тооцогдоно.

СБЗБ-ны хаяг:

СБЗБ

Шуудангийн хайрцаг 11 11 41

60046 Франкфурт-ам-Майн хот

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Факсын дугаар: +49 69 7431-2944

Зээлдэгчийн хаяг:

Сангийн яам

Монгол Улс, Улаанбаатар хот 15160,

С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын

II байр

Төсөл хэрэгжүүлэгч
байгууллагын хаяг:

Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ
Төрийн Өмчит Хувьцаат компани
(ЦДҮС) Монгол Улс, Улаанбаатар хот
17033, Чингисийн өргөн чөлөө-45,
Хан-Уул дүүрэг

- 7.3. Энэхүү гэрээнд СБЗБ болон Зээлдэгчийн хоорондын эрх зүйн харилцаанд хамаарах нэмэлт, өөрчлөлт хийхэд Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын зөвшөөрөл шаардагдахгүй.

8. Төсөл

- 8.1. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь дараах үүрэг хүлээнэ:

а. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь төслийг санхүү, инженерийн зохистой практиктай нийцүүлэн, мөн Төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон СБЗБ хооронд тохиролцсон төслийн үзэл баримтлалтай нийцүүлэн бэлтгэж, хэрэгжүүлж, ашиглалтад оруулж, засвар үйлчилгээ хийх үүрэгтэй;

б. Төслийн бэлтгэл ажил болон барилга барих ажлын хяналтыг хараат бус, мэргэжлийн зөвлөхүүдэд хариуцуулах ба Төслийн хэрэгжилтэд мэргэшсэн байгууллагыг томилно;

в. Төсөл хэрэгжүүлэгч нь Төсөлтэй холбоотой аливаа худалдан авалтын төлөвлөгөөг багтаасан, Тусгай гэрээнд заасан худалдан авалтын бүх журам, заалтыг мөрдөнө;

г. Төслийн хэрэгжилтэд шаардагдах бүх бараа, үйлчилгээний зардлыг тодорхой харуулсан, мөн Зээлээр санхүүжүүлсэн бараа, үйлчилгээг илтгэсэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн баримтыг өөрөө хөтлөх буюу хөтлүүлж хадгална;

д. Төсөлд шаардлагатай бүх бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн тодорхой жагсаалтыг гаргаж, эдгээр төлбөр нь Зээлийн хөрөнгөөр санхүүжигдсэн гэдгийг нотлох тайлан, мэдээлэл бүхий санхүүгийн баримт бичгийг хөтлөх үүргийг хүлээнэ;

е. Төслийн хэрэгжилт болон цаашдын явцын талаар СБЗБ-ны шаардсан бүхий л мэдээлэл, тайланг Төсөл хэрэгжүүлэгч нь СБЗБ-нд гаргаж өгнө;

ё. Зээлдэгч нь Зээлээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний гэрээг олгосны дараа **Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)** болон түүний гишүүн орнуудаас “Холбоогүй Хөгжлийн Албан Ёсны Тусламжийн зээлийн ил тод байдлын тухай хэлэлцээр”-ийн хүрээнд ирүүлсэн аливаа лавлагаа, асуулгыг сааталгүйгээр СБЗБ-д дамжуулж, тэдгээрт өгөх хариуг СБЗБ-тай хамтран бэлтгэнэ.

8.2. Төсөл хэрэгжүүлэгч болон СБЗБ-ны 8.1 дүгээр зүйлийн нарийвчилсан нөхцөлийг Тусгайлсан гэрээгээр тогтооно.

8.3. Зээлдэгч ба Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь дараах үүрэг хүлээнэ:

а. Төслийг бүрэн санхүүжүүлэх үүрэг хүлээж, шаардлагатай тохиолдолд энэхүү Зээлээс санхүүжигдээгүй зардлыг өөр эх үүсвэрээр бүрэн төлж байгааг нотлох баримтыг СБЗБ-нд гаргаж өгнө.

б. Төслийн хэрэгжилт, ашиглалт эсвэл зорилгыг хэрэгжүүлэх боломжгүй болгох, эсхүл ноцтойгоор эрсдэлд оруулах аливаа нөхцөл байдал үүссэн тохиолдолд өөрийн санаачилгаар даруй СБЗБ-нд мэдэгдэнэ.



8.4. Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагыг Төслийг хэрэгжүүлэхэд болон энэхүү Гэрээний дагуу Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хүлээсэн үүргийг биелүүлэхэд инженерийн болон санхүүгийн зөв дадлага, туршлагад нийцүүлэн туслалцаа үзүүлнэ. Тухайлбал Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх зөвшөөрлийг Төсөл хэрэгжүүлэгч байгууллагад олгоно.

8.5. Энэхүү Зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, материалыг тээвэрлэхдээ Зээлдэгчтэй байгуулсан Техникийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрүүдийн заалтуудыг мөрдөнө.

9. Төсөлтэй холбоотой мэдээллийг нийтлэх ба шилжүүлэх

9.1. Хөгжлийн хамтын ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дээд зэргийн ил тод байдал, үр ашигтай байдлын зарчмыг хангах зорилгоор KfW нь гэрээ байгуулахаас өмнөх хэлэлцээний үе шат, Төслийн холбогдох гэрээнүүдийг хэрэгжүүлэх хугацаанд болон гэрээний дараах үе шатанд (цаашид “**Бүх хугацаа**” гэх) Төсөл болон түүний санхүүжилттэй холбоотой тодорхой мэдээллийг (үүнд байгаль орчин, нийгмийн ангилал, үнэлгээний үр дүн болон хэрэгжилтийн дараах үнэлгээний тайлангууд багтана) нийтэлнэ.

Мэдээлэл нь СБЗБ-ны “СБЗБ-Хөгжлийн банк” хэмээх бизнесийн салбарын вэбсайт дээр (<http://transparenz.kfw-entwicklungsbank.de/>) тогтмол нийтлэгдэнэ.

Төслийн болон түүний санхүүжилтийн талаарх мэдээллийг (СБЗБ эсвэл энэхүү гэрээний 9.3 дугаар зүйлд заасны дагуу гуравдагч этгээдээр дамжуулан) нийтлэхдээ гэрээний баримт бичиг болон Төсөл болон түүний санхүүжилтэд оролцогч талуудын аливаа нарийн санхүүгийн болон бизнесийн нарийвчилсан мэдээллийг нийтлэхгүй. Тухайлбал дараах мэдээллийг багтаахгүй:

а. санхүүгийн дотоод мэдээллийн талаар;

б. бизнесийн стратегиуд;

в. компанийн дотоод дүрэм, журам болон тайлан;

г. хувь хүний тухай нарийвчилсан мэдээлэл;

д. талуудын санхүүгийн байдлын талаарх СБЗБ-ны дотоод үнэлгээ.

9.2. СБЗБ-ны төслийн үйл ажиллагаа хэрхэн санхүүжиж байгаа талаарх мэдээллийг төсөл хэрэгжих бүхий л цаг үед дор дурдсан байгууллагуудад ил тод, үр ашигтай байдлыг хангахын тулд тодорхой мэдээллийг хуваалцана.

а. СБЗБ-ны салбарууд;

б. ХБНГУ болон түүний харьяа эрх бүхий байгууллага, институт, агентлагууд эсвэл нэгжүүд;

в. Германы хоёр талын хөгжлийн хамтын ажиллагааны чиглэлээр ажилладаг бусад хэрэгжүүлэгч байгууллагууд, ялангуяа Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ);

г. Статистик мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд оролцдог олон улсын байгууллагууд болон тэдгээрийн гишүүд, ялангуяа Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ), Парисын клуб болон тэдгээрийн харьяа гишүүд (энэ хүрээнд тодруулахад, Парисын клубын оролцогчид болон ажиглагчид багтана).

9.3. Цаашлаад, ХБНГУ-ын хүсэлтээр СБЗБ-ны Төслийн болон түүний санхүүжилтийн талаарх сонгосон мэдээллийг Бүх үе шатанд дараах байгууллагуудтай хуваалцаж, тэдгээр байгууллагууд нь тухайн зорилгод хамаарах хэсгийг нийтэлнэ:

а. Олон улсын тусламжийн ил тод байдлын санаачилгын хүрээнд ХБНГУ (<https://www.bmz.de/en/ministry/facts-figures/project-and-organisation-data>);

б. Зах зээлийн мэдээллийн зорилгоор Германы Худалдаа, хөрөнгө оруулалтын агентлаг (<https://www.gtai.de/gtai-de/trade>);

в. Хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд санхүүгийн урсгалыг тайлагнах зорилгоор ЭЗХАХБ (<https://data-explorer.oecd.org/>);

г. Германы хөгжлийн хамгийн ажиллагааг бүхэлд нь үнэлэх, ил тод байлгах, үр ашгийг хангах зорилгоор Германы Хөгжлийн хамтын ажиллагааны үнэлгээний хүрээлэн (<http://www.deval.org/de/>).

9.4. СБЗБ нь өөрийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс Төслийн болон түүний санхүүжилтийн талаарх мэдээллийг Бүх үе шатанд гуравдагч этгээдэд шилжүүлэх (нийтлэх зорилгоор шилжүүлэхийг ч багтаана) эрхээ өөртөө хадгална.



Тухайн мэдээлэл нь Зээлдэгч эсвэл төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ашиг сонирхолд нийцэхгүй байгаа бол, мөн СБЗБ-ны мэдээлэл дамжуулах сонирхлоос давсан гэж үзвэл СБЗБ нь түүнийг гуравдагч этгээдэд дамжуулахгүй. Зээлдэгч болон Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хууль ёсны ашиг сонирхолд харшлах, ялангуяа 9.1 дүгээр зүйлд заасан нийтлэгдэхээс хасагдсан чухал мэдээллийн нууцлалыг хамгаалах шаардлагатай бөгөөд ийм ангилалд орсон мэдээллийг нийтлэхгүй.

Мөн СБЗБ нь хууль эрх зүйн зохицуулалтад заасан шаардлагын дагуу эсхүл шүүхийн болон захиргааны ажиллагаанд нэхэмжлэл гаргах, өөрийгөө хамгаалах болон бусад эрхээ эдлэхийн тулд шаардлагатай тохиолдолд аливаа мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах эрх эдэлнэ.

10. Бусад заалтууд

- 10.1. Зээлдэгч нь 1а хавсралт (“Зээлдэгчийн дагаж мөрдөх үүргүүд”)-д заасан үүргүүдийг биелүүлж дагаж мөрдөх бол Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь 1б хавсралт (“Төсөл хэрэгжүүлэгчийн дагаж мөрдөх үүргүүд”)-д заасан үүргүүдийг дагаж мөрдөж биелүүлнэ.
- 10.2. Энэхүү Гэрээний ямар нэг заалт хүчингүй болсон тохиолдолд, бусад заалтууд хүчинтэй хэвээр үлдэнэ. Тухайн заалт хүчингүй болсноос үүсэх орон зайг энэхүү Гэрээний зорилгод нийцсэн заалтаар нөхөн зохицуулна.
- 10.3. Зээлдэгч болон Төсөл хэрэгжүүлэгч нь энэхүү Гэрээний дагуу үүсэх аливаа эрх ба нэхэмжлэлийн эрхээ бусдад шилжүүлэх, дамжуулах, барьцаалах эсвэл үл хөдлөх хөрөнгийн барьцаанд тавихыг хориглоно.
- 10.4. СБЗБ нь шаардах эрх үүссэнийг мэдсэн буюу мэдэх боломжтой байсан тохиолдолд энэ эрхээ хэрэгжүүлээгүй бол хөөн хэлэлцэх хугацаа таван жил байна.
- 10.5. Энэхүү Зээлийн гэрээ нь ХБНГУ-ын хууль тогтоомжийг удирдлага болгоно. Удирдан гүйцэтгэх газар нь Франкфурт ам Майн хот байна.
- 10.6. Энэхүү Гэрээнээс үүсэх эсхүл Гэрээтэй холбоотой аливаа маргааныг зөвхөн арбитрын шүүхээр эцэслэн шийдвэрлэнэ. Үүнтэй холбоотой дараах заалтууд үйлчилнэ:

а. Арбитрын шүүх нь нэг эсвэл гурван томилогдсон арбитрчаас бүрдэх бөгөөд тэднийг тухайн үед Олон улсын худалдааны танхимын арбитрын дүрмийн дагуу томилж, тэд үйл ажиллагаагаа дээрх дүрмийн дагуу явуулна.

б. Арбитрын ажиллагаа нь Франкфурт ам Майн хотод явагдана. Арбитрын ажиллагаа англи хэлээр хийгдэнэ.



Энэхүү гэрээг Англи хэлээр гурван хувь үйлдэв.

Франкфурт ам Майн,

Улаанбаатар,

огноо

огноо

СБЗБ

Монгол Улсыг төлөөлж

Монгол Улсын Сангийн Яам

Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ

Төрийн Өмчит Хувьцаат Компани

Хавсралтууд

Хавсралт 1а: Зээлдэгчийн дагаж мөрдөх гэрээний нөхцөлүүд

Хавсралт 1б: Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын дагаж мөрдөх үүрэг

Хавсралт 2: Зээлдэгчийн хууль зүйн зөвлөхийн гаргах хууль зүйн
дүгнэлтийн маягт

Хавсралт 1а: Зээлдэгчийн дагаж мөрдөх гэрээний нөхцөлүүд

1. ТОДОРХОЙЛОЛТ

Албадлагын арга: хүний хийх үйлдэлд буруу аргаар нөлөөлөх зорилгоор тухайн хүнийг эсвэл түүний өмч хөрөнгийг шууд болон шууд бусаар гэмтээх, хохироох эсхүл гэмтээхээр сүрдүүлэн заналхийлэх.

Хуйвалдах үйлдэл: хоёр ба түүнээс дээш этгээд хоорондоо хэлэлцэн тохиролцож, өөр бусад хүний аливаа үйлдэлд зохисгүйгээр нөлөөлөх.

Авлигын үйлдэл: аливаа хууль бус төлбөр эсвэл ямар нэгэн шударга бус давуу талыг шууд болон шууд бусаар амлах, санал болгох, өгөх, шаардах, авах, хүлээн авах буюу гуйх замаар хэн нэгний үйл ажиллагаанд нөлөөлөх эсвэл үйлдэл хийхгүй байлгах зорилготой аливаа үйлдэл.

Луйврын үйлдэл: санхүүгийн ашиг олох, эсвэл хүлээсэн үүргээсээ зайлсхийх зорилгоор хүнийг санаатай эсвэл хайхрамжгүйгээр төөрөгдүүлэх, эсвэл төөрөгдүүлэхийг завдах аливаа үйлдэл эсвэл үйлдэхээс зайлсхийсэн байдал, түүнчлэн худал мэдээлэл өгөх.

ЕХ-ны жагсаалт: Европын Комиссоос тодорхойлж, тухай бүр шинэчлэн баталдаг татварын хамтын ажиллагаанд үл нийцэгч харьяаллын бүсүүдийн ЕХ-ны жагсаалт бөгөөд холбогдох Хавсралт 1 болон Хавсралт 2-ыг багтаасан болно. (дэлгэрэнгүйг <https://www.consilium.europa.eu/de/policies/eu-list-of-non-cooperative-jurisdictions> хаягаас үзнэ үү). Хавсралт 1-д хамтран ажилладаггүй гэж ангилагдсан харьяалал, Хавсралт 2-т тодорхойлогдсон дутагдлаа арилгах талаар хангалттай үүрэг, амлалт авсан бөгөөд энэ үндэслэлээр одоогоор хамтран ажилладаггүй гэж тооцогдоогүй нэмэлт харьяалал (“Хавсралт 2-ын харьяалал” буюу “Үүрэг, амлалт авсан харьяалал”)-ыг тус тус тусгасан болно.

Саад учруулах үйлдэл: (i) авлигын үйлдэл, луйврын үйлдэл, албадлагын үйлдэл, хуйвалдааны үйлдэлтэй холбоотой албан ёсны мөрдөн шалгалтыг зориуд саатуулах зорилгоор мөрдөн шалгалтад хамаарах нотлох баримтыг санаатайгаар устгах, хуурамчаар үйлдэх, өөрчлөх, нуух, эсвэл мөрдөн шалгагчдад худал мэдүүлэг өгөх; эсвэл мөрдөн шалгалтад холбогдох мэдээ мэдээллээ үнэн зөвөөр нь өгөхөөс, мөрдөн шалгалтыг үргэлжлүүлэх явдалд саад учруулахын тулд хэн нэг хүнийг заналхийлэх, дарамтлах, айлган сүрдүүлэх, эсхүл (ii) авлигын үйлдэл, луйврын үйлдэл, албадлагын үйлдэл, хуйвалдааны үйлдэлтэй холбоотой албан ёсны мөрдөн шалгалтын явцад СБЗБ-ны гэрээгээр шаардагдсан мэдээлэлд хандах эрхийг бодитоор саатуулахад чиглэсэн аливаа үйлдэл.



Этгээд: аливаа хувь хүн, хуулийн этгээд, нөхөрлөл эсвэл эрх зүйн хувьд бүртгэлгүй холбоо.

Хориг арга хэмжээ авах үйлдэл: дээр тодорхойлсон албадлагын үйлдэл, хуйвалдааны үйлдэл, авлигын үйлдэл, луйврын үйлдэл, саад учруулах үйлдлийг үүнд багтааж ойлгоно. Үүнд: (i) Герман улсын хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хууль бус үйлдэл болох нь тогтоогдсон (ii) Зээлдэгч ба СБЗБ-ны хооронд байгуулсан энэхүү Гэрээ болон түүний хэрэгжилтэд бодитой буюу боломжит хууль эрх зүйн эсвэл нэр хүндийн нөлөөлөл үзүүлэхүйц байх тохиолдлуудыг хамруулж ойлгоно.

Хориг арга хэмжээ: Аливаа Хориг арга хэмжээ хэрэгжүүлэгч байгууллагаас хэрэгжүүлж, баталж, эсхүл мөрдүүлж буй эдийн засаг, санхүү, худалдааны (үүнд бараа, технологи, үйлчилгээ болон тэдгээртэй холбоотой санхүүгийн дэмжлэг багтана) хориг, хязгаарлалтын хууль тогтоомж, журам, хориг болон бусад хязгаарлалтын арга хэмжээ.

Хориг арга хэмжээ тогтоогч байгууллага: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл, Европын Холбоо болон ХБНГУ.

Хориг арга хэмжээний жагсаалт: Аливаа Хориг арга хэмжээ хэрэгжүүлэгч байгууллагаас гаргасан, хориг арга хэмжээнд хамрагдсан тусгайлан тодорхойлсон хувь хүн, бүлэг, эсхүл хуулийн этгээдийн жагсаалт.

Татвар төлөхөөс зайлсхийх үйлдэл: Татварын систем болон/эсхүл харьяаллын техникийн нарийн зохицуулалтыг ашиглах, эсхүл хоёр ба түүнээс дээш татварын систем болон/эсхүл харьяаллын хоорондын зөрүүг ашиглах замаар, бизнесийн бодит үндэслэлгүйгээр зөвхөн татварын үүргийг бууруулах зорилготой аливаа үйлдэл.

2. МЭДЭЭЛЛИЙН ҮҮРЭГ

Зээлдэгч дараах үүрэг хүлээнэ:

а. Зээлдэгчийн талаар СБЗБ-аас шаардсан холбогдох “харилцагчаа таньж мэдэх” (KYC) болон түүнтэй адилтгах бүх мэдээллийг KfW-ийн хүсэлтээр шуурхай гаргаж өгөх;

б. СБЗБ-ны шаардлагын дагуу, Төслийг хэрэгжүүлэгч байгууллага болон түүний гэрээт, туслан гүйцэтгэгч байгууллага болон бусад холбогдох талуудын төсөлтэй холбоотой бүх мэдээлэл, баримт бичгийг нэн даруй гаргаж өгнө. Эдгээр мэдээлэл нь СБЗБ нь хориг арга хэмжээ авах үндэслэл

бүхий үйлдэл, мөнгө угаах болон/эсхүл терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үүргээ хэрэгжүүлэх, түүнчлэн энэ зорилгоор Зээлдэгчтэй тогтоосон бизнесийн харилцаанд тасралтгүй хяналт тавихад шаардлагатай мэдээлэл багтана;

в. Төсөл хэрэгжүүлэх явцад аливаа хориг арга хэмжээ авах үйлдэл, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой аливаа баримт нотолгоо олдсон, эсвэл сэжигтэй үйлдэл илэрсэн даруйд өөрийн санаачилгаар, ямар нэг саадгүйгээр нэн даруй СБЗБ-д мэдээлэх;

г. СБЗБ-аас шаардсан тохиолдолд Төслийн болон түүний цаашдын явцтай холбоотой аливаа мэдээлэл, тайланг гаргаж өгөх;

д. Энэхүү хавсралтын зорилгоор СБЗБ болон түүний төлөөлөгчдөд аль ч үед Зээлдэгч болон түүний гэрээт болон туслан гүйцэтгэгч байгууллага холбогдох бусад талуудын Төслийн хүрээтэй холбоотой бүх баримт бичгийг шалгах, мөн Төсөл болон түүнтэй холбоотой бүх байгууламжид очиж үзлэг хийх боломжийг бүрдүүлнэ;

е. Зээлдэгч нь СБЗБ-аас олгосон хөрөнгийг Европын Холбооны Хавсралт 1-д багтсан хамтын ажиллагаагүй улс, нутаг дэвсгэрт байрладаг болон/эсхүл бүртгэлтэй (дэд) гэрээт гүйцэтгэгчид болон/эсвэл холбогдох бусад талуудад хуваарилахаар төлөвлөж байгаа тохиолдолд энэ талаар СБЗБ-д өөрийн санаачилгаар шуурхай мэдэгдэх;

ё. Төсөлтэй холбоотой аливаа татвараас зайлсхийх үйл ажиллагаа илэрсэн, эсхүл тийм байж болзошгүй талаар мэдсэн даруйд СБЗБ-д өөрийн санаачилгаар шуурхай мэдэгдэх.

3. ТӨЛӨӨЛӨЛ БА БАТАЛГАА

3.1 ХБНГУ-ын хууль тогтоомж болон Зээлдэгчийн улсын хууль тогтоомжийн хүрээнд, Зээлдэгч нь төслийн холбогдолтойгоор өөрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй аливаа этгээд нь шийтгэл ногдуулахуйц үйлдэл, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, татвараас зайлсхийх аливаа үйлдэл хийж байгаагүй, мөн одоо тийм үйл ажиллагаанд оролцоогүй гэдгийг төлөөлж, баталгаа гаргаж өгнө.

3.2 Энэхүү зүйлд заасан төлөөлөл болон баталгааг Гэрээ байгуулах үед анх удаа гаргаж өгсөнд тооцно. Мөн Зээлийн аливаа татан авалт хийх бүрд болон хүүгийн төлбөрийн өдөр бүрд тухайн үеийн нөхцөл байдалд нийцүүлэн дахин гаргаж өгсөнд тооцогдоно.



4. ЭЕРЭГ ҮҮРЭГ

Зээлдэгч нь хориг арга хэмжээ авах үйлдэл, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйлдэл эсхүл аливаа татвараас зайлсхийх үйл ажиллагааны талаар өөрөө болон СБЗБ мэдсэн, эсхүл сэжиглэсэн даруйд тухайн нийцлийн зөрчил гарсан эсэхийг тогтоох зорилгоор СБЗБ болон түүний төлөөлөгчидтэй бүрэн хамтран ажиллах үүрэг хүлээнэ. Тодруулбал, Зээлдэгч нь СБЗБ-аас ирүүлсэн аливаа мэдэгдэлд нэн даруй, үндэслэлтэй дэлгэрэнгүй байдлаар хариу өгөх бөгөөд СБЗБ-ны хүсэлтийн дагуу уг хариуг нотлох баримтаар баталгаажуулан ирүүлнэ.

5. СӨРӨГ ҮҮРЭГ

Зээлдэгч дараах үүргийг хүлээнэ:

- а. Төсөл хэрэгжүүлэх явцдаа өөрийн үйл ажиллагаандаа хориг арга хэмжээ авах үйлдэл, мөнгө угаах эсхүл терроризмыг санхүүжүүлэх аливаа үйлдэл гарах нөхцөл байдлыг үүсгэхгүй байх;
- б. Төсөл хэрэгжүүлэх явцдаа хориг арга хэмжээний зөрчилд тооцогдох аливаа хэлцэлд орохгүй байх, мөн шууд болон шууд бусаар бусад ийм үйл ажиллагаанд оролцохгүй байх;
- в. СБЗБ-ны зөвшөөрөлгүйгээр СБЗБ-аас олгосон зээлийг ЕХ-ны жагсаалтын Хавсралт 1-д багтсан харьяалалд байрлаж буй эсхүл тэнд бүртгэгдсэн аливаа этгээдэд хуваарилахгүй байх, мөн татвараас зайлсхийх үйлдэлд тооцогдох аливаа өөр үйл ажиллагаа явуулахгүй байх.

Хавсралт 16: Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын дагаж мөрдөх үүрэг

1. ТОДОРХОЙЛОЛТ

Албадлагын арга: хүний хийх үйлдэлд буруу аргаар нөлөөлөх зорилгоор тухайн хүнийг эсвэл түүний өмч хөрөнгийг шууд болон шууд бусаар гэмтээх, хохироох эсхүл гэмтээхээр сүрдүүлэн заналхийлэх.

Хуйвалдах үйлдэл: хоёр ба түүнээс дээш этгээд хоорондоо хэлэлцэн тохиролцож, өөр бусад хүний аливаа үйлдэлд зохисгүйгээр нөлөөлөх.

Авлигын үйлдэл: аливаа хууль бус төлбөр эсвэл ямар нэгэн шударга бус давуу талыг шууд болон шууд бусаар амлах, санал болгох, өгөх, шаардах, авах, хүлээн авах буюу гуйх замаар хэн нэгний үйл ажиллагаанд нөлөөлөх эсвэл үйлдэл хийхгүй байлгах зорилготой аливаа үйлдэл.

Гэмт хэргийн тодорхойлсон ангиллууд: Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээний ажлын хэсгийн зөвлөмж болон түүнд холбогдох тайлбар тэмдэглэлд заасан дараах гэмт хэргийн ангиллыг хэлнэ. Үүнд: зохион байгуулалттай гэмт бүлэглэлд оролцох; дарамт шахалт үзүүлэх; терроризмын үйл ажиллагаа явуулах, түүний дотор терроризмыг санхүүжүүлэх; хүн худалдаалах болон хууль бус цагаач тээвэрлэх; бэлгийн мөлжлөг, түүний дотор хүүхдийн бэлгийн мөлжлөг үйлдэх; хар тамхи болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус наймаа хийх; зэвсгийн хууль бус наймаа хийх; хулгайлагдсан болон бусад барааны хууль бус наймаа хийх; авлига болон хээл хахуульд оролцох; луйвар хийх; мөнгө хуурамчаар үйлдэх; бараа бүтээгдэхүүнийг хуурамчаар үйлдэх болон хулгайлан хувилах; байгаль орчны гэмт хэрэг үйлдэх; аллага үйлдэх, ноцтой гэмтэл учруулах; хүн хулгайлах, хууль бусаар хорих болон барьцаалах; дээрэм болон хулгай хийх; хууль бус наймаа (гааль, онцгой албан татвар болон бусад татвартай холбоотой) хийх; татварын гэмт хэрэг (шууд болон шууд бус татвартай холбоотой) үйлдэх; айлган сүрдүүлэх замаар мөнгө авах; баримт бичиг хуурамчаар үйлдэх; далайн дээрэм хийх; дотоодын арилжаа болон зах зээлийг зохиомлоор хөдөлгөх.

ЕХ-ны жагсаалт: энэ нь ЕХ-ны комиссоос тодорхойлж, цаг тухайд нь шинэчилж байдаг хамтран ажилладаггүй татварын харьяаллын жагсаалт бөгөөд үүнд 1 ба 2 дугаар хавсралт орно (дэлгэрэнгүйг <https://www.consilium.europa.eu/de/policies/eu-list-of-non-cooperative-jurisdictions> хаягаас үзнэ үү). Хавсралт 1-д хамтран ажилладаггүй гэж ангилсан харьяаллууд ордог. Харин Хавсралт 2-т ("Хавсралт 2-ын харьяалал" эсвэл "Амлалт өгсөн харьяалал") нь илэрсэн дутагдлаа засах хангалттай амлалт өгсөн боловч одоогоор хамтран ажилладаггүй гэж тооцоогүй харьяаллууд ордог.



Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээний ажлын хэсгийн зөвлөмжүүд: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний болон олон улсын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхийг дэмжих зорилготой Засгийн газар хоорондын байгууллага болох Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээний ажлын хэсгээс цаг хугацааны явцад тодорхойлж, шинэчилж байдаг зөвлөмжүүдийг хэлнэ.

Луйврын үйлдэл: санхүүгийн ашиг олох, эсвэл хүлээсэн үүргээсээ зайлсхийх зорилгоор хүнийг санаатай эсвэл хайхрамжгүйгээр төөрөгдүүлэх, эсвэл төөрөгдүүлэхийг завдах аливаа үйлдэл эсвэл үйлдэхээс зайлсхийсэн байдал, түүнчлэн худал мэдээлэл өгөх.

Хууль бус эх үүсвэр: Дараах эх үүсвэрээс бий болсон санхүүгийн эх үүсвэрийг хэлнэ. Үүнд:

а. Гэмт хэргийн ангиллуудад багтсан аливаа гэмт хэрэг;

б. Авлигын үйлдэл;

в. Луйврын үйлдэл;

г. Мөнгө угаах үйлдэл.

Саад учруулах үйлдэл: (i) авлигын үйлдэл, луйврын үйлдэл, албадлагын үйлдэл, хуйвалдааны үйлдэлтэй холбоотой албан ёсны мөрдөн шалгалтыг зориуд саатуулах зорилгоор мөрдөн шалгалтад хамаарах нотлох баримтыг санаатайгаар устгах, хуурамчаар үйлдэх, өөрчлөх, нуух, эсвэл мөрдөн шалгагчдад худал мэдүүлэг өгөх; эсвэл мөрдөн шалгалтад холбогдох мэдээ мэдээллээ үнэн зөвөөр нь өгөхөөс, мөрдөн шалгалтыг үргэлжлүүлэх явдалд саад учруулахын тулд хэн нэг хүнийг заналхийлэх, дарамтлах, айлган сүрдүүлэх, эсвэл (ii) авлигын үйлдэл, луйврын үйлдэл, албадлагын үйлдэл, хуйвалдааны үйлдэлтэй холбоотой албан ёсны мөрдөн шалгалтын явцад СБЗБ-ны гэрээгээр шаардагдсан мэдээлэлд хандах эрхийг бодитоор саатуулахад чиглэсэн аливаа үйлдэл.

Этгээд: аливаа хувь хүн, хуулийн этгээд, нөхөрлөл эсвэл эрх зүйн хувьд бүртгэлгүй холбоо.

Хориг арга хэмжээ авах үйлдэл: дээр тодорхойлсон албадлагын үйлдэл, хуйвалдааны үйлдэл, авлигын үйлдэл, луйврын үйлдэл, саад учруулах үйлдлийг үүнд багтааж ойлгоно. Үүнд: (i) Герман Улсын хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хууль бус үйлдэл болох нь тогтоогдсон (ii) Зээлдэгч ба СБЗБ хооронд байгуулсан энэхүү Гэрээ болон түүний

хэрэгжилтэд бодитой буюу боломжит хууль эрх зүйн эсвэл нэр хүндийн нөлөөлөл үзүүлэхүйц байх тохиолдлуудыг хамруулж ойлгоно.

Хориг арга хэмжээ: эдийн засаг, санхүү болон худалдааны (бараа, технологи, үйлчилгээ болон түүнтэй холбогдох санхүүгийн тусламж) хориг арга хэмжээний тухай хууль, журам, хорио цээр эсвэл хязгаарлалтын арга хэмжээг ямар нэгэн хориг арга хэмжээ тогтоогч байгууллагаас хэрэгжүүлсэн, баталсан эсвэл хэрэгжүүлж буй тохиолдолд.

Хориг арга хэмжээ тогтоогч байгууллага: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл, Европын Холбоо болон ХБНГУ.

Хориг арга хэмжээний жагсаалт: Хориг арга хэмжээнд орсон болохыг тусгайлан нэрлэсэн хувь хүн, бүлэг эсвэл хуулийн этгээдийн жагсаалтыг үүнд багтааж ойлгоно. Энэхүү жагсаалтыг Хориг арга хэмжээ тогтоогч байгууллагаас гаргана.

Татвар төлөхөөс зайлсхийх үйлдэл: татварын тогтолцооны болон түүнд хамаарах нарийн зохицуулалт, эсвэл хоёр ба түүнээс дээш орны татварын тогтолцоо болон/эсвэл харьяаллын зөрүүг ашиглан, зөвхөн татварын үүргээ бууруулах зорилгоор бизнесийн бодит үндэслэлгүйгээр хийгдсэн аливаа үйлдэл.

2. МЭДЭЭЛЛИЙН ҮҮРЭГ

Төсөл хэрэгжүүлэгч дараах үүрэг хүлээнэ:

- а. СБЗБ-ны шаардлагын дагуу Төслийг хэрэгжүүлэгч байгууллага болон түүний (шууд болон/эсхүл шууд бус) хувьцаа эзэмшигчид, охин болон хараат компаниуд, түүнчлэн бусад холбогдох этгээдийн талаарх “харилцагчаа таних” баримт болон түүнтэй адилтгах холбогдох бүх мэдээллийг нэн даруй гаргаж өгнө;
- б. СБЗБ-ны шаардлагын дагуу, Төслийг хэрэгжүүлэгч байгууллага болон түүний гэрээт, туслан гүйцэтгэгч байгууллага болон бусад холбогдох талуудын төсөлтэй холбоотой бүх мэдээлэл, баримт бичгийг нэн даруй гаргаж өгнө. Эдгээр мэдээлэл нь СБЗБ нь хориг арга хэмжээ авах үндэслэл бүхий үйлдэл, мөнгө угаах болон/эсхүл терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үүргээ хэрэгжүүлэх, түүнчлэн энэ зорилгоор Зээлдэгчтэй тогтоосон бизнесийн харилцаанд тасралтгүй хяналт тавихад шаардлагатай мэдээлэл багтана;
- в. Төсөл хэрэгжүүлэх явцад аливаа хориг арга хэмжээ авах үйлдэл, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой аливаа баримт



- нотолгоо олдсон, эсвэл сэжигтэй үйлдэл илэрсэн даруйд өөрийн санаачилгаар, ямар нэг саадгүйгээр нэн даруй СБЗБ-д мэдээлэх;
- г. СБЗБ-аас шаардсан тохиолдолд Төслийн болон түүний цаашдын явцтай холбоотой аливаа мэдээлэл, тайланг гаргаж өгөх;
- д. Энэхүү хавсралтын зорилгоор СБЗБ болон түүний төлөөлөгчдөд аль ч үед Зээлдэгч болон түүний гэрээт болон туслан гүйцэтгэгч байгууллага холбогдох бусад талуудын Төслийн хүрээтэй холбоотой бүх баримт бичгийг шалгах, мөн Төсөл болон түүнтэй холбоотой бүх байгууламжид очиж үзлэг хийх боломжийг бүрдүүлнэ;
- е. Төслийг хэрэгжүүлэгч байгууллага, түүний удирдлагын болон бусад эрх бүхий байгууллагын аливаа гишүүн, эсхүл хувьцаа эзэмшигч нь аливаа хориг арга хэмжээний жагсаалтад багтсан тусгайлан тодорхойлогдсон этгээд, хориглосон этгээд буюу байгууллага болох, эсхүл тийм ангилалд шинээр багтах нөхцөл байдал үүссэн аливаа тохиолдлын талаар мэдсэн даруйдаа өөрийн санаачилгаар СБЗБ-д нэн даруй мэдэгдэнэ.
- ё. Төслийг хэрэгжүүлэгч байгууллага нь СБЗБ-аас олгосон хөрөнгийг ЕХ-ны жагсаалтын Хавсралт 1-д багтсан татварын хамтын ажиллагаанд үл нийцэгч харьяаллын бүсэд байрладаг болон/эсхүл бүртгэлтэй туслан гүйцэтгэгч байгууллага болон/эсхүл холбогдох бусад этгээдэд хуваарилах гэж байгаа тохиолдолд энэ талаар өөрийн санаачилгаар СБЗБ-д нэн даруй мэдэгдэнэ.
- ж. Төслийг хэрэгжүүлэгч байгууллага, түүний удирдлагын болон бусад эрх бүхий байгууллагын аливаа гишүүн, эсхүл хувьцаа эзэмшигчдийн зүгээс татвараас зайлсхийх аливаа үйл ажиллагаа гарсан, эсхүл гарсан байж болзошгүй талаар мэдсэн даруйдаа эсхүл сэжиглэсэн тохиолдолд өөрийн санаачилгаар СБЗБ-д нэн даруй мэдэгдэнэ.

3. ТӨЛӨӨЛӨЛ БА БАТАЛГАА

3.1 ХБНГУ-ын хууль болон Төслийн хэрэгжүүлэгч байгууллага үүсгэн байгуулагдсан улсын хуулийн хүрээнд, Төслийн хэрэгжүүлэгч байгууллага дараах зүйлс үнэн зөв болохыг төлөөлж баталгааг гаргаж өгнө:

а. Энэхүү Гэрээг байгуулах, хэрэгжүүлэхдээ Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь өөрийн нэрийн өмнөөс, өөрийн ашиг сонирхлоор үйлдэнэ.

б. Өөрийн мэдэж буй хэмжээнд, мөн зөвхөн хөрөнгийн зах зээлийн дүрмийн дагуу Төсөл хэрэгжүүлэгчид мэдэгдэж байгаа хувьцаа эзэмшигчидтэй холбоотой хүрээнд, Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хөрөнгө болон Төслийн хөрөнгө оруулалт нь хууль бус эх үүсвэрээс гараагүй.



в. Төсөл хэрэгжүүлэгч, түүний охин компани, хамааралтай компаниуд, эсхүл тэдгээрийн өмнөөс ажиллаж буй аливаа этгээд нь шийтгэл ногдуулахуйц үйлдэл гаргаагүй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх аливаа үйл ажиллагаа явуулаагүй, одоо ч ийм үйл ажиллагаанд оролцоогүй.

г. Төсөл хэрэгжүүлэгч нь (i) хориг арга хэмжээний жагсаалтад тусгайлан нэрлэгдсэн иргэн, хориглогдсон этгээд болон байгууллагатай бизнесийн харилцаанд ороогүй; мөн (ii) хориг арга хэмжээний зөрчилд тооцогдох аливаа өөр үйл ажиллагаа явуулаагүй.

д. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь татвараас зайлсхийх үйлдэлд тооцогдох аливаа үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд одоо ч ийм үйл ажиллагаанд оролцоогүй.

3.2 Энэхүү зүйлд заасан төлөөлөл болон баталгааг Гэрээ байгуулах үед анх удаа гаргаж өгсөнд тооцно. Мөн Зээлийн аливаа татан авалт хийх бүрд болон хүүгийн төлбөрийн өдөр бүрд тухайн үеийн нөхцөл байдалд нийцүүлэн дахин гаргаж өгсөнд тооцогдоно.

4. ЗЭРЭГ ҮҮРЭГ

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь дараах үүргийг хүлээнэ:

а. Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээний ажлын хэсгийн Зөвлөмжид нийцүүлэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандартыг бүрэн дагаж мөрдөх, мөн өөрийн дотоод стандарт, журам (үйлчлүүлэгчийг таньж мэдэхтэй холбоотой арга хэмжээ зэргийг хязгаарлалтгүйгээр хамруулна)-ыг хэрэгжүүлэх, сахин биелүүлэх, шаардлагатай тохиолдолд сайжруулж, ингэснээр шийтгэл ногдуулахуйц үйлдэл, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эсхүл татвараас зайлсхийх үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх;

б. Төсөл хэрэгжүүлэгч эсхүл СБЗБ-ны хориг арга хэмжээ авах үйлдэл, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эсхүл татвараас зайлсхийх үйлдлийн талаар мэдсэн буюу ийм үйлдэл байж болзошгүй гэж сэжиглэсэн даруйд, тухайн зөрчил гарсан эсэхийг тогтооход СБЗБ-ны болон түүний төлөөлөгчидтэй бүрэн хамтран ажиллах болон тодруулбал төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь СБЗБ-аас ирүүлсэн аливаа мэдэгдэлд нэн даруй дэлгэрэнгүй хариу өгөх бөгөөд шаардсан тохиолдолд уг хариултаа нотлох баримтаар хангана.



5. СӨРӨГ ҮҮРЭГ

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь дараах үүргийг хүлээнэ:

а. Өөрийн хөрөнгө болон төслийн хэрэгжилтэд оруулах бусад хөрөнгө нь хууль бус эх үүсвэртэй биш байх нөхцөлийг хангах;

б. Өөрийн бизнесийн үйл ажиллагаа нь хориг арга хэмжээ авах үйлдэл, мөнгө угаах эсхүл терроризмыг санхүүжүүлэх аливаа үйлдэлд хүргэхгүй байхыг хангах;

в. Хориг арга хэмжээний жагсаалтад тусгайлан нэрлэгдсэн иргэн, хориглогдсон этгээд, эсхүл байгууллагатай бизнесийн харилцаанд орохгүй, мөн ийм харилцааг үргэлжлүүлэхгүй байх, түүнчлэн хориг арга хэмжээний зөрчилд тооцогдох бусад аливаа үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцохгүй байх;

г. СБЗБ-ны урьдчилсан зөвшөөрөлгүйгээр СБЗБ-аас олгосон хөрөнгийг ЕХ-ны жагсаалтын Хавсралт 1-д багтсан харьяалалд байрлаж буй эсхүл тэнд бүртгэгдсэн аливаа этгээдэд хуваарилахгүй байх, мөн татвараас зайлсхийх үйлдэлд тооцогдох аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх.



Хавсралт 2

**Хавсралт 2: Зээлдэгчийн хууль зүйн зөвлөхийн гаргах хууль зүйн
дүгнэлтийн маягт**

Тэмдэглэл: “Холбооны Бүгд Найрамдах Улс”/ “Улс” хэсгийг зөв бөглөнө үү!

[Хуулийн зөвлөхийн албан бланк]

СБЗБ _____

Газар [_____]

[_____] (огноо)

Анхааралд: [_____]

Palmengartenstrasse 5 - 9

Postfach 11 11 41

60325 Frankfurt am Main/Germany

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

_____-ны өдөр СБЗБ болон _____ (“Зээлдэгч”)-ийн
хоорондын байгуулсан [_____ евро]-ийн хэмжээний зээлийн
гэрээг байгуулав.

Эрхэм хүндэт.....,

Би [улсын нэр]-ийн _____ Улсын [Хууль зүйн сайд] [хууль
зүйн зөвлөх] _____-ийн (аль яам эсхүл бусад эрх бүхий
байгууллагын нэрийг бөглөнө) хуулийн хэлтсийн дарга] байна. Би энэ
чиг үүргээр, [огноо]-нд байгуулагдсан Зээлдэгч болон Танай хооронд
хийгдсэн, Танай байгууллагын зүгээс Зээлдэгчид олгохоор болсон
нийтдээ EUR _____ 000.000,---оос хэтрэхгүй хэмжээний хөрөнгө
оруулалтад шаардлагатай зээлийн гэрээг нягталж ажилласан болно.



1. Шалгасан бичиг баримтууд

Би дараах бичиг баримтуудыг хянан шалгав:

1.1 Гарын үсэг зурж баталгаажуулсан гэрээний эх хувь;

1.2 Зээлдэгчийн үндсэн бичиг баримтууд, тэр дундаа:

(а) [] Улсын Үндсэн хууль, []-ны өдөр батлагдсан, []-д [], []-т зохих ёсоор нийтлэгдсэн, нэмэлт, өөрчлөлт орсон;

(б) [] Улсын зээллэгтэй холбоотой (*жишээлбэл, Төсвийн тухай хууль зэрэг*) хууль тогтоомж (*хэрэв байгаа бол энд оруулна*), №[], []-ны өдөр батлагдсан, []-д [], []-т зохих ёсоор нийтлэгдсэн, нэмэлт, өөрчлөлт орсон;

(в) [*Энд тухайн улсын Засгийн газар эсхүл захиргааны байгууллагуудаас зээл авахтай холбоотойгоор, ерөнхий эсвэл уг Зээлийн гэрээтэй холбогдуулан гаргасан тогтоол, захирамж зэрэг бусад баримт бичгийг дурдаж оруулна уу.*];

(г) (хэрэв хамааралтай бол) [] Улсын Засгийн газар болон Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газрын хооронд []-ны өдөр байгуулагдсан Санхүүгийн хамтын ажиллагааны гэрээ (“Засгийн газар хоорондын гэрээ”).

Мөн шаардлагатай гэж үзсэн бусад хууль, журам, баримт бичгүүдийг шалгасан болно. Үүнээс гадна энэхүү дүгнэлтийг гаргах зорилгоор шаардлагатай эсвэл зохистой гэж үзсэн бусад судалгааг хийсэн болно.

2. Дүгнэлт

Зээлийн гэрээний дугаар зүйлийн дагуу, энэхүү өдрийн байдлаар Улсын хууль тогтоомжийн хүрээнд миний гаргаж буй дүгнэлт нь дараах байдалтай байна:

2.1 “[Үндсэн хуулийн [] дугаар зүйл] / [] тухай хуулийн [] дугаар зүйл]-ийн дагуу, Зээлдэгч нь Зээлийн гэрээ байгуулах эрхтэй бөгөөд уг Зээлийн гэрээг байгуулах, гарын үсэг зурах, хүргүүлэх болон хэрэгжүүлэхийг зөвшөөрөх шаардлагатай бүх арга хэмжээг авсан байна. Тухайлбал, дараах байдлаар:

(а) [] Улсын парламентын [он, сар, өдөр]-ний өдрийн [] дугаар хуулиар Зээлийн гэрээг соёрхон баталсан / Зээлдэгчийн зүгээс Зээлийн гэрээнд гарын үсэг зурах, хүргүүлэх, хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн [энд тохирох хувилбарыг оруулна];

(б) []-ний өдрийн [] дугаар тогтоолоор [Засгийн газар / Төрийн зээлийн хороо / тухайн улсын холбогдох засгийн эсхүл захиргааны байгууллагын нэрийг оруулна];

(в) [] [энд бусад тогтоол, шийдвэр зэргийг оруулна].

2.2 Хатагтай / Ноён [] (болон Хатагтай / Ноён [] нь []-ийн дагуу (жишээлбэл, албан тушаалынхаа дагуу хуулиар, [-ийн сайдын хувьд / -ийн хувьд], Засгийн газрын [] дугаар тогтоолоор) огноотой итгэмжлэлээр гэх мэт) Зээлдэгчийн нэрийн өмнөөс Зээлийн гэрээнд дангаар / хамтран гарын үсэг зурах бүрэн эрхтэй. Хатагтай / Ноён [] (болон Хатагтай / Ноён [])-ийн гарын үсэг зурсан Зээлийн гэрээ нь Зээлдэгчийн нэрийн өмнөөс зохих ёсоор хийгдсэн бөгөөд Зээлдэгчийн хууль ёсны үүрэг хариуцлагыг бүрдүүлж, түүний нөхцөлийн дагуу хуулиар хэрэгжих, албадан биелэгдэх хүчинтэй баримт бичиг болно.

[2.3 дугаар хэсгийн хувилбар 1: Хэрэв 2.1 ба 2.2 дугаар хэсэгт заасан баримт бичгүүдээс гадна тухайн улсын хуулиар нэмэлт албан ёсны зөвшөөрөл авах шаардлагатай бол ашиглана]

2.3 Зээлдэгчийн зүгээс Зээлийн гэрээнд гарын үсэг зурах болон хэрэгжүүлэх (үүнд, хязгаарлалтгүйгээр, уг гэрээнд заасан валютын дагуу төлөх бүх төлбөрийг авч, СБЗБ-нд шилжүүлэх зэрэг орно)-тэй холбоотойгоор дараах албан ёсны зөвшөөрөл, эрх, тусгай зөвшөөрөл, бүртгэл болон/эсхүл зөвшөөрлүүдийг авсан бөгөөд эдгээр нь бүрэн хүчин төгөлдөр үйлчилж байна:



- (а) [] [Төв банк / Үндэсний банк /]-ийн [он, сар, өдөр]-ний өдрийн [] дугаар зөвшөөрөл;
- (б) [] [Сайд /]-яам-ын []-ний өдрийн [] дугаар зөвшөөрөл;
- (в) [] [бусад албан ёсны зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл болон/эсхүл зөвшөөрөл, зөвшөөрлийн жагсаалтыг энд оруулна].

Зээлдэгч нь Зээлийн гэрээг байгуулах, хэрэгжүүлэх (үүнд тухайн гэрээний дагуу төлбөлзөхөх бүх төлбөрийг гэрээнд заасан валютаар СБЗБ-д шилжүүлэхийг оролцуулан, үүгээр хязгаарлагдахгүй), мөн Зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргийн хүчин төгөлдөр байдал болон хэрэгжилтийг хангахтай холбогдуулан Бүгд Найрамдах Улсын аливаа төрийн байгууллага, агентлаг (үүнд Бүгд Найрамдах Улсын Төв/Үндэсний банкныг оролцуулан) эсхүл шүүхээс өөр ямар нэгэн албан ёсны зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, лиценз, бүртгэл болон/эсхүл батламж авах шаардлагагүй бөгөөд тийм зөвшөөрөл авах нь зүйтэй гэж үзэх нөхцөл мөн үүсээгүй болно.

[2.3 хувилбар 2: Хэрэв 2.1 ба 2.2-т заасан баримт бичгээс гадна нэмэлт албан ёсны зөвшөөрөл авах шаардлагагүй бол хэрэглэнэ]

2.4 Зээлдэгчийн зүгээс Зээлийн гэрээнд гарын үсэг зурах болон хэрэгжүүлэхтэй (үүнд, хязгаарлалтгүйгээр, гэрээнд заасан валютын дагуу төлбөрийг авч, KfW-д шилжүүлэх зэрэг орно) холбоотойгоор аливаа төрийн байгууллага эсхүл агентлаг (түүнчлэн [УЛС]-ын Төв/Үндэсний банк) эсхүл шүүхээс ямар нэгэн албан ёсны зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, тусгай зөвшөөрөл, бүртгэл шаардлагатай эсхүл зохистой гэж тооцогдохгүй. Мөн Зээлийн гэрээний хүчин төгөлдөр байдал болон хэрэгжилтэд холбогдохоор Зээлдэгчийн хүлээх үүргийг албадан биелүүлэхэд ийм зөвшөөрөл шаардагдахгүй.

2.5 Зээлийн гэрээний хүчин төгөлдөр байдал эсхүл хэрэгжилттэй холбогдуулан аливаа тамгын татвар эсхүл түүнтэй төстэй татвар, хураамж төлөх шаардлагагүй.

2.6 Зээлийн гэрээг Германы хуулиар зохицуулахаар сонгосон болон Зээлийн гэрээний [] дугаар зүйлд заасны дагуу арбитра

хандахаар зөвшөөрсөн нь хүчин төгөлдөр бөгөөд холбогдохуйц байна. Зээлдэгчийн эсрэг гаргасан арбитрын шийдвэрүүд нь [УЛС]-д хүлээн зөвшөөрөгдөж, албадан биелүүлэх боломжтой. Үүнд дараах дүрэм хамаарна: [_____] [тухайн улсын нэгдсэн гэрээ, жишээлбэл 1958 оны Нью-Йоркийн конвенц, эсхүл тухайн улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, албадан биелүүлэх үндсэн зарчмуудыг оруулна].

2.7 [_____] Улсын шүүхүүд нь Зээлийн гэрээнд заасан валют эсхүл валютуудаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй.

2.8 Зээлдэгчийн зээл авах, Зээлийн гэрээнд гарын үсэг зурах болон хэрэгжүүлэх нь хувийн болон арилжааны шинжтэй үйлдэл болохоос төрийн буюу олон нийтийн шинжтэй үйлдэл биш. Зээлдэгч болон түүний аливаа хөрөнгө нь арбитр, шүүхийн хэрэг, гүйцэтгэл, битүүмжлэл эсхүл бусад хууль ёсны ажиллагаанаас ангид дархан эрх эдлэхгүй.

2.9 Засгийн газрын гэрээ нь [УЛС]-ын Үндсэн хууль болон хуулийн дагуу бүрэн хүчин төгөлдөр байна. [Засгийн газрын гэрээний 3 дугаар зүйлд заасны дагуу] [Хэрэв Засгийн газрын гэрээ хүчин төгөлдөр болоогүй эсхүл Засгийн газрын гэрээ байгуулагдахаар төлөвлөгдөөгүй боловч Давхар татварын тухай гэрээ байгаа бол] [_____] [энд холбогдох гэрээ, хууль, журам зэргийг оруулна]. Ингэснээр Зээлдэгч нь Зээлийн гэрээний дагуу төлбөр хийхдээ ямар нэгэн суутгал, саатал хийх үүрэг хүлээхгүй бөгөөд хэрэв дараа нь ийм суутгал ногдуулсан тохиолдолд Зээлийн гэрээний [_____] дугаар зүйлд заасны дагуу Зээлдэгч нь СБЗБ-ны зохих ёсоор нөхөн төлөх үүрэгтэй.

2.10 Зээлийн гэрээнд гарын үсэг зурах, хэрэгжүүлэх эсхүл биелүүлэхтэй холбоотойгоор СБЗБ-г [УЛС]-д оршин суугч, хаягтай, бизнес эрхэлдэг гэж үзэхгүй бөгөөд татвар ногдуулах үндэслэл болохгүй. Мөн СБЗБ нь [_____] Улсад үйл ажиллагаа явуулахын тулд тусгай зөвшөөрөл авах, бүртгүүлэх, эсхүл төлөөлөгч томилох шаардлагагүй.

Иймд Зээлдэгчийн Зээлийн гэрээний дагуу хүлээх үүргүүд нь Зээлдэгчийн хувьд шууд, нөхцөлгүй, хууль ёсны, хүчин төгөлдөр, холбогдох бөгөөд тухайн гэрээний нөхцлийн дагуу албадан биелүүлэх боломжтой.



Энэхүү хууль зүйн дүгнэлт нь [] Улсын хуулиар хязгаарлагдана.

[] []
(Газар) (Огноо)

[Гарын үсэг]

Нэр: []

Тайлбар: Дээр дурдсан баримт бичгүүд болон хууль тогтоомжийн гэрчилгээжүүлсэн хуулбаруудыг хавсаргах (урт хуулиуд эсхүл Үндсэн хуулийн хувьд зөвхөн холбогдох зүйл, заалтыг хавсаргавал хангалттай). Мөн дээрх баримт бичгүүд англи эсхүл герман хэл дээр гаргагдаагүй бол, эсхүл СБЗБ өөрөөр зөвшөөрөөгүй бол, албан ёсны англи эсхүл герман орчуулгыг хавсаргана.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 15.75

Индекс: 200003

